КРЕДИТ
ББСБ

FPO

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2023

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 ... 5459567

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", түүнчлэн Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмын дагуу нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа нэмж санал болгон гаргаж байна.

Андеррайтер нь энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгасан зарим ирээдүйн болон одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан санхүүгийн болон санхүүгийн бус тоо мэдээ, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг өөрсдийн цуглуулсан баримт материал, арга зүй дээр үндэслэн үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлсэн бөгөөд ямар нэгэн мэдээллийг санаатайгаар орхигдуулаагүй болохыг албан ёсоор мэдэгдэж байна. Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь ирээдүйн тооцоолол, төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл, Хуулийн дүгнэлт, Хөндлөнгийн аудитын тайлан, мэдээ зэрэг баримт бичигт үндэслэн бэлтгэсэн.

**"ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР (ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ТА ӨӨРӨӨ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ХӨЛСЛӨН АВЧ) ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА."**

Үнэт цаас гаргагч нь өөрийн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гарган ирүүлсэн бөгөөд энэхүү үнэт цаасны танилцуулгын агуулга үнэн зөв болохыг баталгаажуулсан. Хөрөнгө оруулагч та шийдвэр гаргахдаа энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгаснаас илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Үнэт цаас гаргагч болон Андеррайтертай холбогдон тодруулах боломжтой.

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД

**Үндсэн Андеррайтер**

**Стандарт Инвестмент ҮЦК ХХК**

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Туул голын гудамж, Автохаб төв, 1-р давхар

**Утас:** +976 7011 4433

**Имэйл:** info@standardinvestment.mn

**Вэб хуудас:** www.standardinvestment.mn

**Туслах Андеррайтер**

**Ард Секюритиз ҮЦК ХХК**

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Цэнтрал тауэр, 13-р давхар, 1303 тоот

**Утас:** +976 7707 8282

**Имэйл:** info@ardsecurities.com

**Вэб хуудас:** www.ardsecurities.com

**Аудитын компани**

**Грант Торнтон Аудит ХХК**

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЭСКО гудамж-31, Далай тауэр, 9-р давхар

**Утас:** +976 7011 0744, +976 7011 0799

**Имэйл:** info@mn.gt.com

**Вэб хуудас:** www.grantthornton.mn

**Хуулийн фирм**

**Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН**

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн Гудамж, Ардчиллын өргөө, 6-р давхар

**Утас:** +976 7711 8193

**Имэйл:** info@snowhill.com

**Вэб хуудас:** www.snowhill.mn

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР

КРЕДИТ ББСБ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 9-ний өдөр № 2023/02 Улаанбаатар хот

Компаниас олон нийтэд энгийн хувьцаа нэмж гаргах болон энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.8 дахь заалт, 2023 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комисын Дугаар:01, Дугаар:02 тоот тогтоолуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор энгийн хувьцааны 30 хүртэлх хувь буюу 84,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбогдуулан хувьцааны тоо ширхэг, олон нийтэд нээлттэй арилжаалах өдөр, олон нийтэд санал болгох үнэ болон бусад холбогдох тогтоол шийдвэрийг тухай бүр гаргах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл-д олгосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНЗОРИГ

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагч, хөрөнгө оруулагч таны энэ өдрийн мэндийг хүргэе.

Ард Кредит ББСБ ХК 2011 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа банк бус санхүүгийн салбарыг тэргүүлэн, Монгол Улсын санхүүгийн салбарт онцгой хувь нэмрээ оруулсан олон төсөл, хөтөлбөр, бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, харилцагчидтайгаа хамт өсөж хөгжиж ирлээ. Бид эдийн засгийн тодорхойгүй бөгөөд хүндрэлтэй нөхцөлийг технологид оруулсан хөрөнгө оруулалт, менежментийн ур чадвар, харилцагчидтайгаа илүү ойр байж амжилттай даван тууллаа. Энэ онд эдийн засгийн сэргэлтийн салхи эргэж, Монгол улсын эдийн засаг хөгжих, дараагийн шатанд шилжих цаг үе ойртож буй төлөвтэй байна.

Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон I ангилалд орж ирсэн уламжлалтай бөгөөд жил бүр хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг, хувь тэнцүүлсэн урамшуулал олгож ололт амжилтаа хуваалцаж ирсэн билээ. Ард Кредит хувьцаагаа олон нийтэд санал болгосноос хойш 2018-2022 хүртэл 4 жилийн хугацаанд харилцагчийн тоогоо ойролцоогоор 1,000 дахин, нийт хөрөнгө болон зээлийн багцаа 5.5 дахин, цэвэр ашгаа 6.0 дахин тус тус өсгөсөн бахдам амжилттай ажиллаж байна. Жил бүр Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж өдгөө хамгийн олон хувьцаа эзэмшигч бүхий банк бус санхүүгийн байгууллага болж, Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй хувьцаат компаниудаас хувьцаа эзэмшигчийн тоогоор 8-р байранд жагсаж байна. 2022 оны туршид Ард Кредит ББСБ ХК-ийн 1.3 тэрбум төгрөгийн 10.0 сая ширхэг хувьцаа арилжаалагджээ.

2022 оны төгсгөлд Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авсан нь 2017 онд салбартаа анхлан кредит карт гаргаж байсантай адил салбартаа анхдагч карт гаргагч боллоо. Бид энэхүү кредит картыг зөвхөн өөрийн хөрөнгө оруулагч нартаа зориулж банктай өрсөлдөхүйц нөхцөлөөр санал болгож буйг дуулгахад таатай байна. Мөн онд Ард Кредит нь Монгол улсад анх удаа үйлдвэрлэгч, нийлүүлэгч, бизнес эрхлэгч, эцсийн хэрэглэгчийг холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний шинэ төрлийн санхүүжилтийн үйлчилгээ болох СКОПА төслийг хэрэгжүүлж, малчдад зориулан хөнгөлөлттэй зээл, харилцагч нартаа зориулан Pick n Pay хүүгүй, шимтгэлгүй худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн, Cupcake гүйлгээ бүрээсээ хуримтлал үүсгэх боломжтой бүрэн цахимжсан үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлэв. Бид технологи, мэдээллийн аюулгүй байдалдаа зориулан үлэмж хэмжээний хөрөнгө оруулалтыг тогтмол хийж хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи, системийг ашигладаг бөгөөд саяхан Мэдээллийн аюулгүй байдлын Олон Улсын ISO 27001:2013 стандартыг нэвтрүүлснийг дуулгахад баяртай байна.

Ард Кредит ББСБ ХК нь компанийн 2023-2025 оны буюу дунд хугацааны зорилтыг шинэчлэн боловсруулж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ харилцагчид, олон нийтэд илүү хүртээмжтэй үзүүлэх зорилгоор биет болон технологийн хосолмол PHYGITAL (Physical & Digital) хэлбэрийг хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ стратеги төлөвлөгөөний хүрээнд нэмэлт 84 сая ширхэг хувьцааг хөрөнгө оруулагчдадаа санал болгож байна.

Эрхэм таныг Монголын санхүүгийн салбарыг түүчээлэгч, хамгийн олон хувьцаа эзэмшигч бүхий ББСБ-ын ирээдүйн хөгжил, дэвшлийн нэг хэсэг болж, үр өгөөжийг хүртэн, бидэнтэй мөр зэрэгцэн алхахыг урьж байна.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал Г. Тэлмэн

## АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 2
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД 3
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР 4
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ 5
АГУУЛГА 6
ХҮСНЭГТ 9
ГРАФИК 10
ЗУРАГ 11
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР 12
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 13
ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА 14
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 16
1.1. Ард Кредитын товч танилцуулга 16
1.2. Үнэт цаас гаргагчийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл 18
1.3. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл 18
1.4. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал, онцлох үйл явдлууд 18
1.5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид болон хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл 20
1.5.1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц 20
1.5.2. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл 20
1.5.3. Холбоотой талын мэдээлэл 21
1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт 24
1.6.1. Үнэт цаас гаргагчийн бүтэц 24
1.6.2. Үнэт цаас гаргагчийн алба, газрууд 26
1.7. Компанийн засаглал 27
1.7.1. Компанийн засаглалын Кодекс 27
1.7.2. Төлөөлөн Удирдах Зөвлөл 27
1.7.3. ТУЗ-ийн дэргэдэх хороод 31
1.8. Удирдлагын багийн танилцуулга 32
1.9. Үнэт цаас гаргагчийн хүний нөөц 34
1.10. Арилжаалагдаж буй хувьцааны мэдээлэл 35
1.11. Байгаль орчин, нийгэм, засаглал 36
1.12. Хамтын ажиллагаа 40

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
СТАНДАРТ

1.13. Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн эх үүсвэр татах үйл ажиллагаа 42
1.14. Ногдол ашгийн бодлого 44
1.15. Их хэмжээний болон холбоотой талтай хийсэн гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл 44
ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА 48
2.1. Монгол Улсын макро эдийн засгийн байдал, ирээдүйн чиг хандлага 48
2.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбар, цаашдын чиг хандлага 53
2.3. Өрсөлдөгчийн судалгаа 64
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 69
3.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ 69
3.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд 74
3.3. Үнэт цаас гаргагчийн стратеги 78
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 82
4.1. Санхүүгийн үзүүлэлт, шинжилгээ 82
ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 95
5.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй улсын эдийн засаг, салбарын нөхцөл байдал болон төлөв 95
5.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны зорилт болон төлөвлөгөө 95
5.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө 97
ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 104
6.1. Үнэт цаас нэмж гаргах тухай шийдвэр 104
6.2. Санал болгож буй үнэт цаасны тухай 104
6.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт 105
6.4. Үнэт цаасны үнэ тогтоох тухай 106
6.5. Үнэт цаасыг зах зээлд арилжаалах төлөвлөгөө 107
6.6. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг 110
6.7. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт 112
ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА 115
7.1. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого 115
7.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд 115
7.3. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага 119
НАЙМ. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД 126
8.1. Үндсэн Андеррайтерийн компани 126
8.2. Туслах Андеррайтерийн компани 127

8.3. Аудитын компани 129
8.4. Хуулийн фирм 130
ЕС. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ 133
9.1. Андеррайтерийн дүгнэлт 133
9.2. Аудиторын дүгнэлт 133
9.3. Хуулийн дүгнэлт 133
АРАВ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД 135

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Үнэт цаас гаргагчийн бүртгэл ....... 18
Хүснэгт 2 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц (Үнэт цаас гаргах үеийн байдлаар) ....... 20
Хүснэгт 3 Холбоотой этгээдийн жагсаалт ....... 21
Хүснэгт 4 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ....... 27
Хүснэгт 5 Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг ....... 33
Хүснэгт 6 Үнэт цаас гаргагчийн хувьцааны бүртгэл ....... 35
Хүснэгт 7 Үнэт цаас гаргагчийн арилжааны мэдээ (2023 оны 6 сарын 09-ний өдрийн байдлаар) ....... 36
Хүснэгт 8 2023-2025 оны байдлаарх Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл, хувиар 52
Хүснэгт 9 2018-2022 оны байдлаарх санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ ....... 55
Хүснэгт 10 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын санхүүгийн гол үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр ....... 56
Хүснэгт 11 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ-ын эрхэлж буй үйл ажиллагаа 58
Хүснэгт 12 2022 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн бүтэц, тэрбум төгрөгөөр ....... 60
Хүснэгт 13 2022 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн үлдэгдэл, ангиллаар ....... 60
Хүснэгт 14 2023-2025 оны байдлаарх Монгол Улсын ББСБ салбарын төсөөлөл ....... 61
Хүснэгт 15 2023 оны хагас жилийн байдлаарх апп ашиглан зээл олгож байгаа ТОП-10 ББСБ, App Store таталтаар ....... 63
Хүснэгт 16 2022 оны жилийн эцсийн байдлаарх өрсөлдөгч ББСБ-ын тоон үзүүлэлт, тэрбум төгрөгөөр ....... 65
Хүснэгт 17 2022 оны жилийн эцсийн байдлаарх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ ....... 66
Хүснэгт 18 2023 оны хагас жилийн байдлаарх апп-р үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт ....... 66
Хүснэгт 19 2023 оны хагас жилийн байдлаарх бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт ....... 67
Хүснэгт 20 Зээлийн үйлчилгээний мэдээлэл ....... 71
Хүснэгт 21 Итгэлцлийн үйлчилгээний мэдээлэл ....... 71
Хүснэгт 22 Зээлийн үйл ажиллагааны мэдээлэл (тэрбум төгрөг) ....... 76
Хүснэгт 23 Зээлийн эрсдэлийн сан, 2022 оны байдлаар ....... 77
Хүснэгт 24 Зээлийн эрсдэлийн сан, 2021 оны байдлаар ....... 77
Хүснэгт 25 Зээлийн эрсдэлийн сан, 2020 оны байдлаар ....... 78
Хүснэгт 26 Зээлийн эрсдэлийн сан, 2019 оны байдлаар ....... 78
Хүснэгт 27 Зээлийн тоо, зээлийн багцын төсөөлөл ....... 80
Хүснэгт 28 Орлогын тайлан ....... 82
Хүснэгт 29 Санхүүгийн байдлын тайлан ....... 84
Хүснэгт 30 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр ....... 87
Хүснэгт 31 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр ....... 87
Хүснэгт 32 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр ....... 88



СЗХ 2023 09 01 БҮРТГЭВ
АРД КРЕДИТ ББСБ ХК
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

Хүснэгт 33 Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр .... 89
Хүснэгт 34 Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд .... 89
Хүснэгт 35 Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд .... 90
Хүснэгт 36 Зээлийн харьцаа үзүүлэлтүүд .... 90
Хүснэгт 37 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүд .... 91
Хүснэгт 38 Актив хөрөнгийн төвлөрлийн шалгуур үзүүлэлтүүд .... 92
Хүснэгт 39 Гадаад валютын ханштай холбоотой шалгуур үзүүлэлтүүд .... 93
Хүснэгт 40 Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүд .... 93
Хүснэгт 41 Үндсэн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүд .... 93
Хүснэгт 42 Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, 2023-2025 .... 97
Хүснэгт 43 Орлогын тайлангийн төсөөлөл, 2023-2025 .... 100
Хүснэгт 44 Харьцаа үзүүлэлтийн төсөөлөл, 2023-2025 .... 102
Хүснэгт 45 Санал болгож буй үнэт цаасны тухай .... 104
Хүснэгт 46 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (Нэмж хувьцаа гаргах үеэс өмнөх байдлаар) .... 106
Хүснэгт 47 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (Нэмж хувьцаа гаргасны дараах байдлаар) .... 106
Хүснэгт 48 Ард Кредитын жигнэсэн дундаж ханшийн мэдээлэл .... 107
Хүснэгт 49 Эрсдэлийн хамгаалалтын шугам .... 120

## ГРАФИК

График 1 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын ДНБ, их наяд төгрөгөөр .... 48
График 2 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын төлбөрийн тэнцэл, сая доллароор .... 49
График 3 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын инфляцын түвшин, хувиар .... 49
График 4 2018-2023.I улирлын байдлаарх Монгол Улсын бодлогын хүү, хувиар .... 50
График 5 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын зээл, хадгаламжийн хүү, хувиар .... 51
График 6 2022 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, сая доллараар .... 51
График 7 2023-2027 оны байдлаарх олон улсын зээл болон ББСБ салбарын зах зээлийн төсөөлөл, тэрбум доллароор .... 53
График 8 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ салбарын нийт хөрөнгийн задаргаа .... 55
График 9 МХБ-ийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр .... 56
График 10 2018-2022 оны байдлаарх Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт ББСБ-ын тоо .... 58
График 11 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр .... 59
График 12 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын ашигт ажиллагааны үзүүлэлт, сая төгрөгөөр .... 60
График 13 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын цэвэр ашгийн маржин, хувиар .... 61
График 14 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ-ын жигнэсэн дундаж зээлийн хүү, сараар .... 62
График 15 2023 оны хагас жилийн байдлаарх зээлийн хүүгийн (сараар) судалгаа .... 66
График 16 Апп хэрэглэгчийн тоо .... 75
График 17 Онлайн зээлийн хүсэлтийн тоо .... 75



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СЭХ
оны 2023 сар 09. 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-09-01
БҮРТГЭВ-02

График 18 Онлайн зээл олголт (зүүн тэнхлэг - тэрбум төгрөг, баруун тэнхлэг - тоо) .... 76
График 19 Зээлийн багцын чанар .... 77
График 20 Үйл ажиллагааны орлогын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр .... 82
График 21 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр.... 83
График 22 Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр.... 83
График 23 Үнэт цаас гаргагчийн активын бүтэц, тэрбум төгрөгөөр .... 85
График 24 Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр.... 85
График 25 Итгэлцэл, тэрбум төгрөгөөр .... 86
График 26 Үнэт цаас гаргагчийн зээл ангиллаар, тэрбум төгрөгөөр.... 86
График 27 Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багцын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр.... 98
График 28 Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн гүйцэтгэл ба төсөөлөл , тэрбум төгрөгөөр.... 99
График 29 Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр.... 99
График 30 Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлогын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр.... 100
График 31 Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлогын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр.... 101
График 32 Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр.... 101

## ЗУРАГ

Зураг 1 Компанийн голлох тоон үзүүлэлтүүд.... 16
Зураг 2 Үнэт цаас гаргагчийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл .... 18
Зураг 3 Компанийн бүтэц, зохион байгуулалт .... 24
Зураг 4 Үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээлийн арилжаа, төгрөгөөр .... 36
Зураг 5 Үнэт цаас гаргагчийн 2022 оны хэмнэлтийн үзүүлэлтүүд .... 37
Зураг 6 Ард Кредит IPO цан цохих ёслол .... 42
Зураг 7 Крауд Кредит сангийн хамтын ажиллагаа .... 43
Зураг 8 2022 оны жилийн эцсийн байдлаарх олон улсын ДНБ-нд эзлэх өрийн хувь .... 54
Зураг 9 2022 оны жилийн эцсийн байдлаарх дижитал банкны зах зээл, газар зүйн бүсчлэлээр.... 54
Зураг 10 Ард Апп үйлчилгээний мэдээлэл .... 72
Зураг 11 Картын үйлчилгээний мэдээлэл.... 73
Зураг 12 Анхдагч зах зээлд байршуулах хуваарь .... 108
Зураг 13 Үнэт цаас худалдан авах заавар .... 109
Зураг 14 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт .... 112

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Ард Кредит ББСБ | Үнэт Цаас Гаргагч, Компани |
| АрдКойн | Блокчэйн технологид суурилан хийгдсэн Монголын хамгийн анхны хязгаарлагдмал урамшууллын оноо юм. |
| КОВИД-19 | "КО" гэдэг нь корона, "ВИ" нь вирус, 'Д' нь diease буюу англи хэлээр өвчин гэсэн үгийн нийлэмж бөгөөд БНХАУ-ын Ухань хотод анх тогтоогдсон коронавирусийн шинэ омгийн улмаас үүссэн халдварт өвчин юм. |
| ТОП-20 индекс | Тухайн индекс тооцох багцад орсон үнэт цааснуудын үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралт зэргээр үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг энэхүү индексээр тодорхойлдог. |
| Финтек | Технологийн дэвшилд суурилсан санхүүгийн үйлчилгээг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх үйл явц юм. |
| Цахим мөнгө | Цахим мөнгө буюу digital money нь хууль зүйн утгаараа Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл юм. |
| CAGR | Compounded Annual Growth Rate (жилийн, нийлмэл өсөлтийн түвшин) |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ББСБ | Банк Бус Санхүүгийн Байгууллага |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| МХҮХ | Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Төв |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ҮЦТХТ | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЭХ | Хувьцаа Эзэмшигчдийн Хурал |
| ЭСЯ | Элчин Сайдын Яам |
| NPL | Non Performing Loan буюу Чанаргүй зээл |
| PAR | Portfolio at Risk буюу Эрсдэлтэй зээл (хэвийн ангиллаас бусад бүх ангиллын зээл) |
| ТоС | Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ХХН | Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл |
| ХОС | Хөрөнгө оруулалтын сан |
| ХОҮС | Хөрөнгө оруулагч үндэстэн сан |
| ХХН | Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл |

СЗХ
2023 .09. 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -09- 01
БҮРТГЭВ-02



## ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

| ***Үнэт цаас гаргагч*** | ***"Ард Кредит ББСБ" ХК*** |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Үнэт цаасны бүртгэл | Монголын Хөрөнгийн Бирж |
| МХБ-ийн ангилал | I ангилал |
| Зарласан хувьцааны тоо | 280,000,000 ширхэг |
| Нэмж санал болгож буй хувь | 30 хүртэлх хувь |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 84,000,000 ширхэг |
| Нэмж хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо | 364,000,000 ширхэг |
| Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох нөхцөл | • Нэмж гаргах хувьцаанаас 67,200,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох (80 хүртэлх хувь);<br>• Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авах хувьцааны үнийн дүнгийн доод хэмжээг 100,000,000 (нэг зуун сая) төгрөг байх;<br>• Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд тусгаарлах; |
| Олон нийтэд санал болгох нөхцөл | • Нэмж гаргах хувьцаанаас 16,800,000 ширхгээс доошгүй энгийн хувьцааг олон нийтэд санал болгох (20 хувиас доошгүй);<br>• 500,000 төгрөг хүртэлх захиалга 100% биелж, давсан захиалгыг хувь тэнцүүлнэ. |
| Үнэт цаасны арилжаа явуулах арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |
| Хувьцааны үнэ тогтоох аргачлал, санал болгох үнэ | Компанийн хувьцааны үнийг 2023 оны 6 сарын 12-ны өдрөөр тасалбар болгож, тус өдрөөс МХБ-ийн арилжааны өмнөх 180 хоногийн жигнэсэн дундаж ханш болох 106 төгрөгөөр тогтоосон |
| Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцох хувь | 100% |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Компанийн үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэлэх |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН
# ТАНИЛЦУУЛГА

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 5459567

ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК

СЗХ
2023 оны 09 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 11



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-04
БҮРТГЭВ-02

## НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

### 1.1. Ард Кредитын товч танилцуулга

"Ард Кредит ББСБ" ХК (цаашид "Үнэт цаас гаргагч", "Ард Кредит" эсвэл "Компани") нь 2011 онд үүсгэн байгуулагдсан Монгол Улсын тэргүүлэх банк бус санхүүгийн байгууллагуудын нэг юм. Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаасаа тогтмол өсөн дэвшиж, жил бүр ашигтай ажиллан сүүлийн хоёр жилд 2.26 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилаад байна.

2019 онд Ард Кредит нь өөрийн хувьцааны 25 хувийг олон нийтэд нээлттэй санал болгон хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн бөгөөд Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-ийн ТОП-20 индексэд жил бүр багтсан. Ард Кредит нь 2022 оны байдлаар 36.1 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй, 1 сая гаруй харилцагч, 13,539 хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны хувьд 50.5 мянган зээлдэгч, 41.8 тэрбум төгрөгийн зээлийн багц, 14.6 тэрбум төгрөгийн хүү, шимтгэлийн орлого, 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байна.

Ард Кредит нь Монгол Улсад хамгийн өргөн сүлжээгээр буюу "Монгол Шуудан" ХК-ийн аймгийн салбараар дамжуулан бага хүү, таатай нөхцөлтэй бизнесийн зээл, хэрэглээний зээл, Fast Cash цахим зээлийн үйлчилгээ, олон улсын мөнгөн гуйвуулга болон итгэлцлийн үйлчилгээг харилцагчдадаа санал болгон ажилладаг.

Компани нь 2022 онд Монгол Улсад анх удаа үйлдвэрлэгч, нийлүүлэгч, бизнес эрхлэгч, эцсийн хэрэглэгчийг холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний шинэ төрлийн санхүүжилтийн үйлчилгээ болох СКОПА төслийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдэд өртөг бага, санхүүжилтийн хурдтай үйлчилгээг нэвтрүүлэн, түүхий эд, бараа татан авалтын санхүүжилтээ шимтгэлгүй, хүүгүй, барьцаагүй нөхцөлөөр авах боломжийг нээж, малчдад зориулан хөнгөлөлттэй зээл, харилцагч нартаа зориулан хүүгүй, шимтгэлгүй худалдан авалтын Pick n Pay зээлийн бүтээгдэхүүн, гүйлгээ бүрээсээ хуримтлал үүсгэх боломжтой бүрэн цахимжсан хуримтлалын Cupcake үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлсэн.

Үнэт цаас гаргагч нь 2017 онд салбартаа анхлан кредит карт хамтран гаргасан бол 2022 онд Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авснаар бие даан карт гаргасан анхны ББСБ болоод байна.

*Зураг 1 Компанийн голлох тоон үзүүлэлтүүд*

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

## ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 1 САЯ харилцагч

| | |
|---|---|
| 2022 | 1,019,392 |
| 2021 | 1,012,184 |
| 2020 | 357,153 |
| 2019 | 184,005 |

49%. 51%.




### 50K зээлдэгч

| | |
|---|---|
| 2022 | 50,459 |
| 2021 | 47,709 |
| 2020 | 37,759 |
| 2019 | 32,643 |

47%. 53%.




### 13K хувьцаа эзэмшигч

| | |
|---|---|
| 2022 | 13,307 |
| 2021 | 13,702 |
| 2020 | 2,139 |
| 2019 | 1,500 |




- Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хамаарал бүхий компаниуд
- Бусад

АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

## 1.2. Үнэт цаас гаргагчийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл

*Зураг 2 Үнэт цаас гаргагчийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл*




## 1.3. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь Улсын бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу 2011 оны 3 сарын 15-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу СЗХ-ны 2011 оны 4 сарын 21-ний өдрийн Т3101/222 тоот тушаалаар банк бус санхүүгийн байгууллага байгуулах зөвшөөрөл авснаар "Ард Кредит ББСБ" оноосон нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн.

*Хүснэгт 1 Үнэт цаас гаргагчийн бүртгэл*

| *Компанийн нэр* | *Ард Кредит ББСБ ХК* |
|---|---|
| **Компанийн хэлбэр** | Нээлттэй хувьцаат компани |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2011.03.15 |
| **Улсын бүртгэлд бүртгэгдсэн байдал** | 2011 оны 3 сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн 9010002003 тоот улсын бүртгэлийн дугаар, 5459567 тоот регистрийн дугаартайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байгаа хувьцаат компани юм. |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Зээлийн үйл ажиллагаа |
| **СЗХ-ны тусгай зөвшөөрөл** | Зээл, гадаад валютын арилжаа, итгэлцэл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлга, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх |
| **Монголбанкны тусгай зөвшөөрөл** | Цахим мөнгө гаргах, карт гаргагчийн зөвшөөрөл |
| **Улсын бүртгэлд бүртгэгдсэн болон шуудангийн хаяг** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр барилгын 13 давхар, 1313 тоот |
| **Утас** | +976 7700 3322 |
| **И-мэйл** | info@ardcredit.com |
| **Цахим хуудас** | www.ardcredit.com |

## 1.4. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал, онцлох үйл явдлууд

# ТҮҮХЭН ЗАМНАЛ

ARD CREDIT

**2011**
Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдав

**2013**
Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулалт хийв

**2014**
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авав

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**2015**
БСХ Сангаас хөнгөлөлттэй санхүүжилт татав

БИЧИЛ САНХҮҮГИЙН ХӨГЖЛИЙН САН



**2017**
Салбартаа анхлан Кредит картын үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв

**2018**
IPO хийх зөвшөөрөл авч үнэт цаасаа бүртгүүлэв. Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх Ард Аппын анхны хувилбарыг танилцуулав.

**2019**
Цахим зээлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв. 1,500 гаруй хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болж МХБ-ийн хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров.

**2020**
Монголбанкнаас Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авснаар банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв

EUROGIRO

EuroGiro мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Монгол Шуудан ХК-тай хамтран нэвтрүүлж, дэлхийн 56 улсаас хамгийн бага шимтгэлтэй мөнгөн гуйвуулга хийх боломжийг нээв.

ACH+(Автомат Клиринг Хаус) банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

KIDS Stronger. Together.

**2021**
Хүүхдэд зориулсан анхны санхүүгийн аппликейшн АрдКидс Аппыг танилцуулав. Анхны виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв

**2022**
Нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилт олгож эхлэв. Картын тусгай зөвшөөрөл авав.

good platform

АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

## 1.5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид болон хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл

### 1.5.1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т *"Компаниас гаргасан хувьцааг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж болно"* гэж заасны дагуу Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар дараах хувьцаа эзэмшигчид Компанийн нийт эргэлтэд байгаа 280,000,000 ширхэг хувьцааг эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт 2 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц (Үнэт цаас гаргах үеийн байдлаар)*

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 113,660,996 | 40.59% |
| 2 | С.Гэрэлтуяа | 27,305,402 | 9.75% |
| 3 | Ардын Тэтгэврийн Данс ХХК | 16,232,767 | 5.80% |
| 4 | Х.Батхишиг | 14,426,999 | 5.15% |
| 5 | С.Оргил | 11,658,223 | 4.16% |
| 6 | Г. Бат-Эрдэнэ | 11,648,223 | 4.16% |
| 7 | Ард Бит ХХК | 11,217,378 | 4.01% |
| 8 | Н.Мөнхнасан | 7,058,824 | 2.52% |
| 9 | Эйч Ви Эл Эл ХХК | 6,923,259 | 2.47% |
| 10 | А.Сүхдорж | 5,086,580 | 1.82% |
| | Топ хувьцаа эзэмшигчид | 225,218,651 | 80.44% |
| | Бусад хувьцаа эзэмшигчид | 54,781,349 | 19.56% |
| | **Нийт зарласан хувьцаа** | **280,000,000** | **100.00%** |
| | Хувьцаа эзэмшигчдийн тоо | 13,539 | |

### 1.5.2. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Ард Кредитын хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй нийт зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 280,000,000 ширхэг энгийн хувьцаа байгаа бөгөөд үүнээс 280,000,000 ширхэг хувьцаа эргэлтэд байна.

Үнэт цаас гаргагч нь 2019 онд олон нийтэд Компанийн 25 хувийг санал болгож нээлттэй хувьцаат компани болсон ба үнэт цаас гаргах үеийн байдлаар нийт хувьцааны 80.44 хувийг ТОП-10 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаагаас 40.59 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК эзэлж байна.

Ард Кредит нь 2011 оны 4 сарын 21-ний өдөр үүсгэн байгуулагдахдаа хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 500,000,000 төгрөг болгосон ба үнэт цаас гаргах үеийн байдлаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 4 сарын 30-ны өдрийн тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2,800,000,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх үүргийн хэрэгжилтийг хангаг ажилладаг бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээндээ холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, тухай бүрд нь СЗХ-ноос зөвшөөрөл авсан.

СЗХ он сар өдөр 2023.08.03 В
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-08-04 БҮРТГЭВ
УЛААНБААТАР ХОТ АРД КРЕДИТ ББСБ ХК 9023051344 5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

ХЗХ
2023.09.01 өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-04
БҮРТГЭВ-02

*Хувь нийлүүлсэн хөрөнгө, гаргасан, зарласан, эргүүлэн авсан хувьцааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс үзнэ үү.*

### 1.5.3. Холбоотой талын мэдээлэл

*Хүснэгт 3 Холбоотой этгээдийн жагсаалт*

| | |
|---|---|
| | **Хуулийн этгээд** |
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК |
| 2 | Ард Актив ХЗХ |
| 3 | Ард Пропертиз ХХК |
| 4 | Ард Даатгал ХК |
| 5 | Ард Лизинг ХХК |
| 6 | Ардын Тэтгэврийн Данс ХХК |
| 7 | Ард Секюритиз ҮЦК ХХК |
| 8 | Ард Менежмент ХХК |
| 9 | Үндэсний хувьчлалын сан ХОС |
| 10 | Ард Финтек Солюшн ХХК |
| 11 | Монгол Шуудан ХК |
| 12 | Тэнгэрлэг Медиа Групп ХК |
| 13 | Тэнгэр Системс ХХК |
| 14 | Хөрөнгө оруулагч үндэстэн ХОС |
| | **Хувь хүн** |
| 1 | Сэдбазарын Гэрэлтуяа |
| 2 | Хишигдоржын Батхишиг |
| 3 | Сүхдоржын Оргил |
| 4 | Ганхуягийн Бат-Эрдэнэ |
| 5 | Нармандахын Мөнхнасан |
| 6 | Авирын Сүхдорж |

## АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2005 онд үүсгэн байгуулагдсан үндэсний санхүүгийн нэгдэл компани юм. Ард Санхүүгийн Нэгдлийн бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз, Ард Актив, Ард Менежмент, Ард Бит, Ард Лизинг, Ард Пропертиз, Ардын Тэтгэврийн данс гэх мэт компаниуд багтаж байна. Ард Санхүүгийн Нэгдэл нь тэргүүлэгч компани, төслүүдэд хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн өгөөжийг өсгөх, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгын хүрээнд ажилладаг. Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багц нь санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл, технологи, дэд бүтэц, блокчэйн, хэвлэл, мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 44 компаниас бүрддэг, үүнээс 8 нь нэлттэй компани юм.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

## САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН КЛАСТЕР

Ард Актив ХЗХ нь 2014 онд Траско ХЗХ-г худалдаж авснаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Байгуулагдсанаасаа хойш Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрлийн дагуу гишүүддээ санхүүгийн зөвлөгөө, арилжааны банкнаас өндөр хүүтэй хадгаламж, салбарын дунджаас бага хүүтэй зээлийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулдаг салбартаа хөрөнгөөрөө 2-т ордог тэргүүлэх хадгаламж, зээлийн хоршоо юм.

Ард Лизинг ХХК нь 2015 онд гадаад худалдаа, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан, уян хатан нөхцөлтэй цахим лизингийн үйлчилгээ, мөн өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй уялдсан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн бусад охин компаниудын багц бүтээгдэхүүнүүдийг харилцагчдадаа санал болгодог.

Ард Пропертиз ХХК нь 2017 оны 3 сарын 7-ны өдөр үүсгэн байгуулагдсан, Үл хөдлөх хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа, засвар үйлчилгээ эрхэлдэг Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд орчин үеийн ухаалаг, дэвшилтэт технологийг ашиглан үл хөдлөх хөрөнгийн салбарт шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, хүссэн харилцагч бүрд өөрийн боломжоор хөрөнгө оруулалт хийх, Монгол Улсынхаа томоохон бүтээн байгуулалтуудаас эзэмших, хүртээмжтэй, шударга боломж олгохыг зорин ажиллаж байна.

## ДААТГАЛЫН КЛАСТЕР

Ард Даатгал ХК нь 1994 онд Монгол Улсын ууган даатгалын компани болон байгуулагдаж, даатгалын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна. Ард Даатгал нь даатгуулагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, тэдний амар тайван амьдралын баталгааг хангасан үйлчилгээг үзүүлж, харилцагчдаа амжилтад хөтөлсөн,

СЭХ
2023 09 01
БҮРТГЭВ



2023-08-04
БҮРТГЭВ-02

нийгмийн хариуцлагыг дээдлэгч, ил тод, итгэл төрүүлсэн тэргүүлэгч даатгагч, даатгалын үйлчилгээ үзүүлэхийг зорин ажиллаж байна.

Ард Лайф ХХК нь 2022 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалтаар урт хугацааны даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Ардын Тэтгэврийн Данс ХХК нь 2007 онд МТНД (Монголын Тэтгэврийн Нэрийн Данс) нэртэйгээр байгуулагдаж, Монгол Улсад анх удаа хувийн тэтгэврийн сангийн үйлчилгээг эхлүүлсэн. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Хас Банкны ажилчдын тэтгэврийн хуримтлалыг удирддаг байсан бөгөөд 2012 онд бүтцийн өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай компани болсон юм.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР

ARD СЕКЮРИТИЗ ҮЦК | ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН | ARD МЕНЕЖМЕНТ КОМПАНИ

Ард Секюритиз ҮЦК нь 1997 онд Монет Капитал нэрээр байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохих ёсны зөвшөөрлүүдийн дагуу брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад арилжаа зуучлах гэх мэт санхүүгийн зуучлалын цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа Монгол Улсын ууган компаниудын нэг юм. Ард Секюритиз ҮЦК ХХК нь 150 мянга гаруй иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцох дансыг нээж, 30 гаруй аж ахуй нэгжид 200 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт босгох болон нэгдэх, нийлэх үйл ажиллагаанд зуучлагчаар оролцоод байна.

Үндэсний Хувьчлалын Сан ХОС нь урт хугацаанд улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компанийн хувьчлалд оролцох, дунд хугацаанд Монгол улс төдийгүй дэлхий даяар арилжаалдаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж бодит өгөөжийг хөрөнгө оруулагч нарт бий болгох зорилготой Монгол улсын хамгийн анхны хамтын сан юм.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хамтын ХОС (ХОҮС) нь Монгол улсад үүсгэн байгуулагдаж буй анхны хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нэг юм. Тус сан нь мэргэжлийн хөрөнгө оруулалтын багаар удирдуулж оновчтой цаг үед ул суурьтай судалгаа шинжилгээ дээр тулгуурлан хөрөнгө оруулалт хийснээр эдийн засаг хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй ойлгомжгүй байдлыг илүү тодорхой, хялбар болгож өгдөг. ХОҮС-ийн үйл ажиллагаа нь тогтворжсон ногдол ашиг хуваарилдаг компаниудад түлхүү хөрөнгө оруулалт хийж тогтмол өгөөжийг хөрөнгө оруулагч нарт хуваарилахаар ажиллаж байна.

Ард Менежмент ХХК нь 2016 онд байгуулагдаж Санхүүгийн Зохицуулах Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Ард Менежмент нь группийн болон түүний охин компаниудын хөрөнгийн удирдлагыг хийдэг

АРД КРЕДИТ ББСБ ХК



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЭХ
2023.09.01
БҮРТГЭВ
№ 1



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-04
БҮРТГЭВ-02

ба Монгол Улсын анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан (MSE: ХОС), хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан "Хөрөнгө оруулагч үндэстэн сан"-г удирдан ажиллуулж байна.

**БУСАД**

ТЭНГЭРЛИГ

ТЭНГЭР

Ард Финтек Солюшн

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, ОТТ стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын шуудангийн үндсэн сүлжээг эзэмшигч "Монгол Шуудан" ХК нь Монгол Улсын 21 аймаг, дүүргийн 22 шуудангийн үйлчилгээний газар, 330 сум болон Улаанбаатар хотын 38 Шуудангийн үйлчилгээний салбараар дамжуулан нийт 900 гаруй ажиллагсадтайгаар шуудангийн 30 гаруй нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэн явуулж байна.

ТэнГэр СиСтемс ХХК нь Ард Санхүүгийн Нэгдлийн мэдээлэл, технологийн бодлогын хүрээнд охин компаниуд технологийн шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхэд уриалан түүчээлж, ажилчдын хөдөлмөрийн өндөр бүтээмж, цахим үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх замаар дижитал шилжилтийн хийн ажиллаж байна.

Ард Финтек Солюшн ХХК нь технологийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

## 1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

### 1.6.1. Үнэт цаас гаргагчийн бүтэц

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэгжийн бүтэц зохион байгуулалт дараах байдалтай байна:

*Зураг 3 Компанийн бүтэц, зохион байгуулалт*

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ТТС3981 5444381

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ

[redacted]




ББСБ ХК

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

### 1.6.2. Үнэт цаас гаргагчийн алба, газрууд

**Бизнес хөгжил хариуцсан газар** нь Зээлийн бодлогын алба, СКОПА төслийн алба, Салбарын Удирдлагын алба, Дижитал сувгийн удирдлагын алба гэх 4 албаны бүтэцтэй ба дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Бизнес хамтын ажиллагаа, зээлийн бодлого, сувгийн болон үйл ажиллагааны удирдлага
- Зээлийн бодлого, үйл ажиллагааны удирдлага
- Багцын өсөлт, чанар
- Зээлийн шинжилгээ, дүгнэлт
- Зээл олголт, эргэн төлөлт
- Борлуулалт, хамтын ажиллагааны удирдлага
- Үйлчилгээний удирдлага, эх үүсвэр татан төвлөрүүлэлт, зээлийн үйлчилгээ, борлуулалт
- Цахим зээлийн борлуулалт, эргэн төлөлт, хяналт шинжилгээ
- Төслийн удирдлага

**Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан газар** нь Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн алба болон Бүртгэлийн алба гэх бүтэцтэй ба дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Бүтээгдэхүүний хөгжүүлэлт, харилцагчийн бүртгэл, хамтын ажиллагааны удирдлага
- Харилцагчийн мэдээллийн хяналт, мониторинг
- Зээлийн гэрээ баталгаажуулалт, харилцагчийн мэдээллийн нийцүүлэлт, архивлалт

**Санхүүгийн газар** нь Санхүү бүртгэлийн алба, Хөрөнгө удирдлагын алба болон Цахим мөнгөний алба гэх бүтэцтэйгээр дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Санхүү удирдлага
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн шинжилгээ, мониторинг
- Нягтлан бодох бүртгэл

**Дижитал хөгжлийн газар** нь Систем хөгжүүлэлтийн албатай ба дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Систем хөгжүүлэлт, хамтын ажиллагааны удирдлага
- Систем, технологийн сайжруулалт
- Дата, системийн шинжилгээ

**Гүйцэтгэх захирлын алба** нь дараах чиг үүргийн албууд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Үйл ажиллагаа, хүний нөөц
- Хууль, хянан нийцүүлэлт
- Маркетинг, борлуулалт
- Эрсдэл

СЗХ
2023 09 01
БҮРТГЭВ
№ 1



MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-04
БҮРТГЭВ

## 1.7. Компанийн засаглал

### 1.7.1. Компанийн засаглалын Кодекс

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2022 оны 3 сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн Засаглалын Кодексийн журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Компанийн Засаглалын Кодекс нь Хувьцаа эзэмшигчдийн эрх, мэргэжлийн хөрөнгө оруулагчид, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмуудыг багтаасан байдаг.

Ард Кредит нь Компанийн дүрэмдээ Компанийн Засаглалын Кодекс, зохистой засаглалын зарчмуудыг тусгасан. Тус бодлогын хүрээнд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хувь нийлүүлэгчид, харилцагч болон бусад сонирхол нэгтэй этгээдийн эрх ашигт нийцүүлэх, ил тод байдлыг сайжруулахад ач холбогдол өгч, холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 1.7.2. Төлөөлөн Удирдах Зөвлөл

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах зэрэг Компанийн дүрэмд заасан ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гарган ажилладаг.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д хувьцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлагатай гэж заасан байдаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Ард Кредит нь 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийг хангасан байна. ТУЗ-ийн даргаар Чулууны Ганзориг ажиллаж байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

*Хүснэгт 4 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл*

| № | Нэр | Эрхэлж байгаа ажил | Томилогдсон | Төлөв | Эзэмшиж буй хувьцааны хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ч.Ганзориг | Ард Экс ХХК, Гүйцэтгэх захирал | 2013.05.10 | Дарга | 0.22% буюу 604,399 ширхэг |
| 2 | О.Одбаяр | Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга | 2021.04.30 | Ердийн | 0.00% буюу 5,505 ширхэг |
| 3 | Г.Тэлмэн | Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирал | 2021.04.30 | Ердийн | 0.08% буюу 232,071 ширхэг |
| 4 | Г.Уянга | Ард Пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал | 2023.02.09 | Ердийн | 0.05% буюу 145,589 ширхэг |
| 5 | Б.Золбоо | Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал | 2023.02.09 | Ердийн | 0.08% буюу 220,000 ширхэг |
| 6 | Б.Ганбат | Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн | 2014.02.24 | Ердийн | 0.00% буюу 7,941 ширхэг |



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | В.Ганзориг | Бат Солюшн Партнерс ХХК, ТУЗ-ийн дарга | 2016.01.01 | Хараат бус | 0.03% буюу 82,358 ширхэг |
| 8 | Б.Солонго | Софтлайн Азия ХХК, Гүйцэтгэх захирал | 2021.04.30 | Хараат бус | 0.00% буюу 2,891 ширхэг |
| 9 | С.Энхчимэг | Бипрос Монголиа үүсгэн байгуулагч | 2023.02.09 | Хараат бус | Байхгүй |

***ТУЗ-ийн гишүүд***



***Чулууны Ганзориг***
*ТУЗ-ийн дарга*

***Мэргэжил:*** Бизнес Менежмент

***Боловсрол:*** 2007-2010 онд Унгар, Будапешт, Корвинус Эдийн Засгийн Их Сургууль, Бизнес менежмент

***Ажилласан туршлага:***
2022 оны 6 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн дарга, 2013 оноос хойш Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2020-одоог хүртэл Ард Экс ХХК, Гүйцэтгэх захирал
2018-одоог хүртэл Ард Даатгал ХК, ТУЗ-ийн гишүүн
2013-2020 онд Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
2017-2018 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Санхүү эрхэлсэн захирал
2012-2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Хөрөнгө оруулалтын шинжээч
2010-2012 онд Ард Секюритиз ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч



***Гэрэлтийн Тэлмэн***
*Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн*

***Мэргэжил:*** Олон Улсын эдийн засагч

***Боловсрол:***
2010-2013 онд БНСУ, Сөүл, Сонгюньгуан Их Сургуулийн Бизнесийн сургууль, Менежментийн шинжлэх ухааны магистр
2003-2008 онд МУИС, Олон улсын харилцааны сургууль, Олон улсын эдийн засгийн бакалавр

***Ажилласан туршлага:***
2021 оны 4 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2020-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
2016-2020 онд Монгол Шуудан ХК, Дэд захирал
2014-2016 онд Эм И Си Партнерс ХХК, Хамтран үүсгэн байгуулагч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
2015-2016 онд Ленобль ХХК, Гүйцэтгэх захирал
2008-2015 онд Эл Жи Инк (LG Int. Corp.) Монгол дахь төлөөлөгч, ахлах менежер



***Одончимэгийн Одбаяр***
*ТУЗ-ийн ердийн гишүүн*

***Мэргэжил:*** Эдийн засагч, эрх зүйч

***Боловсрол:***
2018 онд АНУ-ын Харвард Бизнесийн Их Сургууль, Бизнес удирдлагын мэргэжил дээшлүүлэх сургалт
1996-1997 онд АНУ, Техникийн их сургууль, Эдийн засгийн мэргэжил дээшлүүлэх сургалт
1996-1998 онд Отгонтэнгэр Их Сургууль, Хуульч, Эрх зүйч бакалавр
1984-1988 онд ЗХУ-ын Багшийн Их Сургууль, Багш бакалавр, магистр

***Ажилласан туршлага:***
2022 оноос Ард Даатгал ХК, ТУЗ-ийн дарга
2021 оны 4 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2016-2019 онд Эрдэнэс Монгол ХХК, Дэд захирал
2012-2016 онд Алтай Холдинг ХХК, Дэд ерөнхийлөгч
2010-2012 онд Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын зөвлөх
2005-2010 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, 3-р нарийн бичгийн дарга, Консул
2002-2005 онд МИАТ ХК, Бээжин дэх төлөөлөгчийн газрын менежер
1988-1992 онд УБДС, багш



**Галнямын Уянга**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*

**Мэргэжил:** Банк Санхүү

**Боловсрол:** 1998-2002 онд СЭЗИС, Банк Санхүү

**Ажилласан туршлага:**
2023 оны 2 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2019-одоог хүртэл Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
2009-2019 онд Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал
2005-2009 онд НҮБ төсөл, Грассрүүтс Жижиг дунд бизнесийг дэмжих төв

**Батбилэгийн Золбоо**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*

**Мэргэжил:** Санхүү удирдлага, Нягтлан бодох бүртгэл

**Боловсрол:**
2013-2016 онд Бизнес, эдийн засгийн сургууль Нью Йорк, АНУ
2012-2013 онд СЭЗИС, ACCA

СЗХ
он сар өдөр
2023 09 01
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-04
БҮРТГЭВ-02



| | |
|---|---|
| **Ажилласан туршлага:** | 2023 оны 2 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн<br>2019 оноос одоог хүртэл Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Санхүү эрхэлсэн захирал<br>2017-2018 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал<br>2017 онд Ард Менежмент ҮЦК ХХК, Гүйцэтгэх захирал<br>2017 онд Ард Менежмент ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч<br>2016 онд Ард Секюритиз ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч<br>2016 онд АНУ, Нью Йорк, Darwood Associates inc., Дадлагажигч<br>2014-2015 онд АНУ, Нью Йорк, Primary Insight LLC, J.P.Morgan, Дадлагажигч |



***Барамсайн Ганбат***
*ТУЗ-ийн ердийн гишүүн*

| | |
|---|---|
| ***Мэргэжил:*** | Санхүү, эдийн засагч |
| ***Боловсрол:*** | 2010-2012 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Бизнес удирдлагын магистр<br>1994-1998 онд МУИС, Эдийн Засгийн Их Сургууль, Санхүү, эдийн засгийн бакалавр |
| ***Ажилласан туршлага:*** | 2007-одоог хүртэл Техник технологийн дээд сургууль, Удирдах зөвлөлийн гишүүн<br>2014-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн<br>2007-2012 онд И Ай Ти ХХК, ТУЗ-ийн гишүүн, захирал<br>2000-2007 онд Хас банк ХХК, Салбарын захирал, Хэрэг эрхлэх газрын захирал<br>1998-2000 онд Монголын Хөрөнгийн Бирж ТӨХЗ, Нягтлан бодогч, Хянан шалгагч |



**Ванчигийн Ганзориг**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*

| | |
|---|---|
| **Мэргэжил:** | Бизнесийн удирдлага |
| **Боловсрол:** | 2009-2010 онд Японы Олон Улсын Их Сургууль, Цахим бизнес удирдлагын магистр, MBA 2003-2005 онд АНУ-ын Нотр Дамын Их Сургууль, Бизнес удирдлагын магистр<br>1997-2001 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль, Бизнес удирдлагын бакалавр |
| **Ажилласан туршлага:** | 2016-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн<br>2015-одоог хүртэл Бат Сольюшн Партнерс ХХК, ТУЗ-ийн дарга, Шунхлай Групп ХХК, Медиа Групп ХХК, Гүйцэтгэх захирал<br>2012-2015 Медиа Групп ХХК, Гүйцэтгэх захирал |

УЛААНБААТАР ХОТ
ARD
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК



**Батсүрэнгийн Солонго**
*Хараат бус гишүүн*

**Мэргэжил:** Бизнесийн удирдлага

**Боловсрол:** 2006-2011 онд ОХУ-ын Москва хотын Санхүүгийн дээд сургууль, Санхүүгийн магистр
2017-2018 онд Удирдлагын академи, Бизнес удирдлагын магистр

**Ажилласан туршлага:** 2021 оны 4 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн
2021 оноос МУК Компьютерс ХХК, Гүйцэтгэх захирал
2015-2021 Софтлайн Азия ХХК, Гүйцэтгэх захирал
2015-одоог хүртэл Триквест ХХК, Гүйцэтгэх захирал;
2016-2019 онд Ард Санхүүгийн Нэгдэл, Хөрөнгө оруулагч үндэстэн, ТУЗ-ийн хараат бус гишүүн
2012-2015 онд Софтлайн Азия ХХК, Худалдаа, маркетинг хариуцсан захирал
2011-2012 онд Софтлайн Азия ХХК, Маркетингийн менежер



**Сүхбаатарын Энхчимэг**
*Хараат бус гишүүн*

**Мэргэжил:** Бизнесийн менежмент

**Боловсрол:** 2011-2013 онд БНСУ, Жонжү Их Сургууль, Бизнесийн менежмент мастер
2008-2010 онд БНСУ Жонжү Их Сургууль, Үйлдвэрлэлийн инженер дизайны бакалавр
2005-2010 онд Улаанбаатар Дээд Сургууль, Үйлдвэрлэлийн инженер дизайн бакалавр

**Ажилласан туршлага:** 2023 оны 2 сараас Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн
2022-одоог хүртэл Бипрос Монголиа ХХК, Үүсгэн байгуулагч
2016-2022 Эрдэнэс Монгол ХХК, Бизнес хөгжлийн мэргэжилтэн
2015-2016 Натхауз крейтив ХХК, Дэд захирал
2014-2015 Стар ТВ, Маркетингийн дарга
2012-2014 Скаймедиа ХХК, Маркетингийн ахлах
2011-2012 Скайтел групп ХХК, ОНХ мэргэжилтэн

### 1.7.3. ТУЗ-ийн дэргэдэх хороод

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэжлийн түвшинд явуулах зорилгоор дараах хороодыг байгуулан ажиллаж байна:

2023-09-04
БҮРТГЭВ-02

- Дотоод аудитын хороо
- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
- Санхүү, зээл, эрсдэлийн хороо

Компанийн тухай хуульд зааснаар Хороод нь ТУЗ-өөр хэлэлцэх асуудлуудтай холбоотой зөвлөмж гарган ТУЗ-д танилцуулдаг.

*Дотоод аудитын хороо*

Дотоод Аудитын Хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Уянга, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Ганбат, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго, ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Энхчимэг нар ажиллаж байна.

*Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо*

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин, урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох асуудлуудыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр ажилладаг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Уянга, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго, ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Ганбат, ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг нар ажиллаж байна.

*Санхүү, зээл, эрсдэлийн хороо*

Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь компанийн стратеги төлөвлөгөө, зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлогуудыг боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулахад хяналт тавьж ажилладаг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Золбоо, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Тэлмэн нар ажиллаж байна.

## 1.8. Удирдлагын багийн танилцуулга

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үүргийг ТУЗ-өөс сонгосон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Ард Кредитын дүрэм болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий төлөөлөгч байна. Ард Кредитын гүйцэтгэх удирдлагын баг нь салбартаа удаан ажилласан, хариуцсан чиг үүрэг болон менежментийн ур чадварын хувьд мэргэшсэн, мэргэжлийн хамт олноос бүрддэг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

СЗХ
2023 сар 09 өдөр 01
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-04
БҮРТГЭВ-02

*Хүснэгт 5 Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг*

| № | Нэр | Албан тушаал | Томилогдсон огноо | Эзэмшиж буй хувьцааны хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Г.Тэлмэн | Гүйцэтгэх захирал | 2020.01.27 | 0.08% буюу 232,071 ширхэг |
| 2 | Г.Сүхбаатар | Бизнес хөгжил эрхэлсэн захирал | 2023.01.02 | 0.01% буюу 38,351 ширхэг |
| 3 | Х.Билгүүн | Санхүү эрхэлсэн захирал | 2021.11.06 | 0.00% буюу 1,560 ширхэг |
| 4 | Г.Чимэгсүрэн | Бүтээгдэхүүн хөгжүүлэлт эрхэлсэн захирал | 2022.12.12 | 0.00% буюу 5,915 ширхэг |
| 5 | А.Дуним | Дижитал хөгжил эрхэлсэн захирал | 2023.05.12 | 0.00% буюу 6,058 ширхэг |



**Гүррагчаагийн Сүхбаатар**
*Бизнес хөгжил эрхэлсэн захирал*

**Мэргэжил:** Нягтлан бодогч

**Боловсрол:** 2000-2004 онд МУИС, Эдийн засгийн сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр бакалавр

**Ажилласан туршлага:** 2023 оны 1 сараас Ард Кредит ББСБ ХК, Бизнес хөгжил эрхэлсэн захирал
2019-2023 онд Ард Лизинг ХХК, Гүйцэтгэх захирал
2017-2021 онд Ард Кредит ББСБ ХК, Стратеги бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал
2005-2016 онд Хас банк ХК, Эдийн засагч, Салбарын захирал
2004-2005 онд Кредит Монгол ББСБ, Эдийн засагч



**Хүрэлбаатарын Билгүүн**
*Санхүү эрхэлсэн захирал*

**Мэргэжил:** Эдийн Засагч, Санхүүч

**Боловсрол:** 2020-2021 онд ИБУИНВУ, Глазговын Их Сургууль, Санхүүгийн төсөөлөл болон хөрөнгө оруулалтын мастер
2017-2019 онд Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн магистр
2008-2013 онд Монгол Улсын Их Сургууль, Олон Улсын эдийн засгийн бакалавр

**Ажилласан туршлага:** 2021 он 12 сараас одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, Санхүү эрхэлсэн захирал
2019-2020 онд Мөнхбумууд ХХК, Санхүү эрхэлсэн захирал
2017-2019 онд Санхүүгийн Зохицуулах Хороо, Ахлах референт
2013-2017 онд Сангийн яам, Зөвлөх

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567



**Галиндэвийн Чимэгсүрэн**
*Бүтээгдэхүүн хөгжүүлэлт эрхэлсэн захирал*

**Мэргэжил:** Бизнесийн Удирдлага

**Боловсрол:** 1999-2003 онд Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр

**Ажилласан туршлага:** 2022 оноос одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт эрхэлсэн захирал
2018-2019 онд Богд Банк ХК, Эрсдэлийн удирдлагын газрын захирал
2013-2016 онд Хас Банк ХК, Иргэдийн банкны газар, Хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний хэлтсийн захирал, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн захирал
2008-2013 онд Хас Банк, Иргэдийн банкны газар, Бүтээгдэхүүний ахлах мэргэжилтэн
2007 он Хас Банк, Эрсдэлийн удирдлагын газарт Эрсдэлийн ахлах мэргэжилтэн
2004-2005 онд Хас Банк, Зээлийн мэргэжилтэн, Эрсдэлийн менежер



**Ариунболдын Дуним**
*Дижитал хөгжил эрхэлсэн захирал*

**Мэргэжил:** Актуарч

**Боловсрол:** 2014-2018 онд АНУ, Wartburg College, Актуарч шинжлэх ухааны бакалавр
2011-2013 онд БНЭУ, Mahindra United World college, IB диплом

**Ажилласан туршлага:** 2023 оны 5 сараас Ард Кредит ББСБ ХК, Дижитал хөгжил эрхэлсэн захирал
2019 онд Ард Кредит ББСБ ХК, Систем шинжилгээний алба, Ахлах менежер
2018 онд АНУ, Summers financial group, Актуарч

## 1.9. Үнэт цаас гаргагчийн хүний нөөц

Компанийн үйл ажиллагааны бүтэц, хүний нөөц нь компанийн үндсэн чиглэл болох зээлийн үйл ажиллагаанд төвлөрдөг бөгөөд бусад функцүүд болох мэдээлэл технологи, дотоод аудитын үйл ажиллагааг толгой компаниас менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр авдаг. Ард Кредит нь хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад ажлын байрны тэгш эрхийн бодлого баримтлан ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь цахим бүтээгдэхүүн үйлчилгээнд суурилсан үйл ажиллагаа явуулах бодлогын хүрээнд цомхон бөгөөд чадварлаг, баг бүрэлдэхүүнтэйгээр ажиллахыг зорьдог бөгөөд стратегийн түнш болох "Монгол Шуудан" ХК-ийн салбар, орон даяар ажиллаж буй 400 гаруй ажиллагсад болон тусгайлан сургаж бэлтгэсэн

Ардын брокеруудаар дамжуулан зайлшгүй салбараар дамжих шаардлагатай үйл ажиллагааг харилцагчдадаа түргэн шуурхай үзүүлэн ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Компанид нийт 42 ажилтан байгаа бөгөөд үүнээс 6 гэрээт, 7 тусгай хэрэгцээт ажилтан байна.

Ард Кредит нь цар тахлын онцгой цаг үе, Орос-Украйны дайн зэрэг нийгэм, эдийн засгийн хүнд нөхцөлд үндсэн үйлчилгээгээ тасралтгүй үзүүлэхийн зэрэгцээ ажлын байрыг тогтвортой хадгалах, нийт ажилтнууд, харилцагчдаа халдвараас урьдчилан сэргийлэх, зайнаас ажиллах горим руу шилжих зэрэг зохицуулалтыг шуурхай хийж шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэн цар тахлын хямралыг амжилттай даван туулсан.

Компани нь эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, хөдөлмөрийн дотоод журмаа үе шаттай шинэчилж бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэн ажилладаг. Ард Кредит нь 2022 оноос эхлэн ажлын цагийг уян хатан болгож, ажлын өдрүүдэд зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж ажиллах, тэгш эрхийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь Компанийн үнэт зүйлд мэргэжлийн өндөр түвшний чадвартай, тэгш оролцоотой, ёс зүйтэй хамт олон болохын тулд аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, хүн бүрд шударга боломжийг олгож, ажилтан бүрийнхээ үзэл бодол, мэдлэг оюун, оролцоог дээдлэгч компани байна гэж тодорхойлсон байдаг. Үүнээс гадна, ажлын байранд сонгон шалгаруулалт хийхдээ хүний эрхийн мэдрэмжтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон ээжүүдийг уян хатан ажлын цагаар ажиллуулах, бие давхар эмэгтэйчүүдийг ажлын байранд тусгай нөхцөлөөр ажиллуулах зэрэг өөрчлөлтүүдийг хүний нөөцийн бодлогодоо тусган хэрэгжүүлдэг. Ард Кредит нь ажиллагсдаа эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулж, өөрийн болон бүрэлдэхүүн компаниудын хувьцаа, виртуал хөрөнгийг урт хугацаанд эзэмшүүлэх, ажилтнаас болон байгууллагаас сар бүр тэтгэврийн хуримтлалд орлого нэмэх зэрэг ажилтны болон тэдний гэр бүл, үр хүүхдийн ирээдүйд тасралтгүй хөрөнгө оруулалт хийж ажилласаар байна.

## 1.10. Арилжаалагдаж буй хувьцааны мэдээлэл

### Үнэт цаас гаргагчийн хувьцааны бүртгэл

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/133 тоот тушаалаар Ард Кредитын үнэт цаасыг 2019 оны 1 дүгээр улиралд үнэт цаасны бүртгэлд бүртгэж хувьцааны арилжааг эхлүүлсэн. Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн хувьцааны захиалга амжилттай явагдаж, Компанийн 25 хувь буюу 70,000,000 ширхэг хувьцаа 50, 50 хувийн харьцаатайгаар стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд арилжаалагдсан.

*Хүснэгт 6 Үнэт цаас гаргагчийн хувьцааны бүртгэл*

| *Бүртгэлтэй бирж* | *Монголын Хөрөнгийн Бирж* |
|---|---|
| Хувьцааны симбол | ADB |
| Бүртгэгдсэн огноо | 2018 оны 11 сарын 30 (Анхдагч зах зээл 2019 оны 2 сарын 18-ны өдрөөс 2019 оны 3 сарын 1-ний өдөр) |
| Хувьцааны ангилал | I ангилал |

| | |
|---|---|
| Хувьцааны тоо, ширхэг | 280,000,000 |
| Гүйцэтгэх захирал | Гэрэлтийн Тэлмэн |

**Олон нийтэд арилжаалагдаж буй хувьцааны мэдээлэл**

Ард Кредитын хувьцаа нь Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индексэд багтдаг ба олон нийтэд нээлттэй компани болсноос хойш 2023 оны 06 сарын 09-ний өдрийг хүртэл нийтдээ 26.5 тэрбум төгрөгөөр арилжаалагдаж, ТОП-20 индексэд 3 удаа багтаад байна.

Ард Кредитын хувьцаа 2023 оны 6 сарын 9-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны хаалтын ханш 109.00 төгрөг байна.

*Хүснэгт 7 Үнэт цаас гаргагчийн арилжааны мэдээ (2023 оны 6 сарын 09-ний өдрийн байдлаар)*

| | |
|---|---|
| Хаалтын ханш | ₮109.00 |
| 52 долоо хоногийн хэлбэлзэл | ₮88.08 - ₮137.20 |
| Зах зээлийн үнэлгээ | ₮30.49 тэрбум |
| Эргэлтэд гаргасан хувьцаа тоо ширхэг | 280,000,000 |
| Дансны үнэ (2022.12.31) | ₮18.10 тэрбум |
| P/E харьцаа буюу үнэ ашгийн харьцаа (2022.12.31) | 14.48 |
| EPS харьцаа буюу нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг (2022.12.31) | ₮7.52 |
| Ногдол ашиг (2021 оны тайлант жилийн ашиг) | ₮1.26 тэрбум |

**Эх сурвалж:** *Монголын Хөрөнгийн Бирж*

*Зураг 4 Үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээлийн арилжаа, төгрөгөөр*




**Эх сурвалж:** *Монголын Хөрөнгийн Бирж*

## 1.11. Байгаль орчин, нийгэм, засаглал

Үнэт цаас гаргагч нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөргөөр нөлөөлж болзошгүй бизнесүүдэд санхүүжилт олгохоос татгалзах бодлого баримталдаг ба Компанийн үнэт зүйл болох "тогтвортой хөгжих", хүрээлэн буй орчиндоо эерэг нөлөөлөл үзүүлэх, үнэ цэнэ бүтээхэд онцгойлон анхааран ажиллаж байна. Ард Кредит



АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СЭХ
2023 .09. 01 өдөр
БҮРТГЭВ
№ 1



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-04
БҮРТГЭВ-02

нь ногоон хөгжил, цахим шилжилтийг дэмжих зорилгоор Ард Аппыг зах зээлд нэвтрүүлснээс хойш бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, төрөлжилтийг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглан ирсэн бөгөөд байгаль орчноо хамгаалах, үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор салбаргүй бодлогыг хэрэгжүүлэн цахим салбараар үйл ажиллагаагаа явуулдаг. Компани нь санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан 24/7 горимоор үзүүлэн эрчим хүч, ус, цаасны хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэн ажиллаж байна. Үүний үр дүнд 2022 онд дараах хэмнэлтүүдийг гаргасан:

*Зураг 5 Үнэт цаас гаргагчийн 2022 оны хэмнэлтийн үзүүлэлтүүд*

**Цахим зээлийн үйлчилгээ**

Цаас хэмнэлт - **31.5 тонн**

Мод хэмнэлт - **11,003**

**Салбаргүй бодлого**

Эрчим хүчний хэмнэлт - **2,160,000 кВт**

Цаг хугацаа хэмнэлт - **104 жил буюу 911,040 цаг**

Ард Кредит нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш нийгмийн сайн үйлсийг дэмжин ажиллаж байгаа ба хэд хэдэн төсөл, аянуудыг хэрэгжүүлээд байна:

**"NO ONE LEFT BEHIND. TOGETHER" төсөл**



НҮБ-ын "Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих", "Тэгш бус байдлыг бууруулах" зорилгын хүрээнд Ард Кредит нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрны тэгш боломж олгох бодлогыг шат ахиулан хэрэгжүүлж байгаа ба дээрх бодлогыг илүү өргөн далайцтай, үе шаттай хэрэгжүүлэхээр "NO ONE LEFT BEHIND. TOGETHER" төслийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, JCI Централ ТББ-тай хамтран ажиллаж байна. Уг төслийн хүрээнд МХҮХ-ны гишүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг Ард Академиар зохион байгуулсан. Үүнээс гадна хараагүй болон сул хараатай залуусыг дадлагажих хөтөлбөрт хамруулж амжилттай оролцсон 2 хүнийг харилцагчийн үйлчилгээний төвд ажиллуулж эхэлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн хүртээмжтэй байдал, тэгш оролцоог хангах зорилгоор ажил олгогч, төрийн бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлагыг гаргаж, Ард Апп, Компанийн вэбсайтаа хүртээмжтэй болгох ажлыг эхлүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлыг дохионы хэлмэрчтэй зохион байгуулж эхэлсэн.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ☏ 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

**"Илгээлтийн эзэд - санхүүгийн боловсрол түгээх" төсөл**



Ард Санхүүгийн Нэгдэл ХК, түүний охин компаниуд "Илгээлтийн Эзэд - Санхүүгийн боловсрол түгээх" төслийг санаачлан Монгол Шуудан ХК-тай хамтран хэрэгжүүлсэн ба уг төслийн хүрээнд улсын хөгжлийн түүчээ болсон оюутан залууст зуны амралтаа дурсамжтай, үр бүтээлтэй өнгөрүүлж, "Ардын илгээлтээр" эх орныхоо өнцөг булан бүрд очиж цалинтай дадлага хийх боломж олгосноороо ач холбогдолтой юм. Ард Кредит нь Илгээлтийн эзэд төслийн хүрээнд 418 оюутныг санхүүгийн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамруулж, 21 аймаг, 330 сумдад 29,952 харилцагчдад санхүүгийн боловсрол түгээж, Монгол улсын хүүхэд бүрд хөрөнгө оруулалт хийх "Хүүхэд бүрд 77 АрдКойн" хөтөлбөрт орон нутгийн, алслагдмал иргэдийн хүүхдүүдийг хамруулж урамшуулав.

**"Ардын Брокер" хөтөлбөр**



Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд нь Монгол хүн бүрийг ирээдүйнхээ эзэн байж, сайн сайхан амьдралаа цогцлоон бүтээхэд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлэн өнөөдрийг хүртэл энэхүү үйл хэрэгтээ үнэнчээр зүтгэж байна. Ардын Брокерууд хөтөлбөрийн хүрээнд Ард Санхүүгийн Нэгдлийн ажилтан, харилцагч, хөрөнгө оруулагчид нь тусгай сургалт хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж хүн бүр "Хөрөнгө Оруулагч Үндэстэн" хөдөлгөөнд нэгдэхэд Ардыг Ардтай холбож, Монгол Улсын ирээдүйн хөрөнгө, санхүүгийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

**Ард Санхүүгийн Боловсрол НҮТББ**



Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох зорилгынхоо хүрээнд иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжин Ард Санхүүгийн Боловсрол хэмээх нийгэмдээ үйлчлэх зорилготой ТББ-ыг 2017 онд үүсгэн байгуулж Ард Академи нэрээр санхүүгийн боловсролд зориулж оюуны хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр ирсэн. Ард Академи нь Хөрөнгө Оруулалт, Хувийн санхүү, Блокчэйн, Humans of Ard, Санхүүгийн мэдлэгийг 5 минутад зэрэг нийтлэлийн булангаараа дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдээ, мэдлэгийг цахим орчинд тасралтгүй хүргэсээр ирсэн бөгөөд АрдКидс

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СЭХ
2023.09 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Апп зах зээлд нэвтэрснээс хойш "Ард Кидс" нийтлэлийн буланг хүүхдийн санхүүгийн боловсролд тусгайлан хүргэж байна.

**Сайн үйлсийн аян**




Компанийн нийт ажиллагсад нэг өдрийн цалингаа ЗҮРХ МАРТАХГҮЙ аянд хандивласан.




Ард Кредит нь МББСБХ-ноос санаачлан зохион байгуулсан хандивын үйл ажиллагаанд нэгдэж нийт 100 сая төгрөгийн хандив цугларсныг Улсын Онцгой Комиссын даргад гардуулсан.



"Даян дэлхийн нэр төрөө эрхэмлэх өдөр"-ийн хүрээнд 29 дүгээр тусгай дунд сургуулийн сурагчдад "Нэр төр гэж юу вэ?" сэдэвт лекц, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд нь сайн дурын цусны донорын эгнээг өргөжүүлэх, хүмүүнлэгийн үйлсийг олон нийтэд сурталчлан уриалах зорилгоор Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтарсан үйл ажиллагааг дэмжиж ажилласан.



Үнэт цаас гаргагч нь "Ид Шидийн Орон" - Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвд хандив өргөж 26 хүүхдийн автобусыг хүлээлгэн өгсөн.



Ард Кредит нь нийгмийн хариуцлагын хүрээнд КОВИД-19 цар тахлын хэцүү нөхцөл байдалд ажиллаж буй 100 сувилагчид 100 сая төгрөгийн хандив өргөсөн.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

## 1.12. Хамтын ажиллагаа

Салбарын хөгжлийг түүчээлэх алсын хараатай Ард Кредит нь нийгэм болон бизнесийн үйл ажиллагааны хүрээнд гадаад болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тасралтгүй өргөжүүлэн тэлсээр байна.




2021 онд Үнэт цаас гаргагч нь СкопАллианс ХХК-тай хамтран нийлүүлэлтийн гинжин хэлхээний GOOD платформыг хэрэгжүүлж, түүхий эдийн ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид, мерчантууд, санхүүгийн байгууллагуудыг нэг талбарт холбож хамтын ажиллагааг бэхжүүлснээр эцсийн хэрэглэгчид үнэ багатай бүтээгдэхүүнийг нийлүүлэн, гинжин хэлхээнд оролцож буй талуудад харилцан ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

CROWD CREDIT

Ард Кредит нь 2019 онд Япон улсын Крауд Кредит сантай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд сүүлийн 4 жилийн хугацаанд нийт 16.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монгол улсад татан төвлөрүүлж санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулаад байна.

МОНГОЛ ШУУДАН

Үнэт цаас гаргагч нь Fast Cash онлайн зээл болон малын тэжээлийн зээлийг Монгол Улсын 21 аймаг, 330 сумдад хүртээмжтэй олгоход стратегийн түнш Монгол шуудан ХК-тай хамтран ажиллаж байна.

eurogiro

Компани нь дэлхийн 60 гаруй улсад байршилтай, 500 мянган салбар нэгж бүхий санхүүгийн байгууллагууд, 4 тэрбум хүнийг төлбөр тооцооны дэд бүтцээр холбодог Eurogiro байгууллагын "Санхүүгийн супермаркет" системд амжилттай холбогдож олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хамтран үзүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд АНУ, ОХУ, БНСУ, Австрали, Турк, Их Британи зэрэг дэлхийн 60 гаруй оронд суугаа мянга мянган харилцагчид Ria, Small world, PostalPay зэрэг дэлхийн томоохон мөнгөн

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

гуйвуулгын операторуудын салбараас Монгол Улсад суугаа дотнын хүмүүстээ түргэн шуурхай, өртөг багатайгаар мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.

Ард Кредит нь дэлхийн сая сая эмэгтэйчүүдэд тулгардаг санхүүгийн асуудлыг хүртээмжтэйгээр шийдвэрлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа явуулдаг Women's World Banking-тай байгуулсан түншлэлийн хүрээнд гишүүн байгууллагын хувьд хандив тусламж өгөх замаар үйл ажиллагааг дэмжин ажилладаг бөгөөд эмэгтэйчүүдэд зориулсан хөнгөлөлттэй бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргахаар ажиллаж байна.

Ард Кредит нь үйл ажиллагаандаа тогтвортой санхүүжилтийн зарчмыг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг ханган ажиллах зорилгын хүрээнд 2022 оны 3 сард Монголын Тогтвортой санхүүгийн холбоо (ТоС холбоо)-нд гишүүн байгууллагаар элсэн орсон. ТоС холбоонд элсэн орсноор бизнесийн үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийг тодорхойлж зээлийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийн асуудлыг авч үзэх, зээлийн эрсдэлийг тооцохдоо байгаль орчинд үзүүлж буй хор нөлөөллийг мөн давхар тооцоолох, байгууллагын дотоод гадаад үйл ажиллагааг Тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах цаашлаад 2023-2025 оны бизнес стратегийг шинэчлэхдээ Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллах, стратегийн хүрээнд нийт зээлийн багцын 10 хувийг ногоон зээлийн багцаар бүрдүүлэх шийдвэрийг гарган 2022 онд тогтвортой хөгжлийн бодлогоо батлан ажилласан. ТоС холбоо нь өдрөөс өдөрт үйлчлэгч байгууллагуудынхаа цар хүрээг тэлж тэр ч утгаараа гишүүн байгууллагуудын идэвх оролцоо нэмэгдэж анх удаа ТоС-ын дэргэдэх ББСБ-ын мэргэжлийн зөвлөлийг байгуулав. Энэхүү зөвлөлийн тэргүүнээр Ард Кредитын Санхүү эрхэлсэн захирал Х.Билгүүн сонгогдон ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь ТоС холбооны идэвхтэй гишүүний хувьд 2022 онд анх удаагаа тогтвортой хөгжлийн тайлангаа гарган хувьцаа эзэмшигчид, харилцагч байгууллагууд, түншүүд болон олон нийтэд танилцуулсан бөгөөд цаашид жил бүр энэхүү тайланг тогтмол гаргаж ажиллаж байна.

**Бусад хамтран ажиллагч байгууллагууд**

сар өдөр 2023.09.08

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-09-04



## 1.13. Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн эх үүсвэр татах үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг санхүүжүүлж буй эх үүсвэр нь итгэлцлийн үйлчилгээ, дотоод банк санхүүгийн байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, бондын санхүүжилт болон хоёрдогч өглөг буюу өмчийн санхүүжилт гэсэн хэсгүүдээс бүрддэг.

**Хувьцааны санхүүжилт**

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа өргөтгөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх үүднээс 2019 онд IPO гаргаж 5.3 тэрбум төгрөг олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн.

*Зураг 6 Ард Кредит IPO цан цохих ёслол*



Компани нь 2019 онд хиймэл оюун ухаанд суурилсан онлайн зээлийг Ард Аппаар дамжуулан олгож эхэлсэн бөгөөд IPO татан төвлөрүүлсэн хөрөнгөөр онлайн зээлийг санхүүжүүлэхэд зарцуулснаар зээлийн багц  болон нийт хөрөнгөө 5.5 дахин, цэвэр ашгаа 6.0 дахин тус тус өсгөж чадсан.

Мөн үнэт цаас гаргагч нь 2019 онд олон нийтэд нээлттэй компани болсон цагаасаа хойш тасралтгүй МХБ-ийн нэгдүгээр самбарт багтаж ирсэн нь санхүүгийн тайлан, хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ болон ашигт ажиллагаагаар тогтмол өндөр үзүүлэлтээ хадгалж, амжилттай байсныг илтгэж байна.

**Биржийн бус зах зээлийн үнэт цаас**

2021 онд ББЗЗ-ийн зохицуулалт батлагдсанаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдад ББЗЗ дээр үнэт цаас гаргах, арилжаалах дэд бүтэц бүрдсэн ба Ард Кредит нь Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны дэргэдэх ББЗЗ-ийн OTC платформ дээр 7.0 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд санал болгож амжилттай татан төвлөрүүлсэн.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

2023 оны 5-р сарын байдлаар 4.2 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлөлтийг амжилттай хийсэн бөгөөд 2023 оны сүүлийн хагас жилд 4.1 тэрбум төгрөгийн төлөлт хийгдэх хуваарьтай байна.

**Хоёрдогч өглөг**

Хоёрдогч өглөг гэж өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, гуравдагч этгээдээс авсан, захиран зарцуулалт нь хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг хэлдэг. Хоёрдогч өглөгийн бусад үнэт цааснаас ялгарах онцлог нь урт хугацаатай тогтвортой санхүүжилт болдог ба хугацааны эцэст хувьцаанд хөрвөх нөхцөлтэй, өмчийн хэрэглүүрт бүртгэгдэж эздийн өмчийг нэмэгдүүлэх боломжтой санхүүгийн хэрэглүүр юм.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд 5.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг 5 жилийн хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй буюу зах зээлийн хүүгээс бага, таатай нөхцөлөөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-иас татан төвлөрүүлж үндсэн үйл ажиллагаа санхүүжүүлсэн.

**Гадаадын хөрөнгө оруулалт, эх үүсвэр**

Ард Кредит нь урт хугацаатай, тогтвортой гадны хөрөнгө оруулалт татах зорилгын хүрээнд 2019 оны 3 сард Япон улсын Крауд Кредит сантай нийт 5 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилт татах гэрээг байгуулсан. 2023 оны 5 сарын байдлаар тус гэрээний хүрээнд нийт 5.8 сая ам.долларын санхүүжилт татаж хүүгийн хамт 3.7 сая ам.долларыг амжилттай цөг хугацаанд нь төлсөн байна.

*Зураг 7 Крауд Кредит сангийн хамтын ажиллагаа*




Крауд Кредит Сан нь Япон улсын зах зээлээс крауд фандинг буюу олон нийтээс санхүүжилт татан төвлөрүүлж дэлхийн бусад орнуудын бичил зээл болон лизингийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад санхүүжилт олгохоос гадна дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүч гэх мэт хөгжлийн төслүүдэд дэмжлэг үзүүлэн ажилладаг байгууллага юм.

## 1.14. Ногдол ашгийн бодлого

Ард Кредитын Ногдол ашгийн бодлого нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 13-ны өдрийн 2020/12 тоот тогтоолын дагуу шинэчлэн батлагдсан байна. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн журам нь Ард Кредитын хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаар шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Компани нь ирэх жилүүдэд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг бизнесийн үйл ажиллагаанд зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулж, тухайн жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийг зохистой хэмжээнд байлгах бодлогыг баримтлан ажиллана.

Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээнээс илүү өөрийн хөрөнгөтэй, эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш 60 хоногоос хэтрэхгүй хугацаанд ногдол ашгийг бүрэн төлж дуусгана.

Ард Кредит нь нээлттэй компани болсноос хойш цэвэр ашгаас 2019 онд 1,481 хувьцаа эзэмшигчид 1.18 тэрбум төгрөг, 2020 онд 2,139 хувьцаа эзэмшигчид 1 тэрбум төгрөг, 2021 онд 13,702 хувьцаа эзэмшигчид 1.26 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тус тус хуваарилаад байна. Компани нь 2022 онд 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан хэдий ч 2023-2025 оны компанийн дунд хугацааны бизнесийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж өөрийн өмч болон хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн. Үүний үр дүнд Компанийн өөрийн өмч 18.1 тэрбум төгрөгт хүрч, санхүүжилт татах боломж нэмэгдэж, компанийн үйл ажиллагаа илүү өргөжиж, 2023 онд хувьцаа эзэмшигчдийн хүртэх хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Ард Кредит нь 2022 онд ногдол ашиг олгоогүй хэдий ч хувьцаа эзэмшигчдэдээ хувь тэнцүүлсэн урамшуулал буюу нэгж хувьцаанд 0.1 ширхэг Ард Койныг тооцон 816.3 сая төгрөгтэй тэнцэхүйц нийт 27,975,334 ширхэг Ард Койныг олгосон.

## 1.15. Их хэмжээний болон холбоотой талтай хийсэн гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл

#### Их хэмжээний гэрээ, хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тусгаснаар Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцдог. Үүнд:

СЗХ
2023 .09. 01
сар өдөр



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 18
БҮРТГЭВ-02

- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;
- Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлсон хэлцэл хийхийн өмнөх Компанийн сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнийн дүн бүхий их хэмжээний гэрээ, хэлцлийг бусадтай байгуулаагүй байна.

*Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс харна уу.*

**Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл**

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд тусгаснаар Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэлд дараах ойлголтыг хамруулна. Үүнд:

Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Компани нь сүүлийн гурван жилийн хугацаанд нийт 106 сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг байгуулсан. Сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг байгуулах, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцсэн ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураалтын хуудас болон хурлын тэмдэглэлүүдэд дурдсанаар сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг батлах ТУЗ-ийн

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

хурлын ирц нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5 дахь хэсэгт заасан хэмжээнд хүрсэн байх тул тухайн хурал хүчин төгөлдөр байна.ТУЗ-ийн эчнээ санал хураалтын хуудас болон хурлын тэмдэглэлд дурдсанаар сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, зөвшөөрөл олгох асуудлыг ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн нь компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Иймд эдгээр сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах тухай баталсан шийдвэр хүчин төгөлдөр байна.

*Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс харна уу.*

**Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл**

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,800,000,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 140,000,000 төгрөг байна. "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дахь заалт, Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.3.7 дахь хэсэгт заасны дагуу сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 149 гэрээ, хэлцэл байгуулсан байна. Тэдгээрээс 35 гэрээ хэвийн хэрэгжиж байгаа бол үлдсэн 114 гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан байна.

*Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс харна уу.*

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344

СТАНДАРТ

СЗХ 2023. 09. 01

## ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### 2.1. Монгол Улсын макро эдийн засгийн байдал, ирээдүйн чиг хандлага

Олон улсын эдийн засаг 2023 он гарснаар Орос-Украйны дайны нөлөөнөөс гарч, сэргэлт үзүүлж эхэлсэн. БНХАУ өнгөрсөн жилийн сүүлээр хатуу хөл хорионы дэглэмээ сулруулснаар тус улсын эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлснээс гадна олон улсын эдийн засагт өөдрөг мэдээ болов. Нийлүүлэлтийн гинжин хэлхээ сайжирч, дайнтай холбоотойгоор эрчим хүч, хоол хүнсний үнийн өсөлт хангалттай буураагүй тул олон улсын төв банкнууд инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүг хурдацтай нэмж байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Олон Улсын Валютын Сангаас гаргасан 2023 оны 4 сарын тайлангаар дэлхийн эдийн засаг 2023 онд 2.8 хувиар[1] буюу ёроолдоо хүрч, 2024 онд сэргэн 3.0 хувь өсөх төсөөлөлтэй байна. Харин олон улсын инфляцын түвшинг 2023 онд өнгөрсөн жилийн 8.7 хувиас буурч 7.0 хувьд хүрнэ гэж төсөөлсөн бол ирэх жил 4.9 хувь болно гэж төсөөлсөн байна.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Монгол Улсын ДНБ (2015 оны үнээр) 2022 онд 4.8 хувиар тэлж 28.4 их наяд төгрөгт хүрсэн ба зочид буудал болон нийтийн хоолны үйлчилгээний салбар өмнөх оноос 33.8 хувиар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 28.5 хувиар, урлаг, үзвэр, тоглоом, наадам 20.5 хувиар тус тус өссөн нь үүнд нөлөөлжээ.

Монгол Улс нэг хүнд ногдох ДНБ-ээрээ 2022 онд дэлхийд 128 дугаар байранд орсон[2]. Нэг хүнд ногдох ДНБ-ий дэлхийн дундаж 11,115 доллар[3] байсан бол хөгжиж буй орны дундаж 5,794 доллар байсан. Харин Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ 4,717 доллартой байв.

*График 1 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын ДНБ, их наяд төгрөгөөр*




***Эх сурвалж:** Монголбанк*

[1] ***Эх сурвалж:** IMF, World Economic Outlook, April 2023*
[2] ***Эх сурвалж:** www.tradingeconomics.com*
[3] ***Эх сурвалж:** United Nations, World Economics Situation and Prospects*



АРД КРЕДИТ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
9023051344 ли 5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

**Төлбөрийн тэнцэл**

Өмнөх жилүүдэд Монгол Улсын төлбөрийн тэнцэл алдагдалтай байсан хэдий ч дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ сүүлийн жилүүдэд өссөнөөр 2018 оноос хойш ашигтай гарч эхэлсэн. Төлбөрийн тэнцэл 2021 онд 215 сая долларын ашигтай байсан бол 2022 онд 256 сая доллароор нэмэгдэж 469.7 сая доллар болсон.

*График 2 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын төлбөрийн тэнцэл, сая доллароор*




**Эх сурвалж:** *Үндэсний Статистикийн Хороо*

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 онд 70 сая долларын алдагдалтай гарахад үйлчилгээний худалдааны тэнцэл 322 сая, анхдагч орлогын данс 282 сая долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн.

**Инфляц**

*График 3 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын инфляцын түвшин, хувиар*




**Эх сурвалж:** *Монголбанк*



СЭХ 2023.09.01 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-08-04 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ АРД КРЕДИТ ББСБ ХК 9023051344 5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХК

Инфляцын түвшин 2022 оны 6 сард 16.1 хувьд хүрч хамгийн дээд хэмжээнд хүрсэн. Төв банкны зүгээс инфляцтай тэмцэхээр 2022 оноос эхлэн хатуу мөнгөний бодлого баримталсан нь үр дүнгээ өгч эхэлсэн. Өнгөрсөн оны 11 сараас хойш бодлогын хүүг 13 хувьд барьсан нь инфляцыг 2023 оны 4 сарын байдлаар 11.3 хувь хүртэл буурахад нөлөөлжээ. Цар тахал, Орос-Украины дайн, БНХАУ-ын хөл холио зэрэг гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй байсан инфляц ОУВС-ийн мэдээлж буйгаар 2024 он гэхэд Монголбанкны зорилтот түвшин болох 6.0-8.0 хувьд хүрнэ гэж төсөөлсөн байна.

**Бодлогын хүү**

*График 4 2018-2023.I улирлын байдлаарх Монгол Улсын бодлогын хүү, хувиар*




***Эх сурвалж:*** Монголбанк

Монголбанк цар тахлын нөхцөл байдлыг харгалзан 2020 оны 11 сард бодлогын хүүг 6.0 хувь хүртэл буулгасан. 2022 оны 1 сар гэхэд нөхцөл байдал харьцангуй сайжирч инфляц 13.0 хувь гарсан тул төв банкнаас хатуу мөнгөний бодлого баримталж бодлогын хүүг нэмэх шийдвэрийг гаргасан. 2023 оны 3 сард Монголбанк бодлогын хүүг шат дараалалтай нэмж 13.0 хувьд хүргэсэн. Монголбанк 2023 оны 3 сараас хойш нэмж өсгөөгүй нь зээл болоод хадгаламжийн хүү ойрын хугацаанд тогтворжиж магадгүй гэсэн хүлээлтийг үүсгэж байна.

**Зээл болон хадгаламжийн хүү**

*График 5 2018-2022 оны байдлаарх Монгол Улсын зээл, хадгаламжийн хүү, хувиар*




***Эх сурвалж:** Монголбанк*

Зээл, хадгаламжийн хүү бодлогын хүүг дагаад буурсан ба дээрх зургаас харахад 2021 онд хамгийн доод цэгтээ хүрчээ. 2022 оны жилийн эцсээр зээлийн хүү 15.0 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин хадгаламжийн хүү 2 хувиар өсөж 9.0 хувьд хүрсэн байна. 2023 оны 5 сарын байдлаар инфляц 2022 оны 6 сарын дээд түвшин болох 16.1 хувиас 11.3 хувьд хүрсэн нь буурах хандлагыг илтгэж байна. Хил гаалийн удаашрал шийдэгдсэнээр импортын бараанууд илүү хямд өртгөөр орж ирэх боломжтой болсон тул инфляц цаашид буурч 2023 онд Монголбанкны зорилтот түвшин (6 хувь)-д хүрэх боломжтой байна.

**Монгол Улсын гадаад худалдаа**

2022 онд Монгол Улс дэлхийн 155 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21,245 сая доллар болж, 2021 оны гүйцэтгэлээс 5,158 сая доллар буюу 32.5 хувиар өсжээ.

*График 6 2022 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, сая доллараар*




***Эх сурвалж:** Монголбанк*

СЗХ
сар өдөр
2023 09 В



2023 -09- 04
БҮРТГЭВ-02

Гадаад худалдааны тэнцэл 2022 онд өмнөх оноос 1,440 сая доллароор нэмэгдэж, 3,836 сая долларын ашигтай байв.

Экспортод 12,540 сая долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35.7 хувиар өссөн байна.

Боловсруулсан болон хагас боловсруулсан алтны экспорт өмнөх онтой харьцуулахад 12.3 хувиар өсөж 1,127 сая доллар, зэсийн баяжмалын экспорт ялимгүй буурч мөн 2,735 сая доллар, нүүрсний экспорт 2.3 дахин өсөж 6,503 сая доллар байна. Нийт экспортын дийлэнх хэсгийн буюу 84.0 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Экспорт ийнхүү өсөж, төсөвт орлого олж байгаа нь олон улсад учирч болзошгүй хямралыг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна.

**Монгол Улсын эдийн засгийн төлөв**

Олон улсын байгууллагуудаас Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 2023 онд дунджаар 4.5-аас 5.4 хувийн хооронд байхаар тооцоолсон. Энэхүү өсөлтийн гол хүчин зүйл нь өнгөрсөн жилийн уул уурхайн экспорт дээр тогтоосон хилийн хязгаарлалт байхгүй болсонтой холбоотой байна. Үүнээс гадна Оюу Толгой төслийн гүний уурхайгаар дамжуулж олох орлого өсөх боломж өндөр байгаа талаар Дэлхийн Банк 2023 оны 4 сарын тайландаа тусгасан. Дээрх таатай нөхцөл байдлын тусламжтайгаар дотоодын эдийн засаг гадаад хүчин зүйлээс улбаатай сорилтуудыг даван туулах илүү боломжтой байна. Ойрын хугацаанд учирч болзошгүй эрсдэлүүдээс дурдвал Орос-Украины дайны даамжрал, хөгжингүй орнуудын бодлогын хүүгийн өсөлтөөс улбаалж зээлийн өртөг өсөх, мөн засгийн газрын өр зэргийг нэрлэж болох юм. Эдгээрээс шалтгаалж Монгол Улсын инфляц өсөхөөс гадна гадаад өрийн зардал өсөх эрсдэлтэй юм. Хэрэв Оюу Толгойн олборлолт төлөвлөсөн хугацаандаа буюу 2023-2025 оны хооронд явагдаж орлого хоёр дахин өсөх[4] хүлээлтэд хүрсэн тохиолдолд дээрх дурдсан эрсдэлүүдийг даван туулахад томоохон хувь нэмэр оруулах төлөвтэй байна.

*Хүснэгт 8 2023-2025 оны байдлаарх Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл, хувиар*

| *Голлох үзүүлэлт* | *2022* | *2023Т* | *2024Т* | *2025Т* |
|---|---|---|---|---|
| **Дэлхийн банк** | | | | |
| ДНБ өсөлт | 4.7 | 5.2 | 6.3 | 6.8 |
| Инфляц | 15.2 | 9.5 | 6.8 | 6.0 |
| Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь) | -15.8 | -14.4 | -9.8 | -5.6 |
| Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь) | -0.8 | -1.2 | -0.5 | 0.3 |
| ЗГ-ын өрийн үлдэгдэл (ДНБ-д эзлэх хувь) | 63.8 | 60.8 | 58.5 | 56.0 |
| **Азийн Хөгжлийн Банк** | | | | |
| ДНБ өсөлт | 4.8 | 5.4 | 6.1 | - |
| Инфляц | 15.2 | 10.9 | 8.7 | - |
| **ОУВС** | | | | |
| ДНБ өсөлт | 4.8 | 4.5 | 5.5 | 5.5 (2028 он) |
| Инфляц | 15.2 | 11.2 | 8.8 | 6.0 (2028 он) |

**Эх сурвалж:** *Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, ОУВС*

[4] ***Эх сурвалж:*** *Дэлхийн Банк 2023 оны 4 сарын тайлан*



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5458567

Дээрх хүснэгт дэх олон улсын байгууллагуудын зүгээс Монгол Улсын эдийн засгийг ирэх хоёр жилд 2022 оноос илүү өснө гэж төсөөлсөн байна. Эдийн засаг өссөнөөр хэрэглэгчдийн худалдан авалт нэмэгдэж, цаашлаад аж ахуйн нэгжүүдийн орлого өсөж үнэт цаас гаргагчийн зээлдэгчид цагтаа зээлээ эргүүлэн төлж, үйл ажиллагаа өргөжихөд хувь нэмэр үзүүлэх төсөөлөлтэй байна.

Монголбанкны зүгээс үндсэн зорилтын хүрээнд төгрөгийн тогтвортой байдлыг хангахаар ажиллан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд тогтворжуулах буюу 2023 онд жилийн инфляцыг 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахаар зорин ажиллаж байна.

## 2.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбар, цаашдын чиг хандлага

### Дэлхийн санхүүгийн салбар

Олон улсын зээлийн бүтээгдэхүүний зах зээл 2022 онд $7,888 тэрбум байсан бол 2023 онд $8,682 тэрбум болж 10%-иар өсөх төсөөлөлтэй байна. 2027 он гэхэд $12,177 тэрбум буюу жилд 8.8 хувийн дундаж нийлмэл өсөлттэй (CAGR) байх төсөөлөлтэй байна. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь банк санхүүгийн байгууллагуудын хоорондох өрсөлдөөн ширүүссэн тул харилцагчдад илүү хялбар, шуурхай үйлчилгээг үзүүлэх шаардлагатай болсонтой холбоотой байна. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн байгууллагууд зээлийн үйлчилгээг илүү цахим болгож, ухаалаг гар утаснаасаа авч болдог болгох дээр анхаардаг болсон.

*График 7 2023-2027 оны байдлаарх олон улсын зээл болон ББСБ салбарын зах зээлийн төсөөлөл, тэрбум доллароор*




**Эх сурвалж:** *The Business Research Company, imarcgroup*

ББСБ-ын салбар нь санхүүгийн үйлчилгээг богино хугацаанд цахим болгож чадсан тул онлайн худалдаа, төлбөрийн хэрэглээ өргөжихийн хэрээр зах зээлээ тэлсэн. 2022 онд ББСБ-ын зах зээл $185 тэрбумаар хэмжигдэж байсан бол 2023 онд 9.2 хувиар өсөж

$202 тэрбум болох төлөвтэй байна. Харин 2027 он гэхэд жилд 8.8 хувийн нийлмэл өсөлттэй (CAGR) байснаар $411 тэрбум хүрэх хандлагатай байна.

*Зураг 8 2022 оны жилийн эцсийн байдлаарх олон улсын ДНБ-нд эзлэх өрийн хувь*




***Эх сурвалж:** World Population Review*

Өр болон ДНБ-ний харьцаа нь аливаа улсын нийт өрийг эдийн засагтай нь харьцуулсан үзүүлэлт ба аливаа улсыг өрөө хэр найдвартай төлж чадахыг харуулдаг. Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар өр ба ДНБ-ний харьцаа 77 хувиас хэтэрвэл эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг тул тус харьцааг бага байх тусам эдийн засаг илүү хурдтай өсөх боломжтой гэж үздэг. Монгол Улсын хувьд энэ харьцаа 55 хувь буюу 77 хувиас бага байгаа дотоодын эдийн засгийг өрөө төлөх бүрэн боломжтой ба цаашид хурдтай өсөх магадлал өндөр байгааг харуулж байна.

*Зураг 9 2022 оны жилийн эцсийн байдлаарх дижитал банкны зах зээл, газар зүйн бүсчлэлээр*




***Эх сурвалж:** Grand View Research*

СЗХ
2023 .09 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 1



2023-09-04
БҮРТГЭВ-02

Банк, санхүүгийн салбарт сүүлийн үед газар авч буй дэвшлүүдийн нэг нь дижитал банк билээ. Дижитал банкны зах зээлийн үнэлгээ 2022 онд $28 тэрбум байсан бол 2030 он гэхэд $107.1 тэрбум болох төсөөлөлтэй[5] байна. Ирэх 8 жилийн хугацаанд тус салбарыг 20.5 хувийн дундаж нийлмэл өсөлтийн хувьтай байхаар төсөөлжээ. Дээрх зургаас харахад Ази тивийн орнуудад дижитал банкны зах зээл хамгийн ихээр төвлөрсөн бол Өмнөд Америк, Африк, Европ тивүүдэд хурдтай хөгжиж байна. Үнэт цаас гаргагч нь цахим зээл гаргах дээр төвлөрсөн нь олон улсын санхүүгийн салбарт ажиглагдаж буй чиг хандлагатай нийцэж байна.

**Монгол Улсын санхүүгийн салбар**

*Санхүүгийн салбарын ерөнхий мэдээлэл*

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад нийт 13 арилжааны банк, 513 банк бус санхүүгийн байгууллага, 196 хадгаламж зээлийн хоршоо, 18 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2022 онд 6.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт 595 компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 318 нь хувьцаат компани байна.[6] Санхүүгийн салбарын зохицуулалтын хувьд арилжааны банкнуудад Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороо хяналт, зохицуулалтыг тавьдаг бол ББСБ, ХЗХ, даатгал болон үнэт цаасны зах зээлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохицуулдаг.

*Санхүүгийн салбарын бүтэц*

2022 оны байдлаар санхүүгийн салбарын нийт хөрөнгө 50.3 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь Монгол Улсын ДНБ-ний 95.0 хувийг бүрдүүлж байна. Үүнээс банкны салбар 91.5 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч сүүлийн 5 жилийн хугацааны үзүүлэлтээс харахад эзлэх байр сууриа бага багаар алдаж байна. Харин банкны бус санхүүгийн салбарын хувьд 2018 онд санхүүгийн салбарын 3.7 хувийг бүрдүүлж байсан бол жил ирэх тусам эзлэх хувь нэмэгдэж 2022 онд нийт хөрөнгө 3.5 их наяд төгрөгт хүрч санхүүгийн салбарын 7.0 хувийг бүрдүүлсэн.

*Хүснэгт 9 2018-2022 оны байдлаарх санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ*

| Үзүүлэлт (тэрбум төгрөг) | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % |
| Банк | 33,053 | 94.9% | 35,859 | 94.0% | 36,685 | 93.4% | 41,012 | 92.4% | 46,007 | 91.5% |
| ББСБ | 1,285 | 3.7% | 1,739 | 4.6% | 2,007 | 5.1% | 2,710 | 6.1% | 3,527 | 7.0% |
| Даатгал | 332 | 1.0% | 366 | 1.0% | 382 | 1.0% | 425 | 1.0% | 475 | 0.9% |
| ХЗХ | 153 | 0.4% | 200 | 0.5% | 223 | 0.6% | 256 | 0.6% | 268 | 0.5% |
| Бүгд | 34,823 | 100% | 38,164 | 100% | 39,297 | 100% | 44,403 | 100% | 50,277 | 100.0% |

**Эх сурвалж:** *Үндэсний Статистикийн Хороо, СЗХ*

*График 8 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ салбарын нийт хөрөнгийн задаргаа*

[5] **Эх сурвалж:** *Grand View Research: Digital banking platform market report 2022*
[6] **Эх сурвалж:** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 6459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

СЗХ
2023 .09 сар 01 өдөр
БҮРТГЭВ



2023-09-04




2022 оны байдлаар ББСБ-ын нийт хөрөнгө 3.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн 72.9 хувийг зээлийн багц бүрдүүлж байна. Энэ нь 2021 оны эцсээс 35.5 хувиар өсөж 2.6 их наяд төгрөгт хүрсэн нь уг салбарт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдацтай нэвтэрсэн нь зээлийн дүн өсөхөд нөлөөлсөн байна.

***Эх сурвалж:*** *Үндэсний Статистикийн Хороо*

*График 9 МХБ-ийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр*

Хөрөнгийн зах зээл хурдтай өсөж байгаа ба 2022 онд зах зээлийн үнэлгээ 6.9 их наяд төгрөг хүрсэн нь 5 жилийн өмнөхөөс 2.7 дахин өссөн үзүүлэлт юм. Харин данс эзэмшигчдийн тоо 2018 оныхоос 1.8 дахин өсөж 2.4 сая хүрсэн. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг ДНБ-тэй харьцуулахад 2022 оны байдлаар 13.3 хувьтай тэнцэж байгаа нь бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага[7] юм. Энэ нь дотоодын хөрөнгийн зах зээлийг үнэлгээний хувьд хямд байгааг илтгэж байгаа ба цаашид өсөх өндөр боломжтойг илгэж байна.




***Эх сурвалж:*** *Үндэсний Статистикийн Хороо*

**Банк бус санхүүгийн салбарын өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага**

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо эрчимтэйгээр нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ тэлж байгаа нь тус салбарыг санхүүгийн салбарын өндөр өсөлттэй салбар болоход нөлөөлж байна. Нөгөө талаар, зохицуулалтын орчин сайжрахын хэрээр 2022 онд 21 ББСБ үйл ажиллагаагаа зогсоосон бөгөөд жилийн эцсийн байдлаар 513 аж ахуйн нэгж банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна. Нийт ББСБ-ын 5.1 хувь буюу 26 ББСБ нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.9 хувь буюу 487 ББСБ нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

*Хүснэгт 10 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын санхүүгийн гол үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр*

| ***ББСБ-ын үндсэн үзүүлэлт (тэрбум төгрөг)*** | ***2018*** | ***2019*** | ***2020*** | ***2021*** | ***2022*** |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 315 | 364 | 491 | 430 | 491 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 805 | 1,159 | 1,223 | 1,897 | 2,571 |

[7] *Хөрөнгийн зах зээл болон ДНБ харьцаа 50%-75% хооронд байвал хямд үнэлгээтэй байна гэж үздэг. Эх сурвалж: Investopedia, Дэлхийн банкны зах зээлийн үнэлгээ болон ДНБ харьцааны дата.*



АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СЗХ
2023 .09 сар 01 өдөр
БҮРТГЭВ



MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-04
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үүнээс: чанаргүй зээл | 83 | 106 | 136 | 140 | 207 |
| Бусад актив | 165 | 216 | 293 | 383 | 465 |
| **Нийт актив** | **1,285** | **1,739** | **2,007** | **2,710** | **3,527** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 58 | 108 | 147 | 247 | 381 |
| Банк санхүүгийн байгууллагад өгөх өглөг | 151 | 208 | 43 | 283 | 397 |
| Өрийн бичиг | 23 | 42 | 21 | 150 | 228 |
| Бусад пассив | 76 | 114 | 345 | 441 | 329 |
| **Нийт өр төлбөр** | **308** | **472** | **556** | **1,121** | **1,335** |
| Өөрийн хөрөнгө | 977 | 1,267 | 1,451 | 1,589 | 2,192 |
| Үүнээс: хувьцаат капитал | 741 | 930 | 1,018 | 1,114 | 1,276 |
| **Нийт пассив** | **1,285** | **1,739** | **2,007** | **2,710** | **3,527** |
| ББСБ-ын тоо | 539 | 538 | 532 | 530 | 513 |
| Үүнээс: УБ хотод үйл ажиллагаа эрхэлж буй | 466 | 464 | 465 | 454 | 420 |
| Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй | 73 | 74 | 77 | 76 | 93 |
| Харилцагчдын тоо | 1,601,749 | 2,858,032 | 2,844,782 | 4,820,624 | 4,633,616 |
| Харилцагчдын тооны өсөлт, % | 8.9% | 78.4% | -0.5% | 22.4% | 31.4% |
| Нийт активд эзлэх зээл | 62.6% | 66.7% | 60.9% | 62.7% | 72.9% |
| Чанаргүй зээлийн хувь | 9.5% | 8.5% | 10.3% | 7.0% | 7.6% |
| Нийт активын өсөлт | 32.6% | 35.3% | 15.4% | 4.1% | 30.2% |

***Эх сурвалж:** Санхүүгийн Зохицуулах Хороо*

ББСБ-ын хөрөнгийн бүтцийг авч үзвэл 2018 онд нийт активын 62.6 хувийг зээл эзэлж байсан бол 2022 оны байдлаар зээлийн багцын нийт хөрөнгөд эзлэх хувь 10.3 хувиар өсөж 72.9 хувь болсон байна.

Салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор ББСБ-ын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирч салбарын харилцагчдын тоо хурдацтай өсөж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ салбарын харилцагчдын тоо өмнөх жилтэй харьцуулахад 31.4 хувь буюу 1.2 саяар нэмэгдэж 3.5 сая болсон[8]. Нийт зээлдэгчийн 70.2 хувь буюу 428 мянган харилцагч технологийн шийдлээр дамжуулан зээл авсан бол үлдсэн 29.2 хувь буюу 182 мянган харилцагчид нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгчид байна.

[8] ***Эх сурвалж:** МББСБХ-ны 2022 оны үйл ажиллагааны тайлан*



АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

*График 10 2018-2022 оны байдлаарх Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт ББСБ-ын тоо*




***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах хороо*

2022 оны байдлаар зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оноос 5.8 хувь, гадаад валютын үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо 5.3 хувиар тус тус буурч бусад үйл ажиллагааг санал болгож эхэлсэн байна. 2022 оны тайлангаас харахад богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 10.0 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 30.6 хувиар, факторинг үйлчилгээ 12.5 хувиар тус тус өссөн байна.

*Хүртээмж*

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад нийт 420 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 81.9 хувь нь буюу 327 нь Улаанбаатар хотод, 93 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.[9]

*Үйл ажиллагааны төрөл*

Нийт 513 ББСБ-ыг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 10 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байгаа ба нийт ББСБ-уудын 93.0 хувь нь зээлийн үйл ажиллагааг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна. Үүнээс 59.8 хувь буюу 307 ББСБ нь зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 7.0 хувь буюу 36 ББСБ нь зээлийн үйл ажиллагаанаас гадна гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байна.

*Хүснэгт 11 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ-ын эрхэлж буй үйл ажиллагаа*

| № | Үйл ажиллагааны нэр төрөл | ББСБ-ын тоо | | |
|---|---|---|---|---|
| | | 2020 | 2021 | 2022 |
| | **Нийт ББСБ-ын тоо** | **532** | **534** | **513** |
| 1 | Зээл | 494 | 496 | 477 |
| 2 | Факторинг | 34 | 40 | 45 |
| 3 | Төлбөрийн баталгаа гаргах | 21 | 24 | 28 |
| 4 | Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 5 | 5 | 5 |

[9] ***Эх сурвалж:*** *МББСБХ-ны 2022 оны үйл ажиллагааны тайлан*

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга | 34 | 36 | 37 |
| 6 | Гадаад валютын арилжаа | 147 | 146 | 140 |
| 7 | Итгэлцэл | 43 | 49 | 64 |
| 8 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 11 | 20 | 22 |
| 9 | Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх | 37 | 40 | 39 |
| 10 | Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа | - | 1 | 1 |

***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

*Нийт Хөрөнгө*

*График 11 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр*




***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30.2 хувиар буюу 817.1 тэрбум төгрөгөөр өсөж 3.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийг бүтцээр авч үзвэл 13.9 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт, 72.9 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал өсөлтийн 62.1 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна. Мөн нийт зардлын хэмжээ 78.3 хувиар өсөж 554.9 тэрбум төгрөг болсон ба цэвэр ашгийн хэмжээ 49.0 хувиар буюу 102.9 тэрбум төгрөгөөр өссөн.

*Нийт зээл*

2021 онд хэвийн зээлийн нийт зээлд эзлэх хувь 90.5 хувь байсан бол 2022 онд 88.5 хувь болж буурсан. Чанаргүй зээлийн хэмжээ 1.4 пункт, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 0.6 пунктээр тус тус өссөн байна. Урд хөрш болох БНХАУ цар тахлын улмаас хилийн хязгаарлалт тогтоосон нь дотоодын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн бөгөөд эдийн засаг удааширч өрхийн болон бизнесүүдийн орлого буурч зээлээ цаг хугацаанд нь төлөхөд хүндрэл учруулсан.

*Хүснэгт 12 2022 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн бүтэц, тэрбум төгрөгөөр*




**Эх сурвалж:** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

*Хүснэгт 13 2022 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн үлдэгдэл, ангиллаар*

| Зээлийн төрөл (тэрбум төгрөг) | Олгосон зээл | Төлөгдсөн зээл | Зээлийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **Иргэнд олгосон зээл** | **4,278.7** | **3,611.5** | **2,400.1** |
| Хэрэглээнд зориулсан зээл | 3,215.7 | 2,823.6 | 1,468.1 |
| Бизнест зориулсан зээл | 618.3 | 410.9 | 589.9 |
| Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл | 104.0 | 93.9 | 151.5 |
| Бусад зээл | 340.6 | 283.1 | 190.5 |
| **Хуулийн этгээдэд олгосон зээл** | **404.8** | **335.6** | **322.6** |
| Бизнесийн зээл | 335.3 | 277.8 | 261.7 |
| Автомашины зээл | 5.7 | 6.7 | 5.4 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн зээл | 14.0 | 9.4 | 13.4 |
| Бусад зээл | 49.8 | 41.7 | 42.1 |

**Эх сурвалж:** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

*График 12 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын ашигт ажиллагааны үзүүлэлт, сая төгрөгөөр*




**Эх сурвалж:** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

СЗХ
2023 .08. 01 өдөр
БҮРТГЭВ



2022 онд ББСБ-ууд нийт 868 тэрбум төгрөгийн орлого олж, 555 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 313 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 67 хувь буюу 347 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 78 хувь буюу 244 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 49 хувь буюу 103 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өмнөх онтой харьцуулахад хамгийн их өөрчлөлт орсон орлогын үзүүлэлт нь итгэлцлийн үйлчилгээний орлого байсан бөгөөд 4.1 дахин буюу 49 тэрбум төгрөгөөр өссөн. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаа төдийлөн өсөлт үзүүлээгүй бол 2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 67 хувь болон 43 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал болон ердийн бус зардал байна. Хүүгийн зардал болон хүүгийн бус зардал харгалзан 2.0 болон 1.7 дахин өссөн. Хүүгийн зардлын өсөлтийн 61 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал, 45 хувийг өрийн бичгийн хүүгийн зардлын өсөлт бүрдүүлж байна.

*График 13 2018-2022 оны байдлаарх ББСБ-ын цэвэр ашгийн маржин, хувиар*




***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

ББСБ-ын салбарын цэвэр ашгийн маржин 2018 онд 39.0 хувь байсан бол 2022 онд 36.1 хувь болж буурсан нь ББСБ-уудын эх үүсвэрийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 14 2023-2025 оны байдлаарх Монгол Улсын ББСБ салбарын төсөөлөл*

| ***Голлох үзүүлэлт*** | ***2022*** | ***2023Т*** | ***2024Т*** | ***2025Т*** |
|---|---|---|---|---|
| ДНБ 2015 оны зэрэгцүүлэх (тэрбум төгрөг) | 28,405 | 29,882 | 31,764 | 33,924 |
| *ДНБ өсөлт (хувиар)* | *4.7%* | *5.2%* | *6.3%* | *6.8%* |
| ДНБ оны үнээр (тэрбум төгрөг) | 52,867 | 55,616 | 59,120 | 63,140 |
| ББСБ салбарын актив (тэрбум төгрөг) | 3,527 | 4,452 | 5,680 | 7,279 |
| *ББСБ салбарын нэвтрэлт (хувиар)* | *6.7%* | *8.0%* | *9.6%* | *11.5%* |
| ББСБ салбарын зээл (тэрбум төгрөг) | 2,571 | 3,246 | 4,140 | 5,306 |
| *Зээлийн активд эзлэх хувь* | *72.9%* | *72.9%* | *72.9%* | *72.9%* |
| ББСБ салбарын орлого (тэрбум төгрөг) | 868 | 1,096 | 1,398 | 1,791 |



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

| | | | | |
|---|---|---|---|---|
| *Орлогын зээлийн харьцаа (хувиар)* | *33.8%* | *33.8%* | *33.8%* | *33.8%* |
| ББСБ салбарын ашиг (тэрбум төгрөг) | 313 | 395 | 504 | 646 |
| *Цэвэр ашгийн маржин (хувиар)* | *36.1%* | *36.1%* | *36.1%* | *36.1%* |

***Эх сурвалж:*** *Дэлхийн Банк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Шинжээчийн тооцоолол*

2022 онд ДНБ оны үнээр 52.9 их наяд төгрөг байсан ба Дэлхийн Банкны төсөөллөөр 2025 он гэхэд 63.1 их наяд төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Салбарын нийт актив 2022 онд 3,527 тэрбум төгрөг байсан ба энэ нь ДНБ-ий 6.7 хувийг бүрдүүлж байна. 2025 онд ББСБ салбарын актив 7,279 тэрбум төгрөг болж Монгол Улсын ДНБ-нд харьцуулж үзэхэд 11.5 хувийг эзлэх төсөөлөлтэй байна. 2022 онд ББСБ салбарын нийт зээлийн хэмжээ активын 72.9 хувийг буюу 2,571 тэрбум төгрөгтэй тэнцсэн бол 2025 онд 5,306 тэрбум төгрөг болох төсөөлөлтэй байна. ББСБ-уудын орлогын гол эх үүсвэр нь зээлээс шууд хамааралтай байдаг ба салбарын орлого 2022 онд 868 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 1,791 тэрбум болох төлөвтэй байна. 2022 оны байдлаар ББСБ салбарын цэвэр ашгийн маржин 36.1 хувьтай байгаа нь ирэх 3 жилийн хугацаанд цэвэр ашиг 313 тэрбум төгрөгөөс 646 тэрбум төгрөг болох төсөөлөлтэй байна.

*График 14 2022 оны жилийн эцсийн байдлаарх ББСБ-ын жигнэсэн дундаж зээлийн хүү, сараар*




***Эх сурвалж:*** *МББСБХ, 2022 оны жилийн тайлан*

2022 онд ББСБ-ууд 4.7 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 3.9 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдсөн.

*ББСБ-уудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

2022 оны жилийн эцсийн байдлаар 89 хувь буюу 458 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 11 хувь буюу 55 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

*Финтек зах зээл*

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 513 ББСБ-уудын 94 хувь нь технологид суурилсан зээлийн үйл ажиллагаа явуулж байна. Финтек зах зээлийн хувьд санхүүгийн

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

үйлчилгээнд техник технологийг ашиглаж үйл ажиллагаа явуулж буй 37 ББСБ байгаа ба зээлдэгчдийн 79 хувь, нийт зээлийн 17 хувийг эзэлж байна.[10]

*Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд*

Санхүүгийн үйлчилгээний шинэ техник технологийг ашигласнаар уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгосон бөгөөд онлайн зээлийг одоогийн байдлаар нийт 37 ББСБ үзүүлж байна. Эдгээрийн 7 ББСБ нь зөвхөн аппликэйшн ашиглан зээл олгож байгаа бол 30 ББСБ нь уламжлалт болон финтекийг хослуулан зээл болон бусад санхүүгийн үйлчилгээг иргэдэд санал болгож байна.

*Хүснэгт 15 2023 оны хагас жилийн байдлаарх апп ашиглан зээл олгож байгаа ТОП-10 ББСБ, App Store таталтаар*

| *Финтек* | *App Нэр* | *Таталт* |
|---|---|---|
| Лэнд мн | Lendmn | +1 сая |
| Ард Кредит | Ard app | +1 сая |
| Мобифинанс | Monpay | +1 сая |
| Инвескор хэтэвч | Pocket | +500 мянга |
| Соно финтек | Sono Mongolia | +100 мянга |
| Зээл Эм Эн платформ | Zeel.mn | +100 мянга |
| Нөмөр кредит | Numur | +100 мянга |
| Хатан суудал инвест | Zeely | +100 мянга |
| Централ капитал | Kmobi | +100 мянга |
| Ашид капитал | Simple | +100 мянга |

***Эх сурвалж:*** *Гүүгл Плей Стор*

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт ББСБ-ын харилцагчдын 17 хувь буюу 936 мянган үйлчлүүлэгч зөвхөн аппликэйшн ашиглан зээл авсан бөгөөд 461 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Аппликэйшн ашиглан нэг зээлдэгчид дунджаар 492.6 мянган төгрөгийн зээл олгосон нь уламжлалт зээлийн дунджаас 18 дахин бага байгаа хэдий ч ирээдүйд финтек зээл улам эрчимтэй хөгжиж эрэлттэй зээлийн хэрэгсэл болох хандлагатай байна.[11]

**Санхүүгийн салбарын цаашдын чиг хандлага**

Дэлхий дахинд санхүүгийн технологийн дэд бүтцийн суурь 1866 оноос тавигдаж, 1967 оноос дижитал хэлбэрт шилжих үйл явц эрчимтэй явагдсаны үр дүнд хиймэл оюун ухаан, блокчэйн технологид суурилсан шийдэл бүхий төрөл бүрийн программ хангамжууд олноор гарч байна. Үүнтэй холбоотойгоор финтекийн зах зээлд хийх хөрөнгө оруулалтын хэмжээ 2022 оны байдлаар 75.2 тэрбум долларт хүрээд байна.[12]

КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дижитал шилжилтийн хүчин чармайлтууд хийгдэж банкнуудад үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлснээр дижитал банкны хэрэглээ өссөн. 2026 он гэхэд Дэлхийн нийт хүн амын 53 хувь дижитал банкны эрхтэй болж, хэрэглэгчдийн тоо 2022 оноос 2026 оны хооронд 2.6 тэрбумаас 4.2 тэрбум болж өсөх

[10] ***Эх сурвалж:*** *МББСБХ-ны 2022 оны үйл ажиллагааны тайлан*
[11] ***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны ББСБ-ын тайлан*
[12] ***Эх сурвалж:*** *CB Insights, State Of Fintech 2022 Report: Investment & Sector Trends To Watch*



АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ⊕ 5459567
2023 ...өр 01 өдөр ... БҮРТГЭВ
2023-08-04
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

төлөвтэй байна. Ирэх 5 жилд БНХАУ нь дижитал банкны зах зээлийн томоохон оролцогчдын нэг болж, нийт зах зээлийн 25 хувийг БНХАУ-ыг дижитал банкны хэрэглэгчид бүрдүүлэх төлөвтэй байна.[13]

Монгол Улсын санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж, дижитал банкны шилжилт эрчимтэй хийгдэж байна. Үүнээс Банк бус санхүүгийн байгууллагын активын, зээлийн өсөлт нь бусад санхүүгийн байгууллагуудтай харьцуулахад өндөр байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд интернэт хандалтын эрхтэй хэрэглэгчийн тоо 44 хувиар нэмэгдсэн байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсад нийт 3.6 сая интернэт хандалтын хэрэглэгч байна. Тэдгээрээс 78 хувь нь идэвхтэй хэрэглэгч байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 75.3 их наяд төгрөгийн гүйлгээ хийсний 90.9 хувийг зөвхөн гар утасны аппаар дамжуулан хийжээ. Мобайл хандалтын эрхтэй буюу гар утаснаас банк санхүүгийн үйлчилгээ авч буй 1.9 сая хэрэглэгч байгаагаас 455 мянга нь өдөр тутамдаа идэвхтэй ашиглаж байна.[14]

Арилжааны банкнууд финтек компаниудтай хамтран ажиллах хандлага ажиллагдаж байгаа ба банкнуудын үүсгэсэн дэд бүтцийг бусад санхүүгийн байгууллага дэмжин ажилласнаар үйлчилгээний зардал буурч, хурд нэмэгдэж байна.

## 2.3. Өрсөлдөгчийн судалгаа

2010 оны байдлаар Монгол Улсад 182 ББСБ байгууллага үйл ажиллагаа явуулж байсан бол 2022 оны байдлаар тус тоо 513 болж өссөн. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө 2010 оны байдлаар 128.6 тэрбум төгрөг байсан бол 12 жилийн дотор 27.5 дахин өсөж 3.5 их наяд төгрөгт хүрч, нийт зээл 78 тэрбум төгрөгөөс 2.6 их наяд төгрөгт хүрсэн. ББСБ-ын хурдацтай өсөлтөд техник технологийн дэвшил ихээр нөлөөлж байгаа бөгөөд 2022 оны байдлаар 513 ББСБ үйл ажиллагаа явуулж буйгаас 37 нь онлайнаар зээл олгож байна.

### Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр сууриь

Ард Кредит нь 2011 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш санхүүгийн салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зах зээлд манлайлан ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулсаар салбартаа тэргүүлэгч банк бус санхүүгийн байгууллагын нэг болоод байна.

Үнэт цаас гаргагчийн өрсөлдөгч компаниудад дараах ББСБ-ууд хамаарна. Үүнд:
- Лэндмн
- Мобифинанс
- Инвескор хэтэвч
- Инвескор ББСБ

Дээрх компаниудыг сонгохдоо бүтээгдэхүүн үйлчилгээний төстэй байдал, апп таталтын тоо болон зах зээл дээр эзлэх байр сууриь зэрэгт үндэслэсэн.

[13] **Эх сурвалж:** *Digital banking: banking-as-a-service, open banking & digital transformation 2021-2026*
[14] ***Эх сурвалж:** Монголбанкны Хөдөлгөөнт банкны тайлан, 2022 оны 3 дугаар улирал*



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ☏ 5459567

*Хүснэгт 16 2022 оны жилийн эцсийн байдлаарх өрсөлдөгч ББСБ-ын тоон үзүүлэлт, тэрбум төгрөгөөр*

| ББСБ | Нийт хөрөнгө | Харилцагчдад олгосон зээл | Нийт орлого | Цэвэр ашиг | ББСБ-н зах зээлд эзлэх хувь | Зээлийн хүү |
|---|---|---|---|---|---|---|
| Лэндмн | 71 | 65 | 16 | 2 | 2.0% | * |
| Мобифинанс | 42 | 26 | 6 | 2 | 1.2% | **1.9%-3.4%** |
| Инвескор хэтэвч | 20 | 8 | 12 | 8 | 0.6% | **3.5%** |
| Инвескор ББСБ | 225 | 266 | 50 | 25 | 6.4% | **2.8%-3.5%** |
| **Ард Кредит ББСБ** | **58** | **40** | **13** | **2** | **1.6%** | **1.5-3.0%** |
| **ББСБ** | **3,527** | **2,571** | **868** | **313** | **100.0%** | **-** |

**Лэндмн ББСБ ХК-ийн зээлийн хүү нь хүү болон шимтгэлээс бүрддэг тул дундаж хүүг тооцоолох боломжгүй байна.*

***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо, 2022 оны ББСБ-ын санхүүгийн тайлан*

Ард Кредит нь 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээгээр ББСБ-ын салбарын 1.6 хувийг эзэлж байна. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө сүүлийн 5 жилд дунджаар 29.7 хувиар өссөн бол Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө сүүлийн 5 жилд дунджаар 57.9 хувиар өссөн. Энэ нь Үнэт цаас гаргагч салбарын өсөлтөөс дунджаар 2 дахин илүү өссөнийг харуулж байна

*График 14. Нийт активын эзлэх хувь*




*График 15. Нийт цэвэр ашигт эзлэх хувь*




***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо*

Үнэт цаас гаргагч нь цэвэр ашгийн хэмжээгээр ББСБ-ын салбарын 1.6 хувийг, өрсөлдөгч 4 компани нь салбарын 12.0 хувийг, бусад 508 ББСБ-ууд нь 87.3 хувийг эзэлж байна. ББСБ-ын салбарын бүтцийг банкны салбартай харьцуулан үзэхэд төвлөрөл багатай байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын хувьд нийт зах зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл өмнөх жилийн салбарын дунджаас 1.4 пунктээр буурч 3.9 хувийг бүрдүүлсэн бол чанаргүй зээл 7.6 хувийг бүрдүүлжээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар Ард Кредитын хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 5.5 хувьтай байгаа нь ББСБ салбарын дунджаас 1.5 пунктээр бага харин чанаргүй зээлийн эзлэх хувь 7.8

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

2023 09 сар 01 өдөр



хувьтай байгаа нь салбарын үзүүлэлттэй ойролцоо байна. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанарын харьцаа салбарын үзүүлэлтээс илүү сайн эсвэл дүйцэж байна.

*Хүснэгт 17 2022 оны жилийн эцсийн байдлаарх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ*

| Зээлийн төрөл | 2021 | | 2022 | |
|---|---|---|---|---|
| | ББСБ салбар | Ард Кредит | ББСБ салбар | Ард Кредит |
| Эрсдэлтэй зээл (PAR) % | 9.5% | 9.2% | 11.5% | 13.2% |
| Чанаргүй зээл (NPL) % | 7.0% | 9.5% | 7.6% | 7.8% |

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Ард Кредитын бизнесийн зээлийн хүүг бусад өрсөлдөгч ББСБ-тай харьцуулан үзвэл санал болгож буй зээлийн дундаж хүүгийн түвшин нь харьцангуй бага буюу харилцагчдад олгох зээлийн хувьд дунджаар сарын 2.2 хувийн хүүтэй байна.

*График 15 2023 оны хагас жилийн байдлаарх зээлийн хүүгийн (сараар) судалгаа*




**Эх сурвалж:** *Компаниудын вэбсайт*

**Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт**

*Хүснэгт 18 2023 оны хагас жилийн байдлаарх апп-р үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт*

| Үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|
| Апп гаргагч | Ард Кредит ББСБ ХК | Лэндмн ББСБ ХК | Мобифинанс ББСБ ХХК | Инвескор Хэтэвч ББСБ ХХК |
| Нэвтрүүлсэн огноо | 2018.04.22 | 2016.12.13 | 2015.04.23 | 2020.01.20 |
| Татагдсан тоо | 1,000,000+ | 1,000,000+ | 1,000,000+ | 500,000+ |



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

| | | | | |
|---|---|---|---|---|
| Апп дамжуулан үзүүлж буй үйлчилгээ | -Мөнгөн шилжүүлэг<br>-Онлайн зээл<br>-Хадгаламж<br>-Ард Шоп<br>-Үнэт цаас<br>-Даатгал<br>-Тоглоом<br>-Дуудлага худалдаа | -Төлбөр тооцоо<br>-Зээл<br>-Даатгал<br>-Banana mall<br>-Хоол хүргэлт<br>-Интернэтийн үйлчилгээ<br>-Дуудлагын үйлчилгээ | -Төлбөр тооцоо<br>-Зээл<br>-Хоол хүргэлт<br>-Онлайн төлбөр<br>-Тоглоом, энтэртайнмент<br>-Даатгал | -Төлбөр тооцоо<br>-Зээл<br>-Тоглоом |

***Эх сурвалж:*** *Санхүүгийн Зохицуулах Хороо, Компаниудын вэбсайт*

*Хүснэгт 19 2023 оны хагас жилийн байдлаарх бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт*

| ***Үзүүлэлт*** | ARD | | monpay | pocket |
|---|---|---|---|---|
| Зээл | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| Онлайн дэлгүүр | ✓ | ✓ | ✓ | |
| Купон | | ✓ | ✓ | ✓ |
| Даатгалын үйлчилгээ | ✓ | ✓ | ✓ | |
| Үнэт цаас | ✓ | | | |
| Итгэлцлийн үйлчилгээ | ✓ | | | |
| Төлбөр тооцоо, шилжүүлэг | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| Карт | ✓ | | | ✓ |
| Мөнгөн гуйвуулга | ✓ | ✓ | | |

***Эх сурвалж:*** Компаниудын вэбсайт

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

АЙ КРЕДИТ ББСБ ХК

# ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 3.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ

Ард Кредит нь 2011 оны 3 сарын 22-ны өдөр Интергрупп Интернейшнл ХХК-ийн санаачилгаар үүсгэн байгуулагдаж 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн бүрэлдэхүүнд шилжсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 4 сарын 21-ний 108 тоот Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүрээнд 12 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани нь харилцагч дэлхийн хаанаас ч өөрийн санхүүгээ хүссэн цагтаа удирдах боломж бүхий санхүүгийн шинэлэг үйлчилгээг орчин үеийн технологи дээр тулгуурлан иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэхээр зорин ажилладаг бөгөөд Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлж байна:

**СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж буй үйл ажиллагаа**

- Зээл
- Гадаад валютын арилжаа
- Итгэлцэл
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга

**Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж буй үйл ажиллагаа**

- Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ
- Карт гаргагчийн зөвшөөрөл

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Ард Кредит нь дараах үйлчилгээнүүдийг үзүүлж байна:

**Зээлийн үйл ажиллагаа**

- Бичил жижиг дунд бизнесийн зээл
- Хэрэглээний зээл

**Итгэлцлийн үйл ажиллагаа**

- Итгэлцэл
- Cupcake (бутархай дүнгээр хуримтлал үүсгэх үйлчилгээ)

**Аппликэйшн**

- Ард Апп

**Картын үйлчилгээ**

- Кредит карт

Скопа төслийг хэрэгжүүлэв

Хуваан төлөх үйлчилгээ нэвтрүүлэв

Хүүхдэд зориулсан анхны санхүүгийн апликэйшн нэвтрүүлж 43К харилцагчтай болов

Монголын Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) Холбоонд элсэв

Гүйлгээ бүрээс хуримтлал үүсгэх үйлчилгээ нэвтрүүлэв

Мони Маркет Фанд ХХК-тай хамтран ажиллаж эхлэв

Хөрөнгө Оруулагч Үндэстэн 22 Чуулган зохион байгуулав



Монголбанкнаас карт гаргах тусгай зөвшөөрөл авав

АРД КРЕДИТ ББСБ ХК

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

2023 09 сар 01 өдөр
ХҮЛЭЭН АВСАН



**Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа**

Ард Кредит нь онлайн зээл, бизнесийн зээл, хэрэглээний зээл болон хөрөнгө барьцаалсан зээлийг харилцагчдадаа санал болгон ажилладаг. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн 53.6 хувийг онлайн зээл, 42.5 хувийг бизнесийн зээл, 3.9 хувийг хэрэглээний зээл эзэлж байна. Зээлийн хүү сарын 2.4-6.0 хувийн хооронд байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 595.1 мянган зээлийн хүсэлт авч 95.0 тэрбум төгрөгийн зээл олгон, оны эхнээс өссөн дүнгээр 50.5 мянган зээлдэгчтэй болсон.

*Хүснэгт 20 Зээлийн үйлчилгээний мэдээлэл*

| *Зээл* | *Бизнесийн зээл* | *Хэрэглээний зээл* | *Шуурхай зээл* | *Ард Апп* |
|---|---|---|---|---|
| **Төрөл** | - Бичил жижиг дунд бизнесийн зээл<br>- Зээлийн шугам | - Өрхийн зээл<br>- Лизинг | - Барьцаат зээл | - Онлайн зээл |
| **Хэмжээ** | ₮20-500 сая | ₮2-50 сая | ₮20-100 сая | ₮50 мянга-10 сая |
| **Хугацаа** | 12-36 сар | 3-36 сар | 1-12 сар | 1-6 сар |
| **Хүүгийн түвшин (сарын)** | 2.4%-2.8% | 2.6%-2.8% | 3.0%-3.5% | 3.5-6.0% |

**Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйл ажиллагаа**

Ард Кредит нь 2014 онд итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан. Тус үйлчилгээг төгрөг болон 2 төрлийн гадаад валютаар (доллар, евро) харилцагчдадаа санал болгон ажилладаг ба 2023 оны эхний улирлын байдлаар 14.3 тэрбум төгрөгийн итгэлцэлтэй болсон байна. Итгэлцлийн үйлчилгээний өгөөж нь валют, хугацаанаас хамааран харилцан адилгүй байх ба Үнэт цаас гаргагч нь 3-24 сарын хугацаатай төгрөгийн жилийн 14.0-20.0 хувь, долларын 5.5-8.0 хувь, еврогийн 2.0-4.5 хувийн хүүтэй итгэлцлийг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

*Хүснэгт 21 Итгэлцлийн үйлчилгээний мэдээлэл*

| *Итгэлцэл* | *Төгрөг* | *Доллар* | *Евро* |
|---|---|---|---|
| **Доод хэмжээ** | ₮500 мянга | $200 | €1,000 |
| **Хугацаа** | 3-24 сар | 6-12 сар | 6-12 сар |
| **Жилийн өгөөж** | 14.0%-20.0% | 5.5%-8.0% | 2.0%-4.5% |

**Ард Апп үйлчилгээ**

Үнэт цаас гаргагч нь 2018 онд анх санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-ийн эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Үүнээс хойш тасралтгүй хөгжүүлэлтийг хийж, V5-ийг нэвтрүүлээд байгаа ба Ард Аппаар дамжуулан 24/7 горимоор мөнгөн шилжүүлэг, онлайн зээл, хадгаламж, худалдан авалт, үнэт цаас, даатгал зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой болсон байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

# АРД АПП ҮЙЛЧИЛГЭЭ

## Ард Апп

Санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан 24/7 горимоор үзүүлж байна. Үүнд:

- Бүх төрлийн төлбөр тооцоо, гүйлгээ
- Цахим зээл
- Урт болон богино хугацаат хуримтлалын үйлчилгээнүүд
- Онлайн дэлгүүр
- Үнэт цаас
- Даатгал

- **Харилцагчийн тоо**
  **1,019,392**
- **Апп таталт**
  **269,339**
- **Дундаж зээл олголт**
  **945,600 төгрөг**







## АрдКидс

Хүүхдийн санхүүгийн хэрэглээг цогц хангасан Монголын анхны хүүхдэд зориулсан аппликейшн юм. 2022 онд АрдКидс Аппад Ирээдүйн Ээзн хүүхдийн хадгаламж, аав ээжээсээ утасны дугаараар дамжуулан АрдКойн хүлээн авах, гадаад улсад амьдарч буй хүүхдүүд утасны дугаараар дамжуулан бүртгүүлэх, найзаа урьж АрдКойн цуглуулах боломжийг нэвтрүүлээ. Мөн хүртээмжтэй байдал талаас аав ээж нь хүүхдээ утасны дугаараас гадна регистрийн дугаараар бүртгүүлэн урамшуулалт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нээлээ.

#БидИлүүБайжЧадна аяны хүрээнд Монгол улсын бүх хүүхдийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгохоор ажиллаж байна.

- **Харилцагчийн тоо** **37,440**

АРД КРЕДИТ ББСБ ХК

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

**Картын үйлчилгээ**

Ард Кредит нь 2022 онд "Карт гаргагчийн тусгай зөвшөөрөл" авч ББСБ-ын салбартаа анх удаа Кредит картын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна.

Ардын Кредит карт нь Ардын үнэнч харилцагч нартаа зориулсан, банкнуудтай өрсөлдөхүйц таатай нөхцөлтэй бүтээгдэхүүн юм. Ардын үнэнч харилцагчид өндөр өгөөжийг хөрөнгө оруулалтаас, өдрийн хэрэгцээгээ Кредит картаар санхүүжүүлэх боломжийг олгодог.

Энэ бүтээгдэхүүн худалдаа, үйлчилгээний газраас ПОС төхөөрөмжөөр дамжуулан тус картаар худалдан авалт хийхэд 30 хүртэл хоногт хүү бодогдохгүй бөгөөд худалдан авалт бүрд урамшуулал олгодог. Кредит картаасаа бэлэн мөнгө авах, картаа мартсан тохиолдолд Ард Аппаар дамжуулан тус данснаасаа QPay-ээр төлбөр тооцоогоо төлөх боломжтойгоороо давуу талтай.

*Зураг 11 Картын үйлчилгээний мэдээлэл*

| | Элит | Премиум |
|---|---|---|
| **Нөхцөл** |  |  |
| **Эрхийн хэмжээ** | ₮5 - 20 сая | ₮1-5 сая |
| **Хүү** | 2.0%-2.9% | 2.0%-3.2% |
| **Хугацаа** | 24 сар | |
| **Эргэн төлөлт** | 10% | |

**Бусад бүтээгдэхүүн үйлчилгээ**

1. **EuroGiro үйлчилгээ** - Ард Кредит ББСБ ХК, Монгол Шуудан ХК хамтран дэлхийн 50 гаруй улс, санхүүгийн байгууллагын 500 мянган салбар, 4 тэрбум хүнийг төлбөр тооцооны дэд бүтцээр холбодог Eurogiro байгууллагын "Санхүүгийн супермаркет" системд холбогдсоноор олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлсэн. Тус системд нэгдсэнээр Ria, KoronaPay, Small world, PostalPay зэрэг дэлхийн томоохон мөнгөн гуйвуулгын операторуудын системд нэгдэж Монгол шуудангийн салбарууд дэлхийн 50 гаруй орны 400,000 гаруй шуудангийн салбараас мөнгө хүлээн авах боломжтой болсон. Одоогоор Монгол улсаас БНСУ руу мөнгө илгээх боломжтой байгаа бол мөнгө хүлээн авах боломжтой улсуудын тоонд АНУ, БНСУ, Хятад, ОХУ, Австрали, Турк, Их Британи, Европын Холбооны улсуудаас гадна 50 гаруй улс орсон байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

2. **Fast cash, Fast Cash White үйлчилгээ -** Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа 6 сарын хугацаатай, эхний 30 хоног хүүгүй, дараа сараас нь сарын 3.5-6 хувийн хүүтэй Fast cash онлайн зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс гадна хувьцаа эзэмшигчдэдээ тусгайлан зориулсан хөнгөлөлттэй нөхцөлтэй Fast Cash White онлайн зээлийн үйлчилгээг санал болгож байна.

3. **Хуримтлал барьцаалсан зээл -** Ард Кредит нь тэтгэврийн хуримтлал, итгэлцэл барьцаалсан зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Итгэлцэл барьцаалсан зээл нь итгэлцлийн үнийн дүнгийн 80 хувь хүртэл үнийн дүнгээр итгэлцлийн хүү дээр 8 хувийг нэмсэн хүүгээр гардаг ба хугацаа нь итгэлцлийн хугацаанаас ихгүй байдаг. Тэтгэврийн хуримтлал барьцаалсан зээл нь тэтгэврийн хуримтлалын дүнгийн 80 хувь хүртэл үнийн дүнгээр сарын 1.9 хувийн хүүгээр гардаг ба 12 сарын хугацаатай байна.

4. **АрдКидс үйлчилгээ -** Хүүхдийн санхүүгийн хэрэглээг цогц хангасан Монголын анхны хүүхдэд зориулсан аппликейшн юм. 2022 онд АрдКидс Аппад Ирээдүйн Эзэн хүүхдийн хадгаламж, аав ээжээсээ утасны дугаараар дамжуулан АрдКойн хүлээн авах, гадаад улсад амьдарч буй хүүхдүүд утасны дугаараар дамжуулан бүртгүүлэх, найзаа урьж АрдКойн цуглуулах боломжийг нэвтрүүлсэн. Мөн хүртээмжтэй байдал талаас аав ээж нь хүүхдээ утасны дугаараас гадна регистрийн дугаараар бүртгүүлэн урамшуулалт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой юм. "БидИлүүБайжЧадна" аяны хүрээнд Монгол улсын бүх хүүхдийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгохоор ажиллаж байна.

5. **CupCake - Хариултаа хадгал.** CupCake нь хуримтлалын цоо шинэ төрлийн үйлчилгээ бөгөөд бүрэн автоматжсан гэдгээрээ онцлог юм. Харилцагч гүйлгээ хийх бүртээ ₮100, ₮1,000, ₮5,000, ₮10,000 гүйлгээний дүнгээ бүхэлчилж хуримтлалдаа хялбар байдлаар орлого нэмэх боломжтой бөгөөд харилцагчдын таашаалд нийцсэн бүтээгдэхүүн юм.

6. **Pick n Pay.** Хэрэгцээт бараагаа хүү, шимтгэлгүйгээр Pick n Pay зээлийн бүтээгдэхүүнээр худалдан авах ба бараа бүтээгдэхүүнийг дэлгүүрийн үнээр 60 хоногт 3-5 удаа хуваан төлөх боломжтой юм. Үүгээр зогсохгүй худалдан авалт бүрийг үнийн дүнгийн 1%-иар урамшуулал олгодог.

### 3.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

КОВИД-19 цар тахал нь бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд олон талаар сөрөг нөлөө үзүүлсэн ч финтекийн хөгжил, ББСБ-ын цахим үйлчилгээнд эергээр нөлөөлөн цахим хөгжлийг хурдасгасан.

*График 16 Апп хэрэглэгчийн тоо*




**Онлайн зээлийн хүсэлт**

*График 17 Онлайн зээлийн хүсэлтийн тоо*




**Онлайн зээл олголтын статистик**

2018 оны сүүл үеэс Үнэт цаас гаргагчийн онлайн зээл олголт эхэлж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 35.04 тэрбум төгрөгийн 76,123 зээлийг цахимаар олгосон байна. 2021 онд Ард Кредит нь онлайн зээл олголтоо харилцагчдынхаа зээлийн хэрэгцээг уялдуулж ажилласан ба үнэт цаас гаргагчийн зээл олголт өмнөх оны мөн үеэс 2 дахин буюу 42.9 тэрбум төгрөгөөр өсөж 84.5 тэрбум төгрөг болсон. Онлайн зээлийн олголт нэмэгдсэн нь Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Кредит компанийн маркетингийн үйл ажиллагаа идэвхжиж, Ард Апп хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн зэрэг хүчин зүйлстэй холбоотой байна. 2022 онд 94.5 тэрбум төгрөгийн зээл олголт хийсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 18 Онлайн зээл олголт (зүүн тэнхлэг - тэрбум төгрөг, баруун тэнхлэг - тоо)*




**Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа**

Ард Кредит нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 94.9 тэрбум төгрөгийн зээл олгосон ба үүнээс 65.8 хувийг цахим зээл, 31.5 хувийг бизнесийн зээл, 2.7 хувийг хэрэглээний зээл эзэлж байна. Үнэт цаас гаргагчийн зээлийн багц 41.8 тэрбум төгрөг байгаа ба үүнээс 22.4 тэрбум төгрөг буюу 53.6 хувь нь цахим зээл байна.

*Хүснэгт 22 Зээлийн үйл ажиллагааны мэдээлэл (тэрбум төгрөг)*

| *Үзүүлэлт* | *2020* | *2021* | *2022* |
|---|---|---|---|
| **Нийт зээлийн багц (тэрбум төгрөг)** | **20.3** | **36.65** | **41.80** |
| хэрэглээний зээл | 1.8 | 2.3 | 2.2 |
| бизнесийн зээл | 6.9 | 11.9 | 18.2 |
| цахим зээл | 11.6 | 22.5 | 21.4 |

2022 оны жилийн эцсээр Үнэт цаас гаргагч нь 41.8 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болсон ба энэ нь 2021 оны жилийн эцсээс 14 хувь буюу 5.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн багцын өсөлтөд жижиг, дунд бизнесийн зээлийг түлхүү олгосон нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн зах зээлд цахим үйлчилгээ эрчимтэй хөгжиж буйн хэрээр банк бус санхүүгийн байгууллагын цахим зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ өсөж байна. 2018 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн цахим зээл нийт зээлийн багцын 0.4 хувийг эзэлж байсан бол энэхүү хувь хэмжээ өссөөр 2022 оны байдлаар 53.6 хувийг эзэлж байна. Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ нь уг өсөлтөд шууд хамааралтай.

*График 19 Зээлийн багцын чанар*




2020-2022 онуудад цар тахал, макро эдийн засгийн таагүй нөлөөгөөр санхүүгийн салбарын чанаргүй зээлийн хувь хэмжээ өссөн. 2022 оны жилийн эцсээр Банкны салбарын нийт зээлийн 9.1 хувийг, ББСБ-н салбарын нийт зээлийн 7.6 хувийг чанаргүй зээл бүрдүүлсэн. Харин Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын 7.8 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байгаа нь салбарын үзүүлэлттэй ойролцоо, банкны салбараас доогуур байна.

2022 оны жилийн эцсээр нийт зээлийн багцын 86.8 хувийг хэвийн зээлийн багц, 5.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 7.8 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийг бууруулж, онлайн зээлийн кредит скорингийн үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгохоор тогтмол ажилладаг.

*Хүснэгт 23 Зээлийн эрсдэлийн сан, 2022 оны байдлаар*

| ***Зээлийн төрөл (тэрбум төгрөг)*** | ***2022*** | ***Байгуулбал зохих сан*** | ***Нийт байгуулсан*** | ***Нэмж байгуулсан*** |
|---|---|---|---|---|
| **Нийт зээл** | **41.80** | **-1.23** | | |
| Хэвийн зээл | 36.27 | - | | |
| Хугацаа хэтэрсэн зээл | 2.28 | 0.11 | | |
| **Чанаргүй зээл** | **3.25** | **-1.12** | -1.76 | -0.53 |
| Хэвийн бус | 2.69 | -0.67 | | |
| Эргэлзээтэй | 0.24 | -0.12 | | |
| Муу | 0.32 | -0.32 | | |

*Хүснэгт 24 Зээлийн эрсдэлийн сан, 2021 оны байдлаар*

| ***Зээлийн төрөл (тэрбум төгрөг)*** | ***2021*** | ***Байгуулбал зохих сан*** | ***Нийт байгуулсан*** | ***Нэмж байгуулсан*** |
|---|---|---|---|---|
| **Нийт зээл** | **36.65** | **-1.35** | | |
| Хэвийн зээл | 33.27 | - | | |
| Хугацаа хэтэрсэн зээл | 0.80 | -0.04 | -2.47 | -1.12 |
| **Чанаргүй зээл** | **2.57** | **-1.31** | | |
| Хэвийн бус | 1.37 | -0.34 | | |

2023 09 01 өдөр
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5450567
СТАНДАРТ

| | | |
|---|---|---|
| Эргэлзээтэй | 0.48 | -0.24 |
| Муу | 0.73 | -0.73 |

*Хүснэгт 25 Зээлийн эрсдэлийн сан, 2020 оны байдлаар*

| ***Зээлийн төрөл (тэрбум төгрөг)*** | ***2020*** | ***Байгуулбал зохих сан*** | ***Нийт байгуулсан*** | ***Нэмж байгуулсан*** |
|---|---|---|---|---|
| **Нийт зээл** | **20.30** | **1.15** | | |
| Хэвийн зээл | 17.23 | - | | |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1.15 | 0.06 | | |
| **Чанаргүй зээл** | **1.92** | **1.09** | -1.35 | -0.22 |
| Хэвийн бус | 0.62 | 0.16 | | |
| Эргэлзээтэй | 0.71 | 0.36 | | |
| Муу | 0.58 | 0.58 | | |

*Хүснэгт 26 Зээлийн эрсдэлийн сан, 2019 оны байдлаар*

| ***Зээлийн төрөл (тэрбум төгрөг)*** | ***2019*** | ***Байгуулбал зохих сан*** | ***Нийт байгуулсан*** | ***Нэмж байгуулсан*** |
|---|---|---|---|---|
| **Нийт зээл** | **18.43** | **0.66** | | |
| Хэвийн зээл | 1.34 | - | | |
| Хугацаа хэтэрсэн зээл | 0.53 | 0.07 | | |
| **Чанаргүй зээл** | **0.41** | **0.59** | -0.66 | - |
| Хэвийн бус | 0.26 | 0.13 | | |
| Эргэлзээтэй | 18.43 | 0.20 | | |
| Муу | 15.90 | 0.26 | | |

2022 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу нийт 1.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулахаас 0.5 тэрбум төгрөгөөр илүү буюу 1.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан.

Ард Кредитын нийт харилцагчдын 50 хувь, нийт зээлдэгчдийн 62 хувийг эмэгтэй харилцагчид бүрдүүлж байна. Цаашид Үнэт цаас гаргагч нь нийгмийн тэгш эрхийг хангах, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлд ажиллахаар төлөвлөж байна.

## 3.3. Үнэт цаас гаргагчийн стратеги

Ард Кредитын бизнесийн үйл ажиллагааны үндсэн зорилгын хүрээнд орчин үеийн санхүүгийн дэвшилтэт технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний болон бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэн ажилладаг. Компани нь улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зээлийн үйл ажиллагааг Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан явуулах бодлого баримталдаг. Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжсэнээр эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг устгах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, тэгш бус байдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлснээр Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ард Кредит нь ирэх 3 жилд шинээр Ард аппликэйшнд суурилсан санхүүгийн үйлчилгээ, ногоон зээл, мерчантын зээл зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа хүртээмжтэй хүргэн ажиллах бөгөөд дараах зээлийн бодлогын хүрээнд үйл ажиллагааг явуулахаар төлөвлөсөн.

- Орчин үеийн дэвшилтэт санхүүгийн технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд бичил, жижиг дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэнэ.
- Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг PHYGITAL байдлаар буюу финтек санхүүгийн үйлчилгээг өөрийн төв, салбар болон хамтран ажиллагч байгууллагуудын салбаруудаар дамжуулан үзүүлнэ.
- Зээлийн бүтээгдэхүүний зорилтот зах зээл нь байгууллагын болон иргэдийн зээл байх бөгөөд 2024 онд зээлийн багцын 24 хувийг хэрэглээний зээл, үлдсэн 76 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн бүтээгдэхүүнээр бүрдүүлэх бол 2025 онд зээлийн багцын 20 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнээр, 80 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн үйлчилгээгээр бүрдүүлэхээр төлөвлөсөн.
- Нийгэм, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулах "Ногоон зээл"-ийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь хэрэглээний зээл болон бичил, жижиг, дунд бизнесийн зээлийг дижитал /digital буюу финтек/ болон фижитал /PHYGITAL буюу финтек болон биет салбарыг хослуулан/ байдлаар хүргэхээр төлөвлөсөн. Ард Кредит нь ирэх 3 жилийн стратегийн хүрээнд өөрийн салбараас гадна 21 аймаг дахь "Ард Даатгал" ХК-ийн салбарууд, мөн 21 аймаг, 330 сум дахь Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулах бөгөөд 2022 оны эцсийн байдлаар компани нь бизнесийн, хэрэглээний, шуурхай гэсэн 3 төрлийн үндсэн зээлд хуваагдах 18 төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа хүргэж байсан бол ирэх жилүүдэд санхүүгийн үр ашигтай байдал, хүртээмжтэй байдлыг бий болгох стратегийн хүрээнд бичил, жижиг дунд бизнесийн зээл, хөрөнгө барьцаалсан зээл, хэрэглээний зээлд төвлөрөн ажиллахаар төлөвлөсөн.

*Бүтээгдэхүүн үйлчилгээний зээлийн багцад эзлэх хувь*

Компани нь Fast Cash онлайн зээлийг зах зээлд нэвтрүүлсэнтэй холбоотой 2019 оны 12 сарын байдлаар 25 мянга гаруй харилцагчтай байсан бол 2021 онд Ард Санхүүгийн Нэгдэл, түүний охин компаниудын хувьд үсрэнгүй хөгжлийн жил байсантай холбоотойгоор харилцагчийн тоо огцом өсөлт үзүүлж 1 сая харилцагчтай болсон. Цаашид эдгээр харилцагчдаа тогтоон барих стратеги баримталж, ирэх 3 жилд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж байгаатай холбогдуулан харилцагчийн тоо жил бүр дунджаар 2 хувиар өсөж, 2025 онд 1.09 сая харилцагчтай болохоор ажиллаж байна.

*Хүснэгт 27 Зээлийн тоо, зээлийн багцын төсөөлөл*

| *Үзүүлэлт* | *2021* | *2022* | *2023** | *2024** | *2025** |
|---|---|---|---|---|---|
| Харилцагчийн тоо | 1,012,184 | 1,019,392 | 1,053,511 | 1,071,665 | 1,092,776 |
| Зээлийн тоо | 47,708 | 50,459 | 58,496 | 73,090 | 98,527 |
| Зээлийн багц *(сая төгрөг)* | 36,646 | 41,798 | 50,609 | 79,731 | 111,096 |

Ард Кредит нь 2022 онд 41.8 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байсан бөгөөд ирэх 3 жилд зээлийн багцаа дунджаар 48 хувиар өсгөж, 2025 онд 111.1 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болох бөгөөд зээлийн багцын 80.0 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээл, үлдсэн 20.0 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрдүүлэн ажиллана. Үнэт цаас гаргагч нь "Ногоон зээл"-ийн бодлогыг хэрэгжүүлэх ба 2025 онд нийт зээлийн багцынхаа 10 хувийг "Ногоон зээл" болгохоор дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн.

- Хэрэглээний зээлд хүлэмжийн хийг бууруулахад нөлөөлөх эко автомашин буюу цахилгаан автомашины зээл, мөн хайбрид буюу цахилгаан, бензин хосолсон хөдөлгүүртэй автомашины зээл олгох;
- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, амины орон сууцны зээл олгох.

*Автомашин худалдан авахад зориулан олгох болон барьцаалан олгох зээлийг онцолбол:* Агаарын бохирдлын эсрэг, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа болон арга хэмжээг дэмжин ажиллах нь Ард Кредитын үндсэн зорилгуудын нэг бөгөөд Компани нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсээр ирсэн.

Үнэт цаас гаргагч нь энэхүү зорилгынхоо хүрээнд автомашин худалдан авахад зориулсан зээлийг банк, санхүүгийн байгууллагуудтай өрсөлдөхүйц нөхцөлтэйгээр санал болгодог. Тус бүтээгдэхүүн нь 100 хувь цахилгаан автомашин болон хайбрид автомашин худалдан авахад зориулан олгох зээл ба 2023 он гарснаас хойш 310 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Автомашин барьцаалсан зээлийг олгохдоо автомашины үйлдвэрлэсэн жил, Монгол улсад орж ирсэн он зэрэг байгаль орчинд ээлтэй байдлыг харгалзан 36 хүртэл сарын хугацаатайгаар санал болгож байна.

Ард Кредит нь цаашид энэхүү байгаль орчин хамгаалах аливаа бодлогыг хөхүүлэн дэмжих, тэр дундаа Улаанбаатар хотын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн автомашин худалдан авах, барьцаалах бүтээгдэхүүнийг түлхүү олгох замаар өөрийн хувь нэмрээ оруулан ажиллахаар төлөвлөсөн. Үүний үр дүнд Үнэт цаас гаргагч нь "ногоон зээл"-ийн багцыг бүрдүүлж хүлэмжийн хий бууруулсны төлбөрийг ч мөн хүлээн авах боломжтой болох юм.

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 5459567
ИНВЕСТМЕНТ ҮЦК

# ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.1. Санхүүгийн үзүүлэлт, шинжилгээ

### Орлогын тайлан

*Хүснэгт 28 Орлогын тайлан*

| *Үзүүлэлт, мянган төгрөгөөр* | *2020* | *2021* | *2022* | *Өөрчлөлт* | |
|---|---|---|---|---|---|
| | | | | *2021* | *2022* |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 6,306,995 | 7,768,611 | 11,339,294 | 23.2% | 46.0% |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (2,122,526) | (3,913,870) | (6,513,600) | 84.4% | 66.4% |
| **Хүүгийн цэвэр орлого** | **4,184,469** | **3,854,741** | **4,825,694** | **-7.9%** | **25.2%** |
| Хүүгийн бус орлого | 2,075,579 | 7,588,882 | 5,945,035 | 265.6% | -21.7% |
| Хүүгийн бус зардал | (3,369,727) | (5,136,329) | (6,335,565) | 52.4% | 23.3% |
| **Цэвэр хүүгийн бус орлого** | **(1,294,148)** | **2,452,553** | **(390,530)** | **-289.5%** | **-115.9%** |
| Болзошгүй эрсдэлийн зардал | (1,326,564) | (2,145,842) | (2,530,969) | 61.8% | 17.9% |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 155,944 | 678,569 | 575,759 | 335.1% | -15.2% |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (292,586) | (292,033) | (45,389) | -0.2% | -84.5% |
| **Татварын өмнөх ашиг** | **1,427,115** | **4,547,988** | **2,434,565** | **218.7%** | **-46.5%** |
| Орлогын татварын зардал | (186,340) | (623,171) | (375,341) | 234.4% | -39.8% |
| **Цэвэр ашиг** | **1,240,775** | **3,924,817** | **2,059,224** | **216.3%** | **-47.5%** |
| Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл | 736,222 | 6,076,453 | (10,365,665) | 725.4% | -270.6% |
| Хэрэгжсэн олз | 94,415 | 624,468 | - | 561.4% | -100.0% |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | **2,071,412** | **10,625,738** | **(8,306,441)** | **406.4%** | **-178.2%** |

*Үйл ажиллагааны орлого*

*График 20 Үйл ажиллагааны орлогын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр*



СЗХ
БҮРТГЭВ
№ 01



2022 оны жилийн эцсийн байдлаар Ард Кредитын үйл ажиллагааны орлого 11 хувиар өсөж 17.86 тэрбум төгрөгт хүрсэн ба тус өсөлт нь Компанийн зээлийн багц өсч, онлайн зээл нэмэгдэж хүү болон түүнтэй адилтгах орлого өссөнтэй холбоотой байна. Нийт үйл ажиллагааны орлогын 63 хувийг хүү болон түүнтэй адилтгах орлого, 33 хувийг хүүгийн бус орлого, 3 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого тус тус бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн голлох үзүүлэлт болох үйл ажиллагааны орлого өнгөрсөн 3 жилийн хугацаанд дунджаар 42 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь салбарын өсөлт болох 36 хувиас 6 пунктээр өндөр байна. Хүүгийн орлогын 72 хувийг онлайн зээл, 26 хувийг жижиг дунд бизнесийн зээл, 2 хувийг шуурхай зээл голчлон бүрдүүлж байна.

*Үйл ажиллагааны зардал*

*График 21 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр*




2022 оны жилийн эцсийн байдлаар Ард Кредитын нийт үйл ажиллагааны зардал өмнөх онтой харьцуулахад 38 хувиар өсөж 12.89 тэрбум төгрөгт хүрсэн. Зардлын өсөлт нь Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн өртөг Монголбанкны зүгээс дунд хугацааны инфляцын хүлээлтийг тогтворжуулах, төгрөгийн өгөөжийг өсгөх зорилгоор 2022 оны 12 сард 13 хувь болтол өсгөсөнтэй холбоотой нэмэгдэж хүү болон түүнтэй адилтгах зардал өссөнтэй холбоотой байна. Нийт үйл ажиллагааны зардлын 51 хувийг хүү болон түүнтэй адилтгах зардал, 49 хувийг хүүгийн бус зардал тус тус бүрдүүлж байна.

*Ашигт ажиллагаа*

*График 22 Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр*




УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ☎ 5459567

СЗХ
2023 .08. 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 онд Үнэт цаас гаргагч нь 2.06 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 47.53 хувиар буурсан үзүүлэлт болович 2020 оны үзүүлэлтээс 2 дахин өндөр үзүүлэлт юм. Хэдий хүүгийн цэвэр орлого 25.19 хувиар өсөж 4.83 тэрбум төгрөгт хүрсэн ч хүүгийн бус зардал өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан байгуулсны үр дүнд өссөнтэй холбоотойгоор цэвэр ашгийн маржин буурсан байна. Энэ нь цаашид тооцоологүй зардлыг бууруулж чадвал цэвэр ашгийн маржинг өндөр байлгах бүрэн боломжтойг харуулж байна.

### Санхүүгийн байдлын тайлан

*Хүснэгт 29 Санхүүгийн байдлын тайлан*

| *Үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр* | *2020* | *2021* | *2022* | *Өөрчлөлт 2021* | *Өөрчлөлт 2022* |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3,249,682 | 6,956,116 | 5,027,668 | 114.1% | -27.7% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 89,000 | 2,997,377 | 789,329 | 3267.8% | -73.7% |
| Зээл (цэвэр) | 18,949,256 | 34,177,792 | 40,038,098 | 80.4% | 17.1% |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 1,793,317 | 4,838,475 | 2,855,132 | 169.8% | -41.0% |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 3,285,543 | 22,604,862 | 7,736,922 | 588.0% | -65.8% |
| Үндсэн хөрөнгө | 259,291 | 541,511 | 523,188 | 108.8% | -3.4% |
| Биет бус хөрөнгө | 2,028,939 | 625,738 | 652,707 | -69.2% | 4.3% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | - | 645,880 | 415,704 | 100.0% | -35.6% |
| **Нийт хөрөнгө** | **29,655,028** | **73,387,751** | **58,038,748** | **147.5%** | **-20.9%** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | | | |
| Бусдаас авсан зээл | 3,532,377 | 19,983,388 | 11,211,776 | 465.7% | -43.9% |
| Өрийн бичгээрх өглөг | 3,661,000 | 561,000 | 6,886,000 | -84.7% | 1127.5% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 7,845,836 | 18,189,153 | 13,465,658 | 131.8% | -25.0% |
| Мөнгөн гүйвуулгын өглөг | - | - | 175,619 | | |
| Бусад өр төлбөр | 3,228,326 | 11,224,826 | 8,132,764 | 247.7% | -27.5% |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 134,219 | 824,119 | 117,509 | 514.0% | -85.7% |
| **Нийт өр төлбөр** | **18,401,758** | **50,782,486** | **39,989,326** | **176.0%** | **-21.3%** |
| Хувьцаат капитал | 2,735,604 | 2,800,000 | 2,800,000 | 2.4% | 0.0% |
| Халаасны хувьцаа | - | - | (58) | 0.0% | 100.0% |
| Нэмж төлөгдсөн капитал | 3,694,292 | 5,342,623 | 5,352,792 | 44.6% | 0.2% |
| Бусад өмч | 976,953 | 7,053,406 | -3,401,128 | 622.0% | -148.2% |
| Хоёрдогч өглөг | - | - | 5,000,000 | 0%% | 100.0% |
| Хуримтлагдсан ашиг | 3,846,421 | 7,409,236 | 8,297,816 | 92.6% | 12.0% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **11,253,270** | **22,605,265** | **18,049,422** | **100.9%** | **-20.2%** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **29,655,028** | **73,387,751** | **58,038,748** | **147.5%** | **-20.9%** |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

*Активын бүтэц*

*График 23 Үнэт цаас гаргагчийн активын бүтэц, тэрбум төгрөгөөр*




2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт актив 21 хувиар өсөж 58.04 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт активын 97 хувь нь эргэлтийн, үлдсэн 3 хувь нь эргэлтийн бус хөрөнгөөс бүрдэж байна. Компанийн нийт актив өнгөрсөн 3 жилийн хугацаанд дунджаар 52 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь салбарын өсөлт болох 27 хувиас 2 дахин өндөр үзүүлэлт юм.

*Эх үүсвэрийн бүтэц*

*График 24 Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр*




2022 оны байдлаар нийт активын 69 хувийг өр төлбөр, 31 хувийг эздийн өмч бүрдүүлж байна. Өрийн эх үүсвэрийн бүтцийн хувьд 23 хувийг итгэлцэл, 19 хувийг бусад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 12 хувийг өрийн бичгээрх өглөгөөс тус тус бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн эздийн өмч өнгөрсөн 3 жилийн хугацаанд дунджаар 68 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь салбарын өсөлт болох 21 хувиас 3 дахин өндөр үзүүлэлт юм.

*Итгэлцэл*

*График 25 Итгэлцэл, тэрбум төгрөгөөр*




2022 оны жилийн эцсийн байдлаар Компанийн итгэлцэл 26 хувиар буурч 13.5 тэрбум төгрөг болсон ба нийт итгэлцлийн дийлэнх буюу 76 хувь нь төгрөгөөр, 24 хувь нь гадаад валютаар хийгдсэн байна. Хугацааны хувьд 1 жил хүртэлх хугацаатай 71 хувь, 1-2 жилийн хугацаатай итгэлцэл 29 хувийг эзэлж байна. Үнэт цаас гаргагчийн эздийн өмч өнгөрсөн 3 жилийн хугацаанд дунджаар 50 хувиар өссөн байгаа нь салбарын дундаж өсөлттэй ойролцоо байна.

*Зээл (цэвэр)*

*График 26 Үнэт цаас гаргагчийн зээл ангиллаар, тэрбум төгрөгөөр*




Үнэт цаас гаргагчийн зээлийн багц жил ирэх бүр өссөн ба 2022 онд 41.8 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт зээлийн 87 хувийг хэвийн ангилалтай зээл эзэлж байсан нь салбарын дундаж болох 89 хувьтай ойролцоо байна. Харин чанаргүй зээлийн эзлэх хувь 7.8 хувь байгаа нь салбарын дундаж болох 8.3 хувиас бага байна. Мөн Ард Кредитын зээлийн багц өнгөрсөн 3 жилийн хугацаанд дунджаар 35 хувиар өссөн нь салбарын дундаж өсөлт болох 32 хувьтай ойролцоо байна.



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 д.5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

АЙХ
2023.09.01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Мөнгөн гүйлгээний тайлан**

*Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*

*Хүснэгт 30 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр*

| Үзүүлэлт, мянган төгрөгөөр | 2020 | 2021 | 2022 | Өөрчлөлт 2021 | Өөрчлөлт 2022 |
|---|---|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **55,347,645** | **124,274,280** | **130,140,881** | **124.5%** | **4.7%** |
| Харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлт /үндсэн зээл/ | 39,048,119 | 68,006,439 | 95,763,020 | 74.2% | 40.8% |
| Итгэлцэл, татан төвлөрүүлсэн хөрөнгө | 9,017,906 | 44,428,924 | 13,683,046 | 392.7% | -69.2% |
| Зээлийн хүүгийн орлого | 5,175,231 | 7,986,407 | 11,788,785 | 54.3% | 47.6% |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 1,550,763 | 2,924,745 | 2,763,557 | 88.6% | -5.5% |
| Бусад үйлчилгээний орлого | 555,626 | 927,765 | 6,142,473 | 67.0% | 562.1% |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(53,720,621)** | **(129,432,407)** | **(131,436,190)** | **140.9%** | **1.5%** |
| Харилцагчдад олгосон зээлд төлсөн | (42,113,672) | (84,990,850) | (94,897,581) | 101.8% | 11.7% |
| Итгэлцэл, татан төвлөрүүлсэн хөрөнгө төлөлт | (6,933,486) | (36,210,940) | (15,643,166) | 422.3% | -56.8% |
| Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардалд төлсөн | (1,136,933) | (1,671,947) | (2,647,225) | 47.1% | 58.3% |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | (3,536,530) | (6,558,670) | (18,248,218) | 85.5% | 178.2% |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал** | **1,627,024** | **(5,158,127)** | **(1,295,309)** | **-417.0%** | **74.9%** |

2022 оны жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагааны гарах цэвэр мөнгөн гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 75 хувиар өсөж 1.3 тэрбум болсон ба өсөлт нь харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлтийн дүн өссөнтэй холбоотой байна.

*Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*

*Хүснэгт 31 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр*

| Үзүүлэлт, мянган төгрөгөөр | 2020 | 2021 | 2022 | Өөрчлөлт 2021 | Өөрчлөлт 2022 |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **54,834** | **15,183** | **572,317** | **-72.3%** | **3669.5%** |
| Харилцах хадгаламжийн хүүгийн орлого | 39,455 | 18 | - | -100.0% | -100.0% |
| Ногдол ашгийн орлого | 15,379 | 15,165 | 25,103 | -1.4% | 65.5% |
| Бусад орлого | - | - | 547,214 | 0.0% | 100% |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(363,840)** | **(75,704)** | **(44,949)** | **79.2%** | **40.6%** |



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

2023 09. 01



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө | (363,840) | (75,704) | (25,262) | 79.2% | 66.6% |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардалд төлсөн мөнгө | - | - | (19,687) | 0.0% | -100.0% |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал** | **(309,006)** | **(60,521)** | **527,368** | **80.4%** | **971.4%** |

2022 оны жилийн эцсийн байдлаар Ард Кредитын хөрөнгө оруулалтын орох мөнгөн урсгал 971 хувиар өсөж 527.37 сая төгрөг болсон ба өсөлт нь ногдол ашгийн орлоготой холбоотой байна.

*Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*

*Хүснэгт 32 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр*

| *Үзүүлэлт, мянган төгрөгөөр* | *2020* | *2021* | *2022* | *Өөрчлөлт* | |
|---|---|---|---|---|---|
| | | | | *2021* | *2022* |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **5,452,513** | **19,115,413** | **14,336,252** | **250.6%** | **-25.0%** |
| Бонд гаргалтаас хүлээн авсан мөнгө | 2,538,000 | - | 6,886,000 | -100.0% | 100.0% |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл | 2,914,513 | 19,115,413 | 7,450,252 | 555.9% | -61.0% |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(5,394,274)** | **(10,190,331)** | **(15,496,759)** | **88.9%** | **52.1%** |
| Банк санхүүгийн зээлийг төлсөн мөнгө | (1,840,636) | (5,564,414) | (13,537,518) | 202.3% | 143.3% |
| Бондын төлбөрт төлсөн мөнгө | (1,461,198) | (3,100,000) | (561,000) | 112.2% | -81.9% |
| Ногдол ашигт төлсөн мөнгө | (1,092,000) | (904,655) | (1,160,508) | -17.2% | 28.3% |
| Үнэт цаас худалдан авахад төлсөн мөнгө | (1,000,440) | (621,262) | (237,733) | -37.9% | -61.7% |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал** | **58,239** | **8,925,082** | **(1,160,507)** | **15224.9%** | **-113.0%** |

2022 оны жилийн эцсийн байдлаар Компанийн санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 113 хувиар буурч -1.16 тэрбум төгрөгийн хүрсэн ба бууралт нь банк санхүүгийн байгууллагаас авсан зээл буурч, банк санхүүгийн төлбөрт төлсөн мөнгө өссөнтэй холбоотой байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344



СТАНДАРТ

2023 .09. 01 өдөр
ГЭВ
№ 01



2023 -09- 04
БҮРТГЭВ-02

*Нийт мөнгөн гүйлгээ*

*Хүснэгт 33 Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр*

| *Үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр* | *2020* | *2021* | *2022* | *Өөрчлөлт* | |
|---|---|---|---|---|---|
| | | | | *2021* | *2022* |
| **НИЙТ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | | | |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,376,257** | **3,706,434** | **(1,928,448)** | **169.3%** | **-152.0%** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,873,425 | 3,249,682 | 6,956,116 | 73.5% | 114.1% |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,249,682** | **6,956,116** | **5,027,668** | **114.1%** | **-27.7%** |

2022 оны байдлаар Ард Кредитын нийт цэвэр мөнгөн гүйлгээ 1.93 тэрбум төгрөгийн гарах урсгалтай байсан ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 152 хувиар буурсан үзүүлэлт байна. Бууралт нь банк санхүүгийн зээлийн төлбөртэй холбоотой байна.

**Харьцаа үзүүлэлтүүд**

**Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд**

*Ашигт ажиллагаа*

*Хүснэгт 34 Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд*

| ***Харьцаа үзүүлэлтүүд*** | ***2020*** | ***2021*** | ***2022*** | ***Салбарын үзүүлэлт**** |
|---|---|---|---|---|
| Цэвэр хүүгийн орлогын маржин | 29.65% | 101.82% | 42.67% | 53.49% |
| Цэвэр ашгийн маржин | 14.53% | 24.47% | 11.53% | 38.07% |
| Зардал орлогын харьцаа | 0.85 | 0.76 | 0.88 | 0.62 |
| Өрийн үйлчилгээний харьцаа | 0.08 | 0.09 | 0.06 | 0.56 |
| Эздийн өмчийн өгөөж (ROE) | 11.31% | 23.18% | 10.13% | 13.93% |
| Активын өгөөж (ROA) | 4.70% | 7.62% | 3.13% | 9.07% |

**2020-2022 оны салбарын дундаж үзүүлэлт*

2021 онд цэвэр хүүгийн орлогын маржин болон ашгийн маржин бусад жилүүдээс огцом өссөн шалтгаан нь бусад үйлчилгээнээс олсон санхүүгийн үйлчилгээний шимтгэлээс олсон орлого өндөр гарсантай холбоотой байсан. 2022 онд компанийн орлогын гол эх үүсвэр болох цэвэр хүүгийн орлого өмнөх оноос 20 хувиар өссөн үзүүлэлт нь цаашид нэмэгдэх боломжтойг илтгэж байна. Компани нь харилцагчдын тоог нэмэгдүүлэх, дэд бүтцийг бүтээн байгуулах ажлуудын хүрээнд хөрөнгө оруулалтуудыг эрчимтэй хийн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,019,392 харилцагчтай болоод байна.

Өөрийн хөрөнгийн өгөөж нь хувьцаа эзэмшигчдийн 1 төгрөг тутамд ногдож буй ашгийн хэмжээг илэрхийлдэг. 2022 оны байдлаар тус харьцаа нь 10.13 хувь байгаа нь

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

салбарын үзүүлэлтээс 3.80 хувиар бага байгаа нь нэмэлт хөрөнгө оруулалт татсанаар үйл ажиллагааг тэлж ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломжтойг илтгэж байна.

Хөрөнгийн өгөөж нь Компани өөрийн хөрөнгийг хэрхэн үр ашигтай удирдан зарцуулж ашиг болгон хувиргаж байгааг харуулдаг. 2022 оны байдлаар хөрөнгийн өгөөжийн харьцаа 3.13 хувь байгаа нь салбарын үзүүлэлтээс 3 дахин бага байна. Ирэх жилүүдэд Компанийн шинээр хэрэглэгч бий болгох дэд бүтэц байгуулах үйл ажиллагаанд зарцуулж буй зардлууд буурч ашигт ажиллагаа сайжрах төсөөлөлтэй байна.

*Хөрвөх чадварын харьцаа*

*Хүснэгт 35 Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд*

| *Харьцаа үзүүлэлтүүд* | *2020* | *2021* | *2022* | *Салбарын үзүүлэлт** |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 1.56 | 1.47 | 1.42 | 2.55 |
| Мөнгөн хөрөнгийн харьцаа | 0.19 | 0.14 | 0.13 | 0.37 |

*2022 оны салбарын дундаж үзүүлэлт*

Банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хувьд үйл ажиллагааны онцлогоос хамааран эргэлтийн харьцаа бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр байдаг. 2022 оны байдлаар Ард Кредитын хувьд тус харьцаа 1.42 байгаа ба энэ нь салбарын үзүүлэлтээс бага байгаа хэдий ч эргэлтийн өр төлбөрөө төлөх бүрэн чадвартай байгааг илтгэж байна.

*Зээлийн харьцаа*

*Хүснэгт 36 Зээлийн харьцаа үзүүлэлтүүд*

| *Харьцаа үзүүлэлтүүд* | *2020* | *2021* | *2022* | *Салбарын үзүүлэлт** |
|---|---|---|---|---|
| Чанаргүй зээлийн хувь | 9.50% | 7.00% | 7.80% | 8.30% |
| Зээлийн эргэц | 0.34 | 0.29 | 0.31 | 0.27 |

**2020-2022 оны салбарын дундаж үзүүлэлт*

Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн хувь 2020 онд 9.5 хувь байсан бол 2020 оноос хойш тасралтгүй буурч 2022 онд 7.80 хувь болсон байна. Ард Кредитын чанаргүй зээлийн эзлэх хувь салбарын үзүүлэлтээс бага байгаа нь Компанийн эрсдэлийн түвшин харьцангуй бага байгааг харуулж байна. Ард Кредитын зээлийн эргэц 2022 онд 0.31-тэй байгаа нь өмнөх оны мөн үе болоод салбарын дундаж үзүүлэлтээс илүү байгаа нь зээлийн удирдлага сайн байгааг илтгэж байна.

*ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

Ард Кредит нь СЗХ-ноос банк бус санхүүгийн байгууллагуудад тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тасралтгүй ханган ажиллаж байна.

## Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт

*Хүснэгт 37 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| **ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | |
| I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | >10% | 36.00% | 20.40% | 27.20% | ✓ |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | >20% | 39.20% | 29.70% | 29.90% | ✓ |
| I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | >10% | 34.70% | 21.20% | 28.30% | ✓ |

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг нөхөхөд хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгө байгаа эсэхийг харуулдаг харьцаа юм. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт актив болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаанууд нь 10 хувиас доошгүй байхыг СЗХ-ноос шаарддаг. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 27.20 хувь болон 29.90 хувь байгаа нь хөрөнгийн хүрэлцээ сайн байгааг харуулж байна.

## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

*Хүснэгт. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шалгуур үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| **ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА** | | | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | >8% | 18.50% | 14.30% | 12.70% | ✓ |

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг харьцааг СЗХ-ноос 8 хувиас дээш байх гэсэн шалгуурыг тавьдаг. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн тус харьцаа нь 12.70 хувь байгаа ба төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайн байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9020051344 д. 5459567

2023 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-08-04
БҮРТГЭВ-02

**Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт**

*Хүснэгт 38 Актив хөрөнгийн төвлөрлийн шалгуур үзүүлэлтүүд*

| *Үзүүлэлт* | *Шалгуур* | *2020* | *2021* | *2022* | *Хангасан эсэх* |
|---|---|---|---|---|---|
| **АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | |
| Хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээ | - | 1,417,677 | 2,521,240 | 2,116,148 | ✔ |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | <30% | 8.90% | 8.80% | 26.70% | ✔ |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | <70% | 0.00% | 0.00% | 0.00% | ✔ |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | <25% | 20.20% | 24.90% | 17.30% | ✔ |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | <10% | 8.90% | 8.80% | 9.40% | ✔ |
| Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | <50% | 16.90% | 34.70% | 20.20% | ✔ |
| Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | <20% | 16.90% | 19.10% | 15.60% | ✔ |
| МХБ-ийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | <20% | 9.80% | 9.40% | 4.80% | ✔ |
| Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | <20% | 0.00% | 12.00% | 2.80% | ✔ |
| Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | <10% | 0.00% | 10.40% | 8.90% | ✔ |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344

СЗХ
2023 оны 08 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 04
БҮРТГЭВ-02

## Гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлтүүд

*Хүснэгт 39 Гадаад валютын ханштай холбоотой шалгуур үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| **ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ** | | | | | |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | +/-40% | -6.10% | -32.40% | -14.60% | ✓ |

Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг СЗХ-ноос +/-40 хувийн хооронд байвал зохистой гэж үздэг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар тус харьцаа -14.60 хувь байна.

## Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд

*Хүснэгт 40 Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| **БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | <80% | 69.70% | 80.50% | 74.60% | ✓ |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | <50% | 32.50% | 2.50% | 38.20% | ✓ |

Үнэт цаас гаргагчийн бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд нь уг хөрөнгийг үр ашигтай, зохистой удирдаж байгаа эсэхийг харуулдаг ба эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 74.60 хувь, өөрийн бичгийн зохистой харьцаа 38.20 хувь байна.

## Үндсэн хөрөнгийн үзүүлэлт

*Хүснэгт 41 Үндсэн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| **ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | <15% | 0.90% | 1.60% | 1.60% | ✓ |

Үндсэн хөрөнгийн зохистой харьцааг СЗХ-ноос 15 хувиас хэтрэхгүй байвал зохистой гэж үздэг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар тус харьцаа 1.6 хувь байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ₮ 5459567



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

АРД КРЕДИТ
ББСБ ХК

ИНВЕСТМЕНТ ҮЦК

СЗХ
2023 .09. 01
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -09- 04

# ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

## 5.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй улсын эдийн засаг, салбарын нөхцөл байдал болон төлөв

2020 оны цар тахлын үеэс хойш Монгол Улсын эдийн засаг сэргэсэн ба 2021 онд 1.6 хувиар, 2022 онд 4.8 хувиар өсөж ДНБ 53 их наяд төгрөгт хүрсэн. Эдийн засаг ийнхүү сэргэснээр 2022 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ 4,717 долларт[15] хүрсэн ба энэ нь 2021 оноос 3.3 хувиар, 2018 оны үеэс 13 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүнээс гадна инфляцын түвшин өнгөрсөн оны 6 сарын дээд түвшинд (16.1 хувь)-д хүрснээс хойш буурч 2023 оны 5 сарын байдлаар 11.3 хувьд[16] хүрсэн нь иргэдийн бодит орлого өсөхөд нөлөөлж байна. Нэг хүнд ногдох ДНБ, бодит орлого өссөнөөр өрхийн орлого өсөж, зээл авах боломжит дүнг нэмэгдэх тул ББСБ салбарыг тэлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Гадны[17] байгууллагуудаас Монгол Улсын эдийн засгийг 2025 он гэхэд дунджаар 6.2 хувиар өснө гэж төсөөлсөн. Энэхүү өсөлтийн төсөөллийн гол хүчин зүйл нь БНХАУ-ын зүгээс 2022 онд уул уурхайн экспорт дээр тогтоосон гаалийн хязгаарлалт дууссантай холбоотой байна. Үүнээс гадна Оюу Толгой төслийн гүний уурхайгаас олох орлого одоогийнхоос 2 дахин өсөх боломжтой талаар Дэлхийн Банк 2023 оны 4 сарын тайландаа тусгасан. Монгол Улсын засгийн газраас гаргасан "АЛСЫН ХАРАА-2050" урт хугацааны хөгжлийн бодлогод дурдсанаар Монгол Улсын экспортын хэмжээ 2025 онд 14,020 сая доллар, 2030 онд 29,660 сая доллар, 2050 он гэхэд 139,870 сая долларт хүрнэ гэж төсөөлсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 11 дахин өндөр үзүүлэлт юм. Эдгээр хүчин зүйлс нь дотоодын уул уурхайн салбарт, цаашлаад эдийн засагт томоохон дэмжлэг үзүүлэх хүлээлттэй байна.

2022 оны байдлаар санхүүгийн салбарын нийт хөрөнгө 50.3 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь Монгол Улсын ДНБ-ий 95 хувьтай тэнцэх үзүүлэлт юм. Үүний 7 хувийг нь ББСБ-ын салбар бүрдүүлсэн нь 5 жилийн өмнөх (1.3 их наяд) дүнгээс 2 дахин өссөн (3.5 их наяд) байна. World Population Review судалгааны байгууллагаас гарсан тайланд ББСБ-ын салбар цахимжиж, илүү олон хүмүүс гар утсаараа үйлчилгээ авдаг болсноор олон улсын ББСБ-ын зах зээл 2022 онд 185 тэрбум доллароор хэмжигдэж байсан бол 2027 он гэхэд 2.2 дахин өсөж 411 тэрбум долларт хүрнэ гэж төсөөлжээ. Ирэх жилүүдэд засгийн газрын бодлого болон олон улсын байгууллагуудын судалгаанаас үзэхэд Монгол Улсын эдийн засаг олон улсын дунджаас илүү хурдтай өсөх хандлагатай байгаа тул үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын салбар ирэх 5 жилд санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа нэмж 2 дахин өсөлт үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

## 5.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны зорилт болон төлөвлөгөө

Финтек санхүүгийн үйлчилгээгээр салбартаа тэргүүлэгч "Ард Кредит ББСБ" ХК нь 2019 онд хиймэл оюун ухаанд суурилсан онлайн зээлийн бүтээгдэхүүнийг Ард Аппаар дамжуулан олгож эхэлсэн бөгөөд 2019 онд олон нийтэд хувьцаагаа санал болгож /IPO/

[15] Дэлхийн банкны 2022 оны жилийн эцсийн судалгаа
[16] Үндэсний Статистикийн Хороо
[17] Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

СЗХ
2023 оны 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-03-04
БҮРТГЭВ-02

татан төвлөрүүлсэн хөрөнгөөр онлайн зээлийг санхүүжүүлэхэд зарцуулснаар 4 жилийн хугацаанд зээлийн багц болон нийт хөрөнгөө тус тус 5.5 дахин, цэвэр ашгаа 6.0 дахин үсрэнгүй өсгөж 13,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ амжилттайгаар биелүүлж чадсан.

Цаашид Ард Кредит нь харилцагч нартаа санхүүгийн цогц үйлчилгээг финтек болон өөрийн салбар, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан хосолсон буюу **ФИЖИТАЛ** (**PHYGITAL**) буюу **PHYSICAL (биет салбар) + DIGITAL (финтек)** хэлбэрээр хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж ажиллахаар дунд хугацааны стратегийн зорилт, төлөвлөгөөгөө тодорхойлоод байна. Үнэт цаас гаргагч нь өнөөг хүртэл амжилттай баримталж ирсэн салбаргүйгээр финтект суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлогоо үргэлжлүүлэн баримталж ажиллахаас гадна хамгийн том хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн стратегийн хөрөнгө оруулалттай Монгол улсын аймаг, сум бүрд салбартай, томоохон дэд бүтэц бүхий Монгол Шуудан ХК-тай стратегийн түвшний хамтралыг бий болгож, орон даяарх 400 орчим салбар, нэгжүүдээр дамжуулан өөрийн санхүүгийн үйлчилгээг биет байдлаар хүргэхээр төлөвлөсөн.

Энэхүү зорилгын хүрээнд Компани нь ирэх 3 жилийн хугацаанд дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дээр түлхүү төвлөрч ажиллана. Үүнд:

**Финтек бүтээгдэхүүн, үйлчилгээ**

Үнэт цаас гаргагч нь өнөөгийн Ард Кредитийг бий болгоход голлох үүргийг гүйцэтгэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болох финтект суурилсан онлайн зээлийн үйлчилгээг үргэлжлүүлнэ. Тус үйлчилгээ нь хүний оролцоотой ажиллагаа, алдааг бууруулж, харилцагчдад түргэн шуурхай үйлчилснээр тэдний цаг хугацаа, зардлыг хэмнэхээс гадна нийт санхүүгийн хүртээмжийг сайжруулах давуу талтай юм. Иймд Компани нь тус зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг улам төгөлдөржүүлж, зардлыг бууруулах замаар цаашид тус зээлийн хүүг бууруулах бодлого баримталж ажиллана.

**Бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн ЭКО систем**

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар Монгол Улсын нийт ажлын байрны 50 гаруй хувийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг үйлдвэрлэдэг хэдий ч барьцаа хөрөнгийн шаардлага хангахгүй, уламжлалт байдлаар шийдэгддэг, цаг хугацаа, зардал ихээхэн гардаг зэрэг шалтгаанаар бизнес эрхлэгчид төдийлөн хүртээмжтэй, өөрсдийн бизнесийн онцлогт тохирсон санхүүжилт авахад хүндрэлтэй байсаар байна.

Үнэт цаас гаргагч нь энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилтийн шинэ загварыг боловсруулж, 2021 оноос эхлэн СКОПА төслийг санаачлан амжилттай хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд түүхий эдийн ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид, мерчантууд, санхүүгийн байгууллагууд, эцсийн хэрэглэгчдийг нэг талбарт холбож, финтек суурьтай, дэвшилтэт платформоор дамжуулан оролцогч талуудад барьцаагүй, зах зээлийн нөхцөлөөс хөнгөлөлттэй санхүүжилт олгож эхэлсэн. Ийнхүү гинжин хэлхээнд оролцож буй бүх талуудад

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

СЗХ
20__ он __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01



харилцан ашигтай схемийг бүрдүүлэн ажилласнаар хамгийн чухал нь эцсийн хэрэглэгчид үнэ багатай бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн юм.

Тус нийлүүлэлтийн гинжин хэлхээний оролцогч тал бүрд санхүүгийн ашигтай нөхцөл байдлыг бий болгох, нэмүү өртгийг улсдаа үлдээх, эх орончи үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор энэхүү төслийг улам бүр сайжруулан өргөжин тэлэх шаардлагатай байгаа бөгөөд Ард Кредит нь нэмэлт энгийн хувьцааны санхүүжилтээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн 50 хувийг жижиг дунд, бичил бизнес эрхлэгч, тэдгээрийн харилцагч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

**Тогтвортой санхүүжилт**

Дэлхийн нийтээр байгаль орчны асуудлыг чухалчилж буй энэ цаг үед Үнэт цаас гаргагч нь нийгэм, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулахад онцгойлон анхаарч үүнд чиглэсэн "Тогтвортой санхүүжилт"-ийн бодлогыг хэрэгжүүлж 2025 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Ингэхдээ дараах зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Хүлэмжийн хийг бууруулахад нөлөөлөх эко автомашин буюу цахилгаан автомашины зээл, мөн хайбрид буюу цахилгаан, бензин хосолсон хөдөлгүүртэй автомашины зээл;
- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, амины орон сууцны зээл;
- Олон улсын тодорхойлолтоор ногоон гэж үзэх бусад ногоон зээл.

### 5.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

**Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл**

*Хүснэгт 42 Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, 2023-2025*

| *Үзүүлэлтүүд, мянган төгрөг* | *2022* | *2023Т* | *2024Т* | *2025Т* | *CAGR (2022-2025)* |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 5,027,668 | 3,599,436 | 7,536,077 | 9,177,699 | 22.2% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 789,329 | 508,377 | 1,775,417 | 2,218,943 | 41.1% |
| Зээл (цэвэр) | 40,038,098 | 48,861,571 | 81,290,336 | 101,494,974 | 36.4% |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 2,855,132 | 3,289,586 | 5,326,250 | 6,656,829 | 32.6% |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 7,736,922 | 8,935,247 | 11,712,680 | 13,704,309 | 21.0% |
| Үндсэн хөрөнгө | 523,188 | 2,727,374 | 2,604,533 | 2,353,685 | 65.1% |
| Биет бус хөрөнгө | 652,707 | 543,295 | 623,813 | 549,416 | -5.6% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 415,704 | 154,742 | - | - | |
| **Нийт хөрөнгө** | **58,038,748** | **68,619,628** | **110,869,105** | **136,155,856** | **32.9%** |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5450567

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | | | |
| Бусдаас авсан зээл | 11,211,776 | 13,152,261 | 29,485,594 | 36,485,248 | 48.2% |
| Өрийн бичгээрх өглөг | 6,886,000 | – | 10,000,000 | 15,000,000 | 29.6% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 13,465,658 | 19,045,011 | 27,860,511 | 32,110,511 | 33.6% |
| Мөнгөн гуйвуулгын өглөг | 175,619 | 210,743 | 252,891 | 303,470 | 20.0% |
| Бусад өр төлбөр | 8,132,764 | 7,172,447 | 7,761,775 | 7,877,766 | -1.1% |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 117,509 | - | - | - | - |
| **Нийт өр төлбөр** | **39,989,326** | **39,580,462** | **75,360,772** | **91,776,995** | **31.9%** |
| Хувьцаат капитал | 2,800,000 | 3,640,000 | 3,640,000 | 3,640,000 | 9.1% |
| Халаасны хувьцаа | (58) | - | - | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 5,352,792 | 12,912,792 | 12,912,792 | 12,912,792 | 34.1% |
| Бусад өмч | -3,401,128 | (4,012,624) | - | - | |
| Хоёрдогч өглөг | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | - |
| Хуримтлагдсан ашиг | 8,297,816 | 11,498,997 | 13,955,541 | 22,826,069 | 40.1% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **18,049,422** | **29,039,166** | **35,508,334** | **44,378,861** | **35.0%** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **58,038,748** | **68,619,628** | **110,869,105** | **136,155,856** | **32.9%** |

*График 27 Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багцын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр*




Ард Кредит нь 2023-2025 онд татах санхүүжилтийн төлөвлөгөөтэй уялдуулан зээлийн багцаа жилд дунджаар 37.6 хувиар өсгөж 108.8 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөөд байна.

2025 он гэхэд зээлийн багцын 80.0 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээл, үлдсэн 20.0 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн бүрдүүлнэ.

*График 28 Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн гүйцэтгэл ба төсөөлөл , тэрбум төгрөгөөр*




Үнэт цаас гаргагч нь ирэх 3 жилд зээлийн багцаа тэлснээр нийт хөрөнгөө жилд дунджаар 32.9 хувиар өсгөж 136.2 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн. 2025 онд нийт хөрөнгийн 74.5 хувийг цэвэр зээлийн багц бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

*График 29 Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр*




Ард Кредит нь ирэх 3 жилд гадаад санхүүжилт, банкны стратегийн түншлэл болон дотоодын хөрөнгийн зах зээлээс бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зэргээр санхүүжилт татаж жилд дунджаар 38.4 хувиар нэмэгдүүлж 83.6 тэрбум төгрөгт хүргэхээр зорьж байна.

## Орлогын тайлангийн төсөөлөл

*Хүснэгт 43 Орлогын тайлангийн төсөөлөл, 2023-2025*

| *Үзүүлэлтүүд, мянган төгрөг* | *2022* | *2023Т* | *2024Т* | *2025Т* | *CAGR (2022-2025)* |
|---|---|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 11,339,294 | 12,952,799 | 23,965,237 | 30,802,364 | 39.5% |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (6,513,600) | (5,369,898) | (10,974,949) | (13,971,404) | 29.0% |
| **Хүүгийн цэвэр орлого** | **4,825,694** | **7,582,901** | **12,990,288** | **16,830,960** | **51.7%** |
| Хүүгийн бус орлого | 5,945,035 | 4,326,175 | 5,750,646 | 6,375,042 | 2.4% |
| Хүүгийн бус зардал | (6,335,565) | (7,478,165) | (8,838,031) | (10,046,591) | 16.6% |
| **Цэвэр хүүгийн бус зардал** | **(390,530)** | (3,151,990) | (3,087,385) | (3,671,549) | 111.1% |
| Болзошгүй эрсдэлийн зардал | (2,530,969) | (1,004,455) | (2,738,429) | (2,756,032) | 2.9% |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 575,759 | 332,636 | 316,004 | 284,404 | -21.0% |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (45,389) | (49,928) | (54,921) | (60,413) | 10.0% |
| **Татварын өмнөх ашиг** | **2,434,565** | **3,709,163** | **7,425,558** | **10,627,370** | **63.4%** |
| Орлогын татварын зардал | (375,341) | (473,193) | (956,389) | (1,756,842) | 67.3% |
| **Цэвэр ашиг** | **2,059,224** | **3,235,971** | **6,469,168** | **8,870,527** | **62.7%** |

*График 30 Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлогын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр*



СЗХ
БҮРТГЭВ



Үнэт цаас гаргагч нь үндсэн зээлийн хүүгийн орлогоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 2022 онтой харьцуулахад 2.7 дахин буюу 19.5 тэрбум төгрөгөөр өсгөхөөр төлөвлөсөн. Хүүгийн орлогын жилийн дундаж өсөлт 39.5 хувь байна.

*График 31 Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлогын гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр*




Зээлийн багцад эзлэх бичил, жижиг дунд бизнесийн зээл нэмэгдэж, мөн шимтгэлийн хэмжээг бууруулахтай холбоотойгоор шимтгэл, хураамжийн орлогын өсөлт саарч хүүгийн бус орлого ирэх 3 жилд дунджаар 2.4 хувиар нэмэгдэж 2025 оны эцэст 6.4 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна.

*График 32 Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн гүйцэтгэл ба төсөөлөл, тэрбум төгрөгөөр*




Фижитал байдлаар үйл ажиллагаагаа өргөжүүлж нэгж орлогод ногдох үйл ажиллагааны зардлыг бууруулж ажилласнаар ирэх 3 жилд цэвэр ашгаа нийт 6.8 тэрбум төгрөг буюу 4.3 дахин өсгөх төлөвлөгөөтэй байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 5450567

СЗХ
2023 09 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-09-04
БҮРТГЭВ-02

**Харьцаа үзүүлэлтийн төсөөлөл**

*Хүснэгт 44 Харьцаа үзүүлэлтийн төсөөлөл, 2023-2025*

| *Голлох үзүүлэлт* | *2020* | *2021* | *2022* | *2023Т* | *2024Т* | *2025Т* |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт активд эзлэх зээл | 68.4% | 49.9% | 72.0% | 73.9% | 77.4% | 79.9% |
| Эздийн өмчийн харьцаа | 37.9% | 30.8% | 31.1% | 42.3% | 32.0% | 32.6% |
| Өрийн харьцаа | 50.7% | 52.8% | 54.4% | 46.9% | 60.7% | 61.4% |
| Итгэлцлийн зохистой харьцаа | 69.7% | 80.5% | 74.6% | 65.6% | 78.5% | 72.4% |
| Бондын зохистой харьцаа | 32.5% | 2.5% | 38.2% | 0.0% | 28.2% | 33.8% |
| Хүү төлөх чадвар | 167.2% | 216.2% | 137.4% | 169.1% | 167.7% | 176.1% |
| Цэвэр хүү, шимтгэлийн түвшин | 27.1% | 15.9% | 19.0% | 22.2% | 20.4% | 20.0% |
| Цэвэр ашгийн түвшин | 14.5% | 24.5% | 11.5% | 18.4% | 21.5% | 23.7% |
| Эздийн өмчийн өгөөж | 11.3% | 23.2% | 10.1% | 13.7% | 20.0% | 22.2% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 4.6% | 7.6% | 3.1% | 5.1% | 7.2% | 7.2% |
| NPL | 9.5% | 7.0% | 7.8% | 7.8% | 7.6% | 6.5% |
| PAR | 12.8% | 9.2% | 13.2% | 12.0% | 11.0% | 10.0% |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459507



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК

# ҮНЭТ ЦААСНЫ
# ТАНИЛЦУУЛГА

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 ... 5459567

ИНВЕСТМЕНТ
ХХК

СЗХ
2023 .09 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -09- 01



# ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## 6.1. Үнэт цаас нэмж гаргах тухай шийдвэр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр**

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт болон холбогдох бусад эрх зүйн актуудыг тус тус үндэслэн Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2023 оны 2-р сарын 9-ний өдрийн 2023/02 тоот шийдвэрээр Ард Кредитын өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор энгийн хувьцааны 30 хүртэлх хувь буюу 84,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй арилжаалахаар шийдвэрлүүлсэн байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол**

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 43 дугаар зүйл, 55 дугаар зүйлийн 55.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, Компанийн Дүрмийн 8 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2023/02 тоот шийдвэр болон Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5-р сарын 19-ний өдрийн 2023/18-01 тоот тогтоолоор Компанийн нэмж гаргах хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагчид нэмж гаргах хувьцаанаас 67,200,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг (80 хүртэлх хувь), олон нийтэд нэмж гаргах хувьцаанаас 16,800,000 ширхгээс доошгүй энгийн хувьцааг (20 хувиас доошгүй) санал болгохоор тус тус тогтоожээ.

## 6.2. Санал болгож буй үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагчийн компанийн дүрмийн 6.1-т зааснаар "Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг хувьцаатай байна. Компанийн дүрмийн 6.2-т Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ". Иймээс компанийн дүрмээр зөвшөөрөгдсөн Үнэт цаас гаргагчийн хувьцаат капитал нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байна.

*Хүснэгт 45 Санал болгож буй үнэт цаасны тухай*

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "Ард Кредит ББСБ" ХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Үнэт цаасны бүртгэл | Монголын Хөрөнгийн Бирж |
| МХБ-ийн ангилал | I ангилал |
| Зарласан хувьцааны тоо | 280,000,000 ширхэг |
| Нэмж санал болгож буй хувь | 30 хүртэлх хувь |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 84,000,000 ширхэг |
| Нэмж хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо | 364,000,000 ширхэг |

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2023 .08 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 01
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох нөхцөл | • Нэмж гаргах хувьцаанаас 67,200,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох (80 хүртэлх хувь);<br>• Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авах хувьцааны үнийн дүнгийн доод хэмжээг 100,000,000 (нэг зуун сая) төгрөг байх;<br>• Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд тусгаарлах; |
| Олон нийтэд санал болгох нөхцөл | • Нэмж гаргах хувьцаанаас 16,800,000 ширхгээс доошгүй хувьцааг олон нийтэд санал болгох (20 хувиас доошгүй);<br>• 500,000 төгрөг хүртэлх захиалга 100% биелж, давсан захиалгыг хувь тэнцүүлнэ. |
| Үнэт цаасны арилжаа явуулах арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |
| Хувьцааны үнэ тогтоох аргачлал, санал болгох үнэ | Нэмж гаргах хувьцааны үнийг 2023 оны 6 сарын 12-ны өдрөөр тасалбар болгож, тус өдрөөс МХБ-ийн арилжааны өмнөх 180 хоногийн жигнэсэн дундаж ханш болох 106 төгрөгөөр тогтоосон |
| Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцох хувь | 100% |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Компанийн үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэлэх |

### 6.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагчийн компанийн дүрмийн 6.1-т зааснаар "Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг хувьцаатай байна. Компанийн дүрмийн 6.2-т Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ". Иймээс компанийн дүрмээр зөвшөөрөгдсөн Үнэт цаас гаргагчийн хувьцаат капитал нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2023 .08 04 өдөр
БҮРТГЭВ
№01

*Хүснэгт 46 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (Нэмж хувьцаа гаргах үеэс өмнөх байдлаар)*

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Хувьцаат капитал (дүрмийн сан) төгрөгөөр |
|---|---|---|---|---|
| | **Танилцуулга бэлтгэх үеийн байдлаар** | | | |
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 113,660,996 | 40.59% | 1,136,609,960 |
| 2 | С.Гэрэлтуяа | 27,305,402 | 9.75% | 273,054,020 |
| 3 | Ардын Тэтгэврийн Данс ХХК | 16,232,767 | 5.80% | 162,327,670 |
| 4 | Х.Батхишиг | 14,426,999 | 5.15% | 144,269,990 |
| 5 | С.Оргил | 11,658,223 | 4.16% | 116,582,230 |
| 6 | Г.Бат-Эрдэнэ | 11,648,223 | 4.16% | 116,482,230 |
| 7 | Ард Бит ХХК | 11,217,378 | 4.01% | 112,173,780 |
| 8 | Н.Мөнхнасан | 7,058,824 | 2.52% | 70,588,240 |
| 9 | Эйч Ви Эл Эл ХХК | 6,923,259 | 2.47% | 69,232,590 |
| 10 | А.Сүхдорж | 5,086,580 | 1.82% | 50,865,800 |
| | Топ хувьцаа эзэмшигчид | 225,218,651 | 80.44% | 2,252,186,510 |
| | Олон нийт | 54,781,349 | 19.56% | 547,813,490 |
| | **Нийт гаргасан хувьцаа** | **280,000,000** | **100.00%** | **2,800,000,000** |

Үнэт цаас гаргагч нь нийт хувьцааны 30 хүртэлх хувийг нэмж гаргаснаар нийт 364,000,000 ширхэг энгийн хувьцаатай болох ба хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай болно.

*Хүснэгт 47 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (Нэмж хувьцаа гаргасны дараах байдлаар)*

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Хувьцаат капитал (дүрмийн сан) төгрөгөөр |
|---|---|---|---|---|
| | **Нэмж хувьцаа гаргасны дараах үеийн байдлаар** | | | |
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 113,660,996 | 31.23% | 1,136,609,960 |
| 2 | С.Гэрэлтуяа | 27,305,402 | 7.50% | 273,054,020 |
| 3 | Ардын Тэтгэврийн Данс ХХК | 16,232,767 | 4.46% | 162,327,670 |
| 4 | Х.Батхишиг | 14,426,999 | 3.96% | 144,269,990 |
| 5 | С.Оргил | 11,658,223 | 3.20% | 116,582,230 |
| 6 | Г. Бат-Эрдэнэ | 11,648,223 | 3.20% | 116,482,230 |
| 7 | Ард Бит ХХК | 11,217,378 | 3.08% | 112,173,780 |
| 8 | Н.Мөнхнасан | 7,058,824 | 1.94% | 70,588,240 |
| 9 | Эйч Ви Эл Эл ХХК | 6,923,259 | 1.90% | 69,232,590 |
| 10 | А.Сүхдорж | 5,086,580 | 1.40% | 50,865,800 |
| | Топ хувьцаа эзэмшигчид | 225,218,651 | 61.87% | 2,252,186,510 |
| | Олон нийт | 138,781,349 | 38.13% | 1,387,813,490 |
| | **Нийт** | **364,000,000** | **100.00%** | **3,640,000,000** |

Үнэт цаас гаргагч нь анх 2019 онд Компанийн 25 хувийг олон нийтэд санал болгосноор 13 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй нээлттэй компани болсон бөгөөд 2023 онд 30 хувийг нэмж санал болгон хувьцаа төвлөрлийг бууруулахаар зорин ажиллаж байна. Ард Кредит нь нэмж хувьцаагаа санал болгосноор хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж, төвлөрөл буурч, Компанийн засаглал сайжрах нөлөөтэй юм.

## 6.4. Үнэт цаасны үнэ тогтоох тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нэмж санал болгох хувьцааны үнийг 2023 оны 6 сарын 12-ны өдрөөр тасалбар болгож, тус өдрөөс МХБ-ийн арилжааны өмнөх 180 хоногийн жигнэсэн дундаж болох 106 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэсэн.

УЛААНБААТАР ХОТ АРД КРЕДИТ ББСБ ХК 9023051344 5459567



УЛААНБААТАР ХОТ СТЕППЕ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

**Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл**

Компанийн энгийн хувьцаа нь Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, ТОП 20 индексэд 3 дах жилдээ багтсан, бирж дээр арилжааны идэвх өндөртэй хувьцаат компанийн нэг юм. Нэгж хувьцааны үнийг тооцохдоо Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.8 дах хэсэг, МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дөрөв дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА" ашигласан. Тогтоосон үнийн аргыг ашиглан нэгж хувьцааны үнийг СЗХ-нд материалаа хүргүүлсний дараа, шийдвэр гарахаас өмнө тодорхойлох нь цаг хугацаанаас шалтгаалах ханшийн зөрүүг бага байлгахад тусална.

2023 оны 6 сарын 12-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаас гаргагчийн жигнэсэн дундаж ханшийг арилжааны сүүлийн 30 хоног, 60 хоног, 90 хоног болон 180 хоногоор тооцоход дунджаар 106.60 төгрөг байгаа ба тасалбар болгон авсан 2023 оны 6 сарын 12-ний өдрийн хаалтын ханш 107.00 төгрөг байгааг харвал Үнэт цаас гаргагчийн ханш зах зээлд тогтвортой байгааг харуулж байна.

*Хүснэгт 48 Ард Кредитын жигнэсэн дундаж ханшийн мэдээлэл*

| *2023.06.12-ны хаалтын ханш* | *Жигнэсэн дундаж ханш* | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *30 хоног* | *60 хоног* | *90 хоног* | *180 хоног* | *Дундаж* |
| ₮107.00 | ₮107.79 | ₮107.09 | ₮105.77 | ₮105.74 | ₮106.60 |
| | **Стандарт хазайлт** | | | | |
| | 2.28% | 2.47% | 2.19% | 2.92% | 2.47% |

Мөн дээрх цаг хугацаагаарх Компанийн хаалтын ханшийн өөрчлөлтөөс тооцоолсон стандарт хазайлтын хэлбэлзэл бага байгаа нь Компанийн нэмж гаргаж буй хувьцааны ханшийг 106 төгрөгөөр тогтоох нь үндэслэлтэй гэж үзэж байна.

### 6.5. Үнэт цаасыг зах зээлд арилжаалах төлөвлөгөө

**Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах аргачлал**

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4 дүгээр бүлэгт заасан "Тогтоосон үнийн арга"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална. Тогтоосон үнийн аргаар арилжааг явуулахад хөрөнгө оруулагч нь худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

### Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл

МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсноор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6-аас доош сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагчид тооцдог. Үнэт цаас гаргагч нь дараах нөхцөлөөр стратегийн хөрөнгө оруулагчдад нэмэлт хувьцааг санал болгоно:

- Нэмж гаргах хувьцааны 80 хүртэлх хувь буюу 67,200,000 ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох;
- Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авах хувьцааны үнийн дүнгийн доод хэмжээг 100,000,000 (нэг зуун сая) төгрөг байх;
- Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд тусгаарлах.

### Олон нийтэд санал болгох нөхцөл

Үнэт цаас гаргагч нь нэмж гаргах хувьцааны 20 хувиас доошгүй буюу 16,800,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох ба Тогтоосон үнийн аргыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

### Үнэт цаасыг зах зээлд байршуулах

Захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь СЗХ-ны шийдвэр гарсны дараа Биржтэй хамтран тогтооно. Андеррайтер нь ҮЦК-иудад арилжааны талаар зааварчилга, мэдээлэл өгөх ба ҮЦК-иуд захиалгыг биржийн программд шивж оруулна. Захиалга бүртгэлийн хугацаанд стратегийн хөрөнгө оруулагчдаас болон олон нийтээс захиалга авах сан нь тусдаа байна.

*Зураг 12 Анхдагч зах зээлд байршуулах хуваарь*




### СЗХ, Биржээс үнэт цаасыг бүртгэх шийдвэр

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг Бирж болон СЗХ-нд гаргах бөгөөд зохицуулагч байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл авснаар олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Андеррайтер

нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь тайланг хүлээн авч арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд өмчлөх эрхийн бүртгэл хийх болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

**Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах**

Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл гарсны дараа СЗХ-д мэдэгдсэний үндсэн дээр үнэт цаасыг олон нийтэд санал болгох тухай мэдээлэх, танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

Үнэт цаасыг олон нийтэд танилцуулахаас өмнө Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно.

**Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар**

*Зураг 13 Үнэт цаас худалдан авах заавар*




Хувьцаа худалдан авах хөрөнгө оруулагчид МХБ-д бүртгэлтэй гишүүн үнэт цаасны компаниар дамжуулан захиалга өгөх боломжтой.

**Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх**

Стратегийн хөрөнгө оруулагчдаас авсан хувьцааны захиалгыг Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь МХБ-ийн арилжааны журмын дагуу хуваарилалтыг гүйцэтгэнэ.

Олон нийтээс ирсэн хувьцааны захиалгын биелэлтийг хийхдээ Тогтоосон үнийн аргын дагуу захиалгын сан нь олон нийтэд санал болгох хэмжээнээс давсан тохиолдолд

СЭХ 2023.08.01 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-08-04 БҮРТГЭВ-02

500,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100% биелүүлж, түүнээс дээш давсан захиалгыг хувь тэнцүүлэн хуваарилна.

**Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа**

Үнэт цаас гаргагчийн нэмэлт хувьцааны анхдагч арилжаа амжилттай болсон тохиолдолд Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлөөр Арилжаа эрхлэх байгууллага буюу Монголын Хөрөнгийн биржийн журамд заасан зохицуулалтын дагуу үнэт цаасны хоёрдогч арилжааг эхлүүлнэ.

**Андеррайтерийн худалдан авах хувь**

Үндсэн андеррайтер болох Стандарт Инвестмент ҮЦК ХХК нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй хувьцаанаас анхдагч арилжааны захиалга эхлэх өдөр хамгийн багадаа 30,000 ширхэг үнэт цаасыг худалдан авна.

**Үнэ тогтворжуулах үйл ажиллагаа**

Үндсэн андеррайтер Стандарт Инвестмент ҮЦК ХХК нь хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг 1 сарын хугацаанд 90,000,000 төгрөгөөр бие даан, хараат бусаар хэрэгжүүлнэ. Үндсэн андеррайтер нь хувьцааны үнэ анхдагч зах зээлд санал болгосон үнээс 15 хувь буурсан тохиолдолд худалдан авах арилжааг хийж эхэлнэ.

Стандарт Инвестмент ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэн ажиллана.

**6.6. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг**

Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаар дараах эрх үүрэгтэй:

**Үнэт цаас эзэмшигчийн эрх**

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу энгийн хувьцаа эзэмшигчийн хувьд дараах эрх эдлэхээс гадна өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах, компанийн дүрэмд заасан бусад эрхийг эдэлнэ. Үүнд:

УЛААНБААТАР АРД КРЕДИТ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2023 сар 08 өдөр
БҮРТГЭВ
ARD КРЕДИТ ББСБ



- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах, шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж буй хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах;
- Хувьцаа эзэмшигч нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар Компанийн ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компани татан буугдах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу Компанийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Хувьцаат Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;
- Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, шинэчлэн найруулсан, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн гэх зэрэг тохиолдлуудад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр Компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

**Үнэт цаас эзэмшигчийн үүрэг**

- Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн бол өмчлөх эрх үүссэнээс ажлын 3 хоногийн дотор эрх бүхий байгууллагад бичгээр мэдэгдэх;
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээх;
- Хувьцаа эзэмшигч нь Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгө, компанийн нэр хүндэд хор уршиг, хохирол учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхгүй байх;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг;

**Үнэт цаас гаргагчийн үүрэг**

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5469587

СЗХ
2023 .08 сар .01 өдөр
БҮРТГЭВ
№ 01



- Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;
- Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд СЗХ-нд хүргэх, нийтэд мэдээлэх;
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;
- Тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
- Хагас жилийн болон СЗХ-нд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд СЗХ болон Биржид хүргүүлэх;
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-ноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх.
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг.

### 6.7. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийн 50 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн багцыг нэмэгдүүлэх, 30 хувийг үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, цахилгаан автомашин болон хайбрид автомашин худалдан авахад зориулан олгох ногоон зээлийн багцыг санхүүжүүлэх, үлдсэн 20 хувийг онлайн хэрэглээний зээлийн багцад тус тус зарцуулахаар төлөвлөөд байна.

*Зураг 14 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт*






УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5459567

- 50 хувийг фижитал /PHYGITAL/ хэлбэрээр бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн багцыг санхүүжүүлэх,
- 30 хувийг фижитал /PHYGITAL/ хэлбэрээр үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, цахилгаан автомашин болон хайбрид автомашин худалдан авахад зориулан олгох ногоон зээлийн багцыг санхүүжүүлэх,
- 20 хувийг дижитал /digital/ хэлбэрээр онлайн хэрэглээний зээлийн багцыг санхүүжүүлэхэд тус тус зарцуулахаар бизнес төлөвлөгөөнд тусгасан байна.

*Бичил, жижиг дунд бизнесийн зээл*

Ард Кредит нь ирэх 3 жилийн хугацаанд бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэн, сайжруулж харилцагчдад хүртээмжтэй уян хатан, шинэлэг байдлаар хүрч ажиллахаар зорьж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн 53.6 хувийг онлайн зээл, 42.5 хувийг бизнесийн зээл, 3.9 хувийг хэрэглээний зээл эзэлж байна. Компани нь санхүүгийн үр ашигтай байдал, хүртээмжтэй байдлыг бий болгох стратегийн хүрээнд 2025 он гэхэд нийт зээлийн багцын 80 хувийг бичил, жижиг, дунд бизнесийн зээл байхаар төлөвлөсөн. Мөн Ард Кредит нь бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийн зах зээл дээр эцсийн хэрэглэгч, мерчант, нийлүүлэгч, санхүүгийн байгууллагуудыг холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээ болох "Good platform"-оор дамжуулан бизнес эрхлэгчдэд зээл олгоход төвлөрч ажиллана.

*Тогтвортой санхүүжилт*

Үнэт цаас гаргагч нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бизнест санхүүжилт олгохоос татгалзаж хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжин, үнэ цэнэ бүтээхэд чиглэсэн бизнесүүдийг санхүүжүүлэх зорилттой ажиллаж байна. Тус зорилгын хүрээнд татан төвлөрүүлэх хөрөнгийн 30 хувийг үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, цахилгаан автомашин болон хайбрид автомашин худалдан авахад зориулан олгох ногоон зээлийн багцыг санхүүжүүлэхээр төлөвлөөд байна.

*Хэрэглээний зээл*

Ард Кредит нь татан төвлөрүүлэх хөрөнгийн 20 хувийг онлайн хэрэглээний зээлийг санхүүжүүлэхээр төлөвлөөд байна. Компани нь хэрэглээний зээлийг илүү хүртээмжтэй, өртөг багатай, харилцагчид чирэгдэлгүй болгохын тулд цаасны хэрэглээг бүрэн халж цахимаар зээлийн хүсэлтийг бүхэлд нь шийдвэрлэхээр зорин ажиллаж байна. Онлайн зээлийг идэвхжүүлэх бодлогын хүрээнд Үнэт цаас гаргагч нь 2025 онд нийт зээлийн 50 хувийг финтек, 50 хувийг фижитал хэлбэрээр олгохоор төлөвлөөд байна.

# ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АРД КРЕДИТ
ББСБ ХК
9023051344 ⊥ 5459567

СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК

СЗХ
2023.09.01
БҮРТГЭВ
№ 01



## ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### 7.1. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого

Ард Кредит нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагын дагуу "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг хэрэгжүүлдэг бөгөөд үйл ажиллагааны бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах, мэдээлэх, тасралтгүй үйл ажиллагаа явуулах зарчмын хүрээнд ажилладаг.

Ард Кредит нь эрсдэлийн удирдлагын бодлогоор стратегийн, үйл ажиллагааны болон хувьцаа эзэмшигчдийн өмнө амласан ашгийн түвшний зорилго, зорилтоо биелүүлэх явцад учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн улмаас гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдэлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд дараах зорилтуудыг тавин ажилладаг:

- Эрсдэлийн удирдлагын соёлыг хэвшүүлэх;
- Компанийн эрсдэлийн удирдлагыг дэд бүтэцжүүлэх;
- Эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах;
- Эрсдэл, өгөөжийн зохистой харьцааг барьж ажиллах.

**Үнэт цаасны танилцуулгад орсон мэдээлэлтэй холбоотой эрсдэл**

*Статистикийн мэдээлэлтэй холбоотой эрсдэл*

Тус үнэт цаасны танилцуулга нь Ард Кредитын дотоод мэдээллээс гадна Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Үндэсний Статистикийн Хороо зэрэг зохицуулагч байгууллагуудын олон нийтэд нээлттэй статистик мэдээлэл болон бусад гуравдагч этгээдийн мэдээлэл дээр үндэслэсэн болно. Эдгээр мэдээллүүдийг үнэн, зөв гэсэн үндэслэл дээр тус үнэт цаасны танилцуулгыг бэлтгэсэн хэдий ч Ард Кредит нь мэдээлэл бүрийн үнэн зөв байдал дээр хяналт, баталгаажуулалт хийгээгүй болно. Тиймээс эдийн засгийн үзүүлэлт, ББСБ-ын үзүүлэлт зэрэг нь бүрэн бус эсхүл үнэн бус байж болзошгүй.

### 7.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

*Зээлийн эрсдэл*

Зээлийн эрсдэл гэдэгт зээлдэгч гэрээний үүргээ үл биелүүлэх, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг цаг хугацаанд төлөхгүй байх, зээлийн чанар муудах зэрэг эрсдэл орно. Уг эрсдэл нь зөвхөн зээлийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй ба хөрөнгө оруулагч, бизнесийн түншүүд гэрээний нөхцөлийг биелүүлээгүйгээс үүсэх орлого, өөрийн хөрөнгө буурах эрсдэлийг ойлгоно. Зээлийн эрсдэлд гадаад хүчин зүйлс болох макро эдийн засгийн байдал, санхүүгийн системийн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна



УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

дотоод хүчин зүйлс болох банкны зээлийн болон актив, пассивын бодлого нөлөөлнө. Зээлдэгч бүрийн нөлөө нь харьцангуй байх ба тухайн зээлийн хугацаа, дүнгээс шалтгаалан ББСБ-ын санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багц 36.64 тэрбум төгрөг байснаас 7.02 хувийг чанаргүй зээл, 9.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна. Цаашид зах зээлийн болон санхүүгийн системийн нөхцөл байдал болон Үнэт цаас гаргагчийн баримталж буй дотоод бодлого нь зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд барихад хүндрэл учруулахгүй гэсэн баталгаа байхгүй.

*Стратегийн эрсдэл*

Стратегийн эрсдэл нь бизнест сөргөөр нөлөөлөх шийдвэр гаргах, эсхүл аливаа шийдвэрийг зохисгүй хэрэгжүүлснээс үүсдэг. Үүнд Үнэт цаас гаргагч нь зах зээлд эзлэх байр сууриа аажмаар алдах, үйл ажиллагаа зогсох, бусад компаниудын эзэмшилд орох зэрэг эрсдэлүүдийг хамруулна. Мөн стратегийн эрсдэлд компани өөрт тохироогүй, буруу стратеги баримтлан ажилласнаас үүдэн үйл ажиллагаа доголдох эрсдэлийг хамруулдаг. Урьдчилан тодорхойлох боломжгүй, гэнэтийн гадаад болон дотоод хүчин зүйлс нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн стратегид эрсдэл үүсгэж, санхүүгийн болон үйл ажиллагааны материаллаг сөрөг нөлөө гарч болзошгүй.

*Системийн эрсдэл*

Зах зээл дэх экспортын гол түүхий эдийн үнэ, ханшийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлт удааширч, эдийн засаг нийтээрээ хямрах эрсдэл юм. Мөн тодорхой нэг томоохон санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа доголдох, дефолт зарлах зэргээс үүдэн тэрхүү байгууллагын харилцагч талуудад гинжин сөрөг нөлөө үзүүлж, иргэдийн санхүүгийн байгууллагад итгэх итгэл алдарч улмаар санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учрах эрсдэлийг хэлнэ. Салбарын харилцагч талуудад гинжин сөрөг нөлөө гарах нь Компанийн үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

*Зах зээлийн эрсдэл*

Зах зээлийн эрсдэл гэдэгт зах зээл дэх хүүгийн түвшний өөрчлөлт, Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулсан үнэт цаасны үнийн өөрчлөлт, гадаад валютын ханшийн өөрчлөлт болон холбогдох бусад хүчин зүйлсээс үүдэн компанийн санхүүгийн тайлан дахь болон санхүүгийн тайлангаас гадуурх хөрөнгө, өр төлбөрийн дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг оруулдаг.

*Макро эдийн засгийн эрсдэл*

Монгол Улсад КОВИД-19 халдвар дотоодод тархсанаас хойш УИХ, Засгийн Газар болон Монголбанкнаас санхүүгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээсийг авсаар байна. Бүх нийтийн хөл хорио нь Ард Кредитын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байгаа бол дараах шийдвэрүүдийн үр нөлөө нь Ард Кредитын үйл ажиллагаа, ашигт ажиллагаанд шууд байдлаар эерэг болон сөрөг нөлөөг үзүүлж байна.

*Ханшийн эрсдэл*

Үнэт цаас гаргагчийн гадаад валютаар татсан санхүүжилт, гадаад валютаар олгосон зээл зэрэг нь ханшийн хөдөлгөөнд мэдрэг ба энэ нь гадаад валютын ханшийн эрсдэл бий болгодог.

*Хүүгийн түвшний эрсдэл*

Монголбанкны баримталж буй мөнгөний бодлогын чиглэлийг өөрчлөх, мөнгөний бодлогын хүү огцом өсөх болон буурах, санхүүгийн салбарын хүүгийн түвшин өөрчлөгдөх зэрэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

*Хөрөнгө оруулалтын эрсдэл*

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооноос шалгуурт нийцүүлэн бусад компаниудад хөрөнгө оруулсан бөгөөд эдгээр Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнэ нь буурахад компанид сөргөөр нөлөөлнө. Хувьцааны үнэ нь буурснаар хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурч, улмаар Үнэт цаас гаргагчийн активын дүн буурах эрсдэлтэй.

*Хөрвөх чадварын эрсдэл*

Хөрвөх чадварын эрсдэл гэдэгт зах зээлийн төлөв, ханшийн савлагаа, чанаргүй зээл болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан Үнэт цаас гаргагч бэлэн мөнгөний хомсдолд орж, төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болох, улмаар өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл учрах эрсдэлийг оруулдаг. Үнэт цаас гаргагч нь актив, пассивын зөрүүг тогтмол хянаж, удирддаг хэдий ч зах зээлийн эрсдэл ба санхүүгийн системийн доголдол үүсэхийг үгүйсгэхгүй ба банкны актив, пассивын удирдлагын бодлого нь цаашид тус эрсдэлээс бүрэн хамгаалах баталгааг өгөхгүй.

*Үйл ажиллагааны эрсдэл*

Үйл ажиллагааны эрсдэл гэдэгт Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны дотоод процессын зохион байгуулалт оновчтой хийгдээгүй буюу процессын алдаа үүссэний улмаас, мөн ажилтны алдаатай үйлдэл, дотоод систем болон гадаад хүчин зүйлсээс үүдэн алдагдал хүлээх эрсдэлийг оруулдаг. Ард Кредит нь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахаар дотоод хяналтын зохистой бодлого, журам, процессыг бий болгосон боловч энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн хаах баталгааг өгөхгүй. Хүний хүчин зүйлийн эрсдэл буюу ажиллагсад алдаа гаргах, үйл ажиллагааны болон дотоод хяналтын журмыг үл мөрдөх, хууль, журам, стандарт, стратегид үл нийцэх үйлдэл гаргах зэрэг нь зарим тохиолдолд банкны урьдчилан сэргийлэх хяналтаас гадуур үйлдэгдэж болзошгүй ба тэдгээрийг Үнэт цаас гаргагчийн холбогдох нэгжүүд тухай бүр илрүүлэх баталгаа байхгүй тул хүний хүчин зүйлээс үүсэх эрсдэл нь Компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, ирээдүйн зорилтод материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

*Хүний нөөцийн эрсдэл*

Хүний нөөцийн эрсдэл гэдэгт Үнэт цаас гаргагчийн боловсон хүчин чадваргүй байх, буруу албан тушаалд хуваарилагдсан байх ба эрх мэдлээ урвуулан ашиглах, хүний нөөцийн эргэц нэмэгдэх зэрэг эрсдэлийг оруулдаг. Түүнчлэн хүний нөөц болон сургалтын дутагдал, хангалтгүй байдлаас энэхүү эрсдэл нь үүсэх магадлал өндөр байдаг учир жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа хүний нөөцийг чухалчлан авч үзэн үйл ажиллагаанд гарах өөрчлөлт бүртэй уялдуулан удирдаж ажилладаг.

*Мэдээллийн технологийн эрсдэл*

Мэдээллийн технологийн системийн доголдол үүсэх, компьютерын сүлжээ хакердуулах, програмчлалын алдаа зэрэг программ хангамжийн улмаас Үнэт цаас гаргагчид сөргөөр нөлөөлж болзошгүй. Мэдээлэл, технологийн эрсдэлийг тодорхойлоход дараах арга хэмжээг авна:

- Мэдээлэл, технологийн хөрөнгийг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлэх;
- Болзошгүй аюулыг тодорхойлох;
- Эмзэг байдлыг тодорхойлох;
- Хяналтыг үнэлэх;
- Болзошгүй аюулын магадлалыг тодорхойлох;
- Болзошгүй аюулын нөлөөллийг тодорхойлох;
- Хариу үйлдэл, шаардлагатай хяналтыг тодорхойлох;
- Баримтжуулах.

*Комплаенсын эрсдэл*

Үнэт цаас гаргагч нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани төдийгүй Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад байдаг тул компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, менежер, ажилтнууд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах ёстой. Комплаенсын эрсдэл нь компанийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журамтай үл нийцэх байдлаас үүсдэг. Мөн комплаенсын эрсдэлд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжүүлэх эрсдэл томоохон хэсгийг эзэлнэ. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомж, Олон Улсын байгууллагуудаас баталсан заавар, зөвлөмжийг дагаж мөрдөж ажилладаг бөгөөд учирч болох эрсдэлээс сэргийлэхэд анхаарна ажилладаг. Комплаенсын эрсдэл нь компанийн нэр хүнд, үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлөх магадлалтай.

*Нэр хүндийн эрсдэл*

Нэр хүндийн эрсдэл гэдэгт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээлэл үнэн худлаас үл хамааран олон нийтэд тарснаар хэрэглэгчдийн тоо буурч, хуулийн зардал өсөж, орлого буурах эрсдэл юм. Энэ төрлийн эрсдэл нь шинэ бизнесийн харилцаа тогтоох, үйлчилгээ үзүүлэх, одоогийн харилцагчдадаа үргэлжлүүлэн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй. Нэр

хүндийн эрсдэл нь компанийн үйл ажиллагааны бүх түвшинд байх бөгөөд хууль, хянан нийцүүлэлтийн, үйл ажиллагааны ба стратегийн эрсдэлүүдийг хэрхэн удирдахаас ихээхэн шалтгаалдаг. Ирээдүйд учрах гадаад болон дотоод хүчин зүйлс нь банкны нэр хүндэд нөлөөлөхгүй гэх баталгаа байхгүй. Үүсэж болзошгүй нэр хүндийн эрсдэл нь банкны санхүүгийн чадамж, үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй.

*Хөгжиж буй орнуудын хууль эрх зүйн орчны эрсдэл*

Одоогийн байдлаар Монгол Улсад хууль эрх зүйн сайжруулалт, шинэчлэлүүд банк, санхүүгийн салбарт хурдацтай явагдаж байна. Тус хэрэгжиж буй хууль эрх зүйн шинэчлэл нь банкны үйл ажиллагаа болон тэдгээрийн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэгт нөлөө үзүүлж болзошгүй байна.

### 7.3. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага

Ард Кредитын хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талууд нь Компанийн бизнест үүсэх эрсдэлд шууд болон шууд бусаар өртөх боломжтой байдаг тул Компанийн зүгээс хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог алба, нэгж бүртээ бүрдүүлэн ажиллаж ирсэн. Байгууллагын дотоод соёл, уур амьсгал нь нийт ажиллагсдын зан төлөв хандлагыг төлөвшүүлдэг. Энэ нь ажиллагсад эрсдэлд хэрхэн хандах, ямар хэмжээний эрсдэл хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хэрхэн удирдах зэрэгтэй шууд хамааралтай. Тиймээс Компани нь байгууллагын соёлдоо ажилтан нэг бүр эрсдэлийн удирдлагад хариуцлагатай хандаж, өөрсдийн ажлын дээрх эрсдэл нэг бүрийг тооцоолон ажиллах хэв маягийг бүрдүүлж ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь тулгарч болзошгүй эрсдэлүүдийг макро эдийн засаг, бодлогын хүүгийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон зээлийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага, Монголбанкны бодлогын хүрээ, мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлага, бизнесийн салбарын орчин, санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэл зэргээр эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, багасгах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлдэг.

Үнэт цаас гаргагч нь "Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого"-ын хүрээнд эрсдэл хариуцсан албан тушаалтан болон баг хамт олон нь эрсдэлийн удирдлага, хяналт, үнэлгээ, шугаман мэдээлэл, авсан зохистой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилладаг. Хяналт, үнэлгээний ажил нь тасралтгүй үнэлгээ, салангид буюу давтамжит үнэлгээ эсхүл хосолсон үнэлгээ гэж ангилан тасралтгүй тайлагнах байдлаар хэрэгжүүлдэг. Компанийн эрсдэлийн хамгаалалтын шугамын хүрээнд ажиллагсад дараах байдлаар эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаар тайлагнаж байна.

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК

*Хүснэгт 49 Эрсдэлийн хамгаалалтын шугам*

| **Эрсдэлийн хамгаалалтын түвшин** | **Хэрэгжүүлэгчид** | **Тайлагнах эрх бүхий албан тушаалтан** | **Тайлагнах хугацаа** |
|---|---|---|---|
| Эрсдэлийн хамгаалалтын 1-р түвшин | Харилцагчийн үйлчилгээний төвийн ажилтан, Зээлийн мэргэжилтэн, Эрсдэлийн мэргэжилтнүүд | Харилцагчийн үйлчилгээний төвийн ажилтан, Зээлийн мэргэжилтэн, Эрсдэлийн мэргэжилтнүүд | 7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй |
| Эрсдэлийн хамгаалалтын 2-р түвшин | Зээл эрхэлсэн захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Санхүүгийн менежер, Маркетингийн менежер, Хуульч, Комплаенс хариуцсан ажилтан | Гүйцэтгэх захиралд | Гүйцэтгэх захиралд 7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй |
| Эрсдэлийн хамгаалалтын 3-р түвшин | Дотоод аудитор, Эрсдэл хариуцсан захирал | Дотоод аудитор, Эрсдэл хариуцсан захирал | Гүйцэтгэх захиралд 7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй, ТУЗ-д улирал тутамд |

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тасралтгүй тогтвортой өсөлтийг хангах зорилгоор дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн томоохон аудит, зөвлөх үйлчилгээний байгууллага болох Грант Торнтон-оос 3 дахь жилдээ эрсдэлд суурилсан хөндлөнгийн аудитын шалгалт оруулж, дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн зүгээс Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох Олон Улсын ISO27001 стандартыг нэвтрүүлэх ажлыг 2022 оны 4-р улирлаас эхлэн итгэмжлэгдсэн Инфосек компанийн тусламжтайгаар хэрэгжүүлэлтийн ажлыг хийж амжилттай нэвтрүүлсэн. Тус стандарт нь өөрийн мэдээллийн хөрөнгөнд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, тухайн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцаар хангах юм. Мөн нийт ажиллагсдын хүрээнд давтамжтайгаар танхим болон цахим "эрсдэл-боломж" ойлголт, эрсдэлийг олж илрүүлэх, үнэлгээ хийх сургалтуудыг зохион байгуулж компанийн ажилтан тус бүрийн оролцоотой эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг компанийн засаглалын хүрээнд ТУЗ-н дэргэдэх Санхүү, зээл, эрсдэлийн хороонд цаг алдалгүй тайлагнан хэлэлцэж хариу арга хэмжээг тухай бүрд авч ажилладаг. Мөн толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эрсдэлийн хороо, чадварлаг мэргэжилтнүүдийн зөвлөгөө мэдээллээр хангагдан эрсдэлийн удирдлагыг стратегийн түвшинд хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь стратегийн зорилго, зорилтдоо хүрэхэд учирч болох таагүй үйл явдлыг тэдгээрийн магадлал, нөлөөллийг харгалзан үзсэний үндсэн дээр бага эрсдэлтэй, дунд зэргийн эрсдэлтэй, өндөр эрсдэлтэй, маш өндөр эрсдэлтэй гэсэн үнэлгээгээр үнэлдэг.

СЗХ 2023 .09р 01 өдөр БҮРТГЭВ № 01
2023-09-04 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ АРД КРЕДИТ ББСБ ХК
СТАНДАРТ ...

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлдэг:

1. Нөхцөл байдлыг тодорхойлох;
2. Эрсдэлийг үнэлэх (тодорхойлох, шинжлэх, дүгнэх);
3. Эрсдэлийн хариу арга хэмжээ авах;
4. Эрсдэлийн мониторинг хийх;
5. Мэдээлэл солилцож, зөвлөлдөх;
6. Тайлагнах.

Компани нь эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах эрсдэл бүрийн онцлогт тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг.

**Зээлийн эрсдэлийн удирдлага**

Ард Кредит нь зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг:

- Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай компани тул зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, зээлийн чанарыг зохистой түвшин болон зээлийн эрсдэлийн санг холбогдох журмын дагуу бүрэн зөв байгуулж буй эсэхэд хяналт тавих хараат бус нэгжийг ажиллуулдаг;
- Холбоотой талуудын өглөг ба авлагын үлдэгдлийн хяналтад онцгой анхаарал хандуулдаг. Тухайлбал толгой компани болон түүнтэй түүнтэй авах авлагын хэмжээ тогтоосон хязгаараас хэтэрсэн эсэхэд тогтмол хяналт тавьдаг;
- Холбоотой талуудад зээл олгохдоо давуу тал үүсгэхээс ангид байж, зээлийн бодлогын дагуу шалгуур, шаардлагыг тавьж, зээл бүрэн эргэн төлөгдөх боломжтой тохиолдолд зээлийн шийдвэрийг холбогдох хорооны хурлаар шийдвэрлэдэг. Шаардлагатай тохиолдолд зээлийн эрсдэлээс хамгаалах санг нэмж байгуулдаг;
- Зээлийн багцад шинжилгээ судалгааг тогтмол хийдэг бөгөөд гарсан үр дүнг үндэслэн зээлийн шалгуур, шаардлага өөрчлөлтийг оруулдаг.

**Зах зээлийн эрсдэлийн удирдлага**

Зах зээлийн эрсдэлийн удирдлагад гадаад валютын ханш, хүүгийн түвшин, хөрөнгө оруулалт, хөрвөх чадвараас хамааран эрсдэл үүсэж болзошгүй юм. Иймд Үнэт цаас гаргагч нь зах зээлийн эрсдэлийг удирдахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

*Гадаад валютын ханшийн эрсдэл*

- Үнэт цаас гаргагч нь валютын ханшид нөлөөлөхүйц улс төр, эдийн засгийн бодлого, зохицуулалтын шийдвэрүүдийг анхааран авч үзэн тогтмол хянах, хугацааны давтамжтай гадаад валютын ханшийн таамаглал хийх, эзэмшиж буй гадаад валютын тодорхой хувийг төгрөгт хөрвүүлэх, хугацааны давтамжтай гадаад валютын ханшийн таамаглал хийх, гадаад валютаар хөрөнгө, өр төлбөрийн хэмжээг ойролцоо байлгах замаар гадаад валютын цэвэр позицыг

бууруулах, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд ашиглан ханшийн эрсдэлийг хэджинг хийх зэргээр ханшийн эрсдэлийг удирддаг.

- Value at Risk (VaR) – VaR буюу "Хамгийн их эрсдэл"-ийн аргыг компанийн гадаад валютын позицын ханшийн эрсдэлийг тодорхойлоход ашиглана. Энэ нь зах зээлийн ердийн орчинд тохиолдож болзошгүй сөрөг нөлөөллөөс үүсэх алдагдлыг хэмжих хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалан тодорхой нэгэн актив болон багцаас тодорхой хугацааны дараа алдаж болох алдагдлын хэмжээг тодорхой магадлалтайгаар тодорхойлдог статистик арга юм.
- Төгрөгийн америк доллартой харьцах харьцаанд ханшийн өсөлт, бууралтын шинжилгээг хийж эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ, шийдвэрийг тухай бүр авч хэрэгжүүлдэг.

*Хүүгийн түвшний эрсдэл*

Үнэт цаас гаргагч нь хүүгийн түвшний эрсдэлийг бууруулах стратеги баримталж ажиллах ба зээлийн үйл ажиллагааны хүүг боломжит бага түвшинд барьж ажиллах, салбартаа хамгийн бага хүүг санал болгох, мөнгөний бодлогын чиглэлийг анхааралтай ажиглах, түүнтэй уялдсан стратеги, үйл ажиллагааны шийдвэр гаргах зэрэг арга хэмжээг авч ажиллана. Мөн компани зах зээлээс татаж буй санхүүжилт болон олгож буй зээлийн хүүгийн зөрүүнд шинжилгээ, судалгааг хийж ашигт ажиллагааг хангахад чиглэсэн шийдвэрүүдийг тухай бүр авч хэрэгжүүлдэг.

*Хөрөнгө оруулалтын эрсдэл*

Сар, улирал бүрийн эцэст хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тогтмол тооцоолж, хөрөнгө оруулалтыг хянаж, шаардлагатай нөхцөлд хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах, бусдад борлуулах зэрэг тохирох арга хэмжээг авч, ажилладаг.

- Хувьцаа - Нээлттэй компаниудын хувьцааны үнийн өөрчлөлтөд мэдрэмжийн шинжилгээ хийх байдлаар тухайн нөхцөл байдал үүсэхэд компанийн ашигт хэрхэн нөлөөлөхийг тодорхойлдог.
- Криптовалют - Компанийн хөрөнгө оруулсан криптовалютуудын ханшид 20 хувь, 30 хувь, 50 хувийн өөрчлөлт орох мэдрэмжийн шинжилгээг хийж, тухайн нөхцөлд үүсэх ашиг, алдагдлын хэмжээг тодорхойлдог.

*Хөрвөх чадварын эрсдэл*

- Компанийн орох, гарах мөнгөний урсгалыг хянаж, хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлж, учирч болзошгүй төлбөрийн хомсдолыг үнэлэх. Компани нь мөнгөн гүйлгээнийхээ төсөөллийг бэлтгэж, нөхцөл байдал өөрчлөгдөх магадлалыг тусгадаг.
- Компани өөрийн үйл ажиллагаанд тохирсон хөрвөх чадварын эрсдэлийн лимитийг тогтоох ба Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай компани болохын хувьд Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлттэй уялдсан байна. Нөхцөл байдал, эрсдэлийн зөвшөөрөгдөх хэмжээ

өөрчлөгдөх бүрд тогтоосон лимитийг шинэчлэн, тохируулах ба хяналтыг тогтмол хийдэг.

- Компани богино хугацааны төлбөрийн үүргээ биелүүлэх чадвартай байгаа эсэхэд тогтмол мониторинг хийдэг.

**Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага**

*Хүний нөөцийн эрсдэл*

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн эрсдэлийг удирдах зорилгоор хүний нөөцийн эргэцийг хэмжиж, салбарын дундаж болон бусад холбогдох статистиктай харьцуулан шинжилдэг. Үнэт цаас гаргагч нь шүгэл үлээх журам, хүний нөөцийн журам, болон бусад шаардлагатай дүрэм, журмуудыг боловсруулж хэрэгжүүлдэг.

*Мэдээлэл, технологийн эрсдэл*

Мэдээлэл, технологийн эрсдэлийг тодорхойлоход дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг:

- Мэдээлэл, технологийн хөрөнгийг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлэх; (Мэдээлэл, технологийн хөрөнгө гэдэгт сервер, харилцагчийн мэдээлэл, түншийн мэдээлэл, компанийн нууц мэдээлэл зэрэг ордог)
- Болзошгүй аюулыг тодорхойлох; (Байгалийн гамшиг, системийн доголдол, хүнээс шалтгаалах санаатай болон санамсаргүй алдаа гэх мэт)
- Эмзэг байдлыг тодорхойлох; (Эмзэг байдал гэдэгт компанийн сул хяналтаас шалтгаалан тохиож болох аюул нь компанид алдагдал учруулахыг хэлдэг)
- Хяналтыг үнэлэх; (Тохиож болзошгүй аюул системийн эмзэг байдлыг ашиглан Группт алдагдал учруулах магадлалыг бууруулахаар оршиж буй эсвэл нэвтрүүлж буй хяналтыг үнэлнэ. Урьдчилан сэргийлэх ба илрүүлэх хяналт байгаа эсэхийг тодорхойлдог)
- Болзошгүй аюулын магадлалыг тодорхойлох;
- Болзошгүй аюулын нөлөөллийг тодорхойлох;
- Хариу үйлдэл, шаардлагатай хяналтыг тодорхойлох; (Болзошгүй аюулын магадлал ба нөлөөллийг тодорхойлсны дараагаар эрсдэлийн түвшнийг тодорхойлох ба өндөр эрсдэлд авах хариу арга хэмжээг нэн яаралтай боловсруулан хэрэгжүүлдэг)
- Баримтжуулах;

**Комплаенсын эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь комплаенсын эрсдэлийг удирдахдаа дараах үйл арга хэмжээг хэрэгжүүлдэг:

- Компани нь хууль, хянан нийцүүлэлтийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулахдаа үйл ажиллагаанд хамаарах бүхий л хууль, дүрэм, журмуудын нийцлийг оноогоор үнэлэх;

- Холбогдох Санхүүгийн зохицуулах хорооны хязгаарлалт болон зохистой шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих.

**Нэр хүндийн эрсдэлийн удирдлага**

Нэр хүндийн эрсдэлийг хянахад дараах зүйлсийг анхаарч ажилладаг:

- Ажиллагсдын мэдлэг - Ажиллагсад нь өөрсдийн үйл ажиллагаа бүрд учирч болзошгүй нэр хүндийн эрсдэл болон тэдгээрийн үр дагаврыг ойлгодог байх шаардлагатай;
- Шинэ санааг зах зээлд нэвтрүүлэхээс өмнө үнэлдэг байх - Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бодлого нэвтрүүлэх үед эрсдэл хариуцсан нэгж ба шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллан хараат бус үнэлгээ хийлгүүлэх;
- Харилцагчид, олон нийтийн гомдол, саналыг хүлээн авдаг байх - Гомдол, саналын бүртгэлийг тогтмол хийж, гомдол саналыг ажиглаж, шинжилж, яаралтай хариу арга хэмжээг авснаар нэр хүндэд хүчтэй сөргөөр нөлөөлж болохуйц эрсдэлийг хяналтад байлгах боломжтой. Компани нь олон нийтийн дунд судалгаа авах байдлаар бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, олон нийтийн хандлага, сэтгэл ханамжийн тандалтыг явуулж, өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авна;
- Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх - Ёс зүйн дүрмийг бүх ажилчдад ойлгуулж, таниулж, өдөр тутмын үйл ажиллагаанд уялдуулах сургалтуудыг зохион байгуулах;

**Стратегийн түвшний эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагчийн стратеги төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал нь улирал, жилээр бэлтгэж, Санхүү, зээл, эрсдэлийн хороонд танилцуулж, цаашлаад ТУЗ-аар батлуулна. Мөн стратегийн эрсдэл нь бизнесийн хэлцэл, худалдан авах, нэгдэх зэрэг дээр үүсэх тул тухай бүрд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг:

- Нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох;
- Эрсдэл бүрийг ангилах;
- Эрсдэл бүрийн магадлал ба нөлөөллийг тодорхойлох;
- Эрсдэлийн түвшнээс хамааран эрэмбэлэх;
- Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулах.

**Системийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь системийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулан улирал бүр аргачлалын дагуу системийн эрсдэлийг хянана.

# ОРОЛЦОГЧ
# БАЙГУУЛЛАГУУД

АРД КРЕДИТ
ББСБ ХК

## НАЙМ. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

### 8.1. Үндсэн Андеррайтерийн компани

| СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ | **Стандарт инвестмент ҮЦК ХХК** |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011267116 |
| **Регистрийн дугаар** | 5444381 |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх |
| **Хаяг** | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Туул голын гудамж, Автохаб төв, 1 давхар |
| **Утас** | +976 70114433 |
| **Веб хуудас** | www.standardinvestment.mn |
| **Цахим шуудан** | broker@standardinvestment.mn |

Үндсэн андеррайтер болох Стандарт инвестмент ҮЦК ХХК нь 2011 онд байгуулагдаж СЗХ-оос 2011 онд брокер, диллер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ, 2012 онд андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын хамгийн шилдэг, хамгийн найдвартай, түргэн шуурхай үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэн ажилладаг.

Стандарт инвестмент ҮЦК ХХК нь 2014 онд Мерекс ХК-ийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох ажиллагаанд андеррайтераар, 2015 онд Баянбогд ХК-ийн нэгтгэл, 2016-2017 онд Уужимхангай ХК-ийн нэгтгэл, Айтүүлс ХК-д андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн, дотоодын хөрөнгийн зах зээлээс 1.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхэд 3 дахин их захиалга авч, мянга гаруй хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан түүхэн дээд амжилт тогтоон ажилласан. 2017 онд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос шилдэг андеррайтерийн компани, 2018 онд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ТОП-5 андеррайтерийн нэг, 2018 онд ЛэндМН ББСБ ХК, Монгол базальт ХК, Мандал даатгал ХК, Түмэн шувуут ХК, Ард Кредит ББСБ ХК-уудын IPO-д шилдэг борлуулагч. 2019 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс шилдэг Брокерийн компани, Инвескор ББСБ ХК- ийн IPO-д шилдэг борлуулагчийн амжилттай ажилласан.

Стандарт инвестмент ҮЦК ХХК нь үнэт цаасыг анх удаа олон нийтэд санал болгох (IPO), урвуу нэгдэл хийх (RTO), бондын арилжаа хийх зэрэг арвин туршлагатай хамт олон юм.

Үндсэн андеррайтер Стандарт инвестмент ҮЦК ХХК нь 2023 оны 4 сарын 24-ний өдөр 23/06 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан.

Тус гэрээний хүрээнд Үндсэн Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн зах зээлээс нээлттэй хүрээнд хөрөнгө татахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, , Үнэт

СЗХ 2023 сар 01 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-03-04

цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ийн бүртгэлийн журам болон нэмэлт хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, нэмэлт хувьцааг анхдагч зах зээлд байршуулж худалдах, Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чадавх дээр магадлан шинжилгээ хийхийг тусгасан байна. Үнэт цаас гаргагч нь Үндсэн Андеррайтерт энэхүү гэрээнд заасан үйлчилгээг гүйцэтгэхэд нь эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас санал болгосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд, шаардлага хангахуйц байдлаар гаргаж өгөх бөгөөд гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.

## 8.2. Туслах Андеррайтерийн компани

| ARD СЕКЮРИТИЗ ҮЦК | Ард Секюритиз ҮЦК ХХК |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9011472112 |
| Регистрийн дугаар | 2111063 |
| Үйл ажиллагааны чиглэл | Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад арилжаа |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Цэнтрал тауэр, 13-р давхар, 1303 тоот |
| Утас | +976 7707 8282 |
| Веб хуудас | www.ardsecurities.com |
| Цахим шуудан | info@ardsecurities.com |

Ард Секюритиз ҮЦК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компани бөгөөд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулж, харилцагчдадаа олон улсын жишигт нийцсэн, шинэ дэвшилтэт үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Ард Секюритиз ҮЦК ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдсан ба Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохих ёсны зөвшөөрлүүдийн дагуу брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад арилжаа гэх мэт санхүүгийн зуучлалын цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа Монгол Улсын ууган компани юм. Ард Секюритиз ҮЦК ХХК нь 150 мянга гаруй иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцох дансыг нээж, 20 гаруй аж ахуй нэгжид 100 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт татах болон нэгдэх, нийлэх үйл ажиллагаанд зуучлагчаар оролцоод байна.

Ард Секюритиз ҮЦК нь 2023 оны 2 сарын 13-ны өдөр 23/2 тоот Туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан байна. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагчид хөрөнгийн зах зээлээс нээлттэй хүрээнд хөрөнгө татахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна. Тус гэрээний хүрээнд Андеррайтер нь Компанийн санхүүгийн болон үйл

УЛААНБААТАР ХОТ АРД КРЕДИТ ББСБ ХК

ажиллагааны чадавх дээр магадлан шинжилгээ хийх, санхүүжилт татах хүрээнд Үнэт цаас гаргагчаас хэрэгтэй мэдээлэл, материалыг гаргуулан түүнд үндэслэн шаардлагатай тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг хийх, нээлттэй хүрээнд санхүүжилт татах буюу СЗХ болон Биржээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад Үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгөх, үүнтэй холбоотойгоор компанийн нэрийн өмнөөс СЗХ болон МХБ-тэй харилцах, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэх, гуравдагч талуудыг сонгоход болон тэдэнтэй үүсэх харилцаанд зөвлөгөө өгөх, боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, Үнэт цаас гаргагчийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргахтай холбоотой хууль тогтоомж, журмыг мөрдөх тал дээр зөвлөмж өгөх үүрэг хүлээсэн. Тус гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Андеррайтерт энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын эх хувь буюу баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд, Андеррайтерийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах, мөн Андеррайтераас үзүүлэх үйлчилгээний чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

СЗХ 2023.09.01 өдөр БҮРТГЭВ № 01

2023-09-04 БҮРТГЭВ-02

## 8.3. Аудитын компани

| GrantThornton | Грант Торнтон Аудит ХХК |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9018001038 |
| Регистрийн дугаар | 2577542 |
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа |
| Хаяг | Далай тауэр, 9 давхар, Юнэско гудамж - 31, Сүхбаатар дүүрэг, 1 хороо Улаанбаатар 14230 |
| Утас | +976 7011 0744, +976 7011 0799 |
| Веб хуудас | http://www.grantthornton.mn |
| Цахим шуудан | info@mn.gt.com |

Грант Торнтон Монгол нь Грант Торнтон Интернэшнл гишүүн байгууллага бөгөөд Монгол дахь үйл ажиллагаагаа Улаанбаатар хот дахь суурин төлөөлөгчийн газраараа дамжуулан хэрэгжүүлдэг. Олон улсын болон орон нутгийн туршлагатай Грант Торнтоны мэргэжилтнүүд дээд түвшний аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, олон улсын болон орон нутгийн байгууллагууд, үндэсний болон арилжааны банкнуудад тэдний өндөр хүлээлтэд нийцсэн мэргэжлийн өндөр стандартын дагуу аудит, татварын болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Грант Торнтон Аудит ХХК нь 2022 оны 9 сарын 19-ний өдөр Үнэт цаас гаргагчтай 2022/41 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна. Тус аудитын үйлчилгээ гэрээний хүрээнд Ард Кредитын 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, аудиторын тайлан гаргах болон мөн хураангуй санхүүгийн тайланд дүгнэлт гаргах үйлчилгээг үнэт цаас гаргагчид үзүүлэхээр тусгасан байна. Гэрээний хүрээнд Аудитын компани нь аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах үүрэг хүлээсэн байна. Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Аудитын компанид энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд аудитын фирмийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэг хүлээсэн байна.

УЛААНБААТАР ХОТ ARD АРД КРЕДИТ ББСБ ХК 9023081344 5459567

## 8.4. Хуулийн фирм

| SNOW HILL | Сноу Хилл Консалтанси ХХН |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9022003117 |
| Регистрийн дугаар | 6593879 |
| Үйл ажиллагааны чиглэл | Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ардчиллын Өргөө, 6 давхар |
| Утас | +976 7711 8193 |
| Веб хуудас | www.snowhill.mn |
| Цахим шуудан | info@snowhill.mn |

Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН нь 2020 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 17 хуульч, 15 өмгөөлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий 12 хуульч, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх бүхий 2 хуульч, Татварын итгэмжлэгдсэн болон Мэргэшсэн нягтлан бодогч, санхүү бүртгэлийн зөвлөх 3, хятад, англи, орос, герман болон япон хэлээр мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай 30 гаруй хуульч, эрх зүйчдээс бүрдсэн томоохон хуулийн фирмүүдийн нэг юм. Дан ганц бизнесийн зөвлөх үйлчилгээ төдийгүй хуулийн төсөл боловсруулах, гадны санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж, дотоодын болон олон улсын шүүхийн болон арбитрын хэргүүдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Тус нөхөрлөл нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 1 сарын 27-ны өдөр 24 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэн ажиллаж байна.

Сноу Хилл нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2023 оны 2 сарын 10-ны өдрийн S-35/23 тоот Хууль зүйн үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр, олгосон эрх, зааварчилгааны дагуу олон нийтэд нээлттэй нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт гаргахаар ажиллаж байгаа болно. Үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журмын дагуу хууль зүйн дүгнэлт гаргахдаа Нөхөрлөл нь үйлчлүүлэгчээс ирүүлсэн баримт бичгийг бүрэн судалж, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гаргах, төрийн байгууллагуудаас лавлагаа, тодорхойлолт авах, бусад мэргэжлийн байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах бөгөөд үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгыг хянаж тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах үүрэгтэй. Үнэт цаас гаргагч нь нөхөрлөлд энэхүү гэрээнд

заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд нөхөрлөлийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэгтэй.

**Үнэт цаас гаргагч**

"Ард Кредит ББСБ" ХК

Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр барилгын 13 давхар, 1313 тоот

| | | |
|---|---|---|
| **ТУЗ-ийн дарга** | **Гүйцэтгэх захирал** | **Ерөнхий нягтлан бодогч** |
| Овог нэр: Ч.Ганзориг | Овог нэр: Г.Тэлмэн | Овог нэр: Х.Цэрэннадмид |
| Гарын үсэг.................................. (Тамга/ тэмдэг) | Гарын үсэг.................................. (Тамга/ тэмдэг) | Гарын үсэг.................................. (Тамга/ тэмдэг) |

| | |
|---|---|
| **Үндсэн андеррайтер** | **Туслах андеррайтер** |
| "Стандарт Инвестмент ҮЦК" ХХК | "Ард Секюритиз ҮЦК" ХХК |
| Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Туул голын гудамж, Автохаб төв, 1-р давхар | Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр барилгын 13 давхар, 1303 тоот |
| **Гүйцэтгэх захирал** | **Гүйцэтгэх захирал** |
| Овог нэр: З.Төрболд | Овог нэр: Ц.Бархас |
| Гарын үсэг.................................. (Тамга/ тэмдэг) | Гарын үсэг.................................. (Тамга/ тэмдэг) |